

ШИНЭ СӨЛТ

ЭДИЙН ЗАСГИЙН ТӨРӨЛЖИЛТ, ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СЭТГҮҮЛ

2022 ОН. 11 САР. ТУСГАЙ ДУГААР

**ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ
ЖААХАН
ДЭМЖИХЭД П
ӨӨРЧЛӨЛТ
АВЧИРНА**



8658000123718

ЦАГ НЬ ИРЛЭЭ
7 НҮҮРТ



Б.ЛАКШМИ: АЖ АХУЙ
ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДЭД
ДЭМЖЛЭГ ЧУХАЛ



11 НҮҮРТ

- 16 Яагаад ногоон эдийн засаг гэж
- 24 Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн тэгш бус байдлыг халах нь
- 26 Б.Оюунгэрэл: Монгол эмэгтэйчүүд илүү эрх хүсээгүй
- 33 Б.Эрдэнэдэлгэр: Нийт зээлийн багцын 48 хувийг ЖДБ-ийн зээлд, үүнийхээ 51 хувийг эмэгтэй бизнес эрхлэгчдэд олгосон байна
- 37 Ш.Ариунаа: Аль ч хэсэгт эмэгтэйчүүдийн оролцоо чухал
- 40 Б.Оргио: Жижиг, дунд бизнесүүд эдийн засгийн гол эргэлт
- 52 Б.Оюун-Ундрах: Итгэлцлийн үндсэн дээр зээл олгодог баймаар байна
- 55 Малчин хүний хувьд нутгийн брэнд хөгжүүлэх бизнестэй болохыг их хүсдэг

ДОТОР НҮҮРТ



Т.Энхбаяр:

Жендэр хэн нэгэнд давуу тал олгох арга хэрэгсэл биш, тэгш бус байдлыг тэгш болгох асуудал
18 НҮҮРТ



А.Солонго:

Эмэгтэй бизнес эрхлэгчдэд тэгш боломж, адил түвшний гараа хэрэгтэй
30 НҮҮРТ



Н.Амгалан-Эрдэнэ:

Монголд бизнес эрхлэнэ гэдэг шийтгүүлж байгаа мэт санагддаг
43 НҮҮРТ



Ногоон үйлдвэрлэгч

48 НҮҮРТ

ДИЗАЙНЕР:
Б.Ариунаа

Борлуулах цэгүүд:
Интерном,
Номин
супермаркет

И-МЭЙЛ ХАЯГ:
shineusult2018@gmail.com

УТАС:
86800598
88006228

FB ХАЯГ:
Agronews.mn

ВЭБ САЙТ:
www.agronews.mn
www.agroshop.mn

ХАЯГ:
Сүхбаатар дүүрэг
IX хороо, "Citius"
оффис, 5 давхар
503 тоот



АЖЛЫН ТУРШЛАГА:

2000-2010 он “Өнөөдөр” сонины Эдийн засаг, бизнесийн мэдээллийн албаны сэтгүүлч, албаны дарга.

2011-2017 он “Mongolian Economy” сэтгүүлийг үүсгэн байгуулалцаж, Орлогч эрхлэгчээр ажилласан.

2019 оноос эдийн засгийн төрөлжилт, тогтвортой хөгжлийн “Шинэ өсөлт” сэтгүүлийг үүсгэн байгуулж, ерөнхий эрхлэгчээр.

2020 оноос санхүүгийн зах зээлийн “Financial Inclusion” сэтгүүлийн ерөнхий эрхлэгчээр тус тус ажиллаж байна.

ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС

Эдийн засгийн төрөлжилт, тогтвортой хөгжлийн “Шинэ өсөлт” сэтгүүл Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвтэй хамтран жил бүрийн арваннэгдүгээр сарын 19-нд болдог Олон улсын аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн өдрийг тохиолдуулан эмэгтэйчүүдийн Тусгай дугаар эрхлэн гаргаж, таны гар дээр тавьж байгаадаа баяртай байна.

Бид энэ удаагийн сэтгүүлдээ эмэгтэйчүүдийн эдийн засаг, бизнес, шийдвэр гаргах түвшний оролцоог хэрхэн нэмэгдүүлэх боломжтой. Уг орчин нөхцөлийг сайжруулах хууль эрх зүйн орчин хэр бүрдсэн, аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүд болон банк санхүүгийн салбарынхан хөгжлийн ирээдүй болсон ногоон эдийн засаг, ногоон санхүүжилт, ногоон бизнесийг хэрхэн дэмжиж байгаа талаарх салбар бүрийн зочдын дуу хоолойг хүргэхийг чухалчиллаа.

Мөн эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоо, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр Монголын холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын удирдлагуудын байр суурийг хүргэхээс гадна аж ахуй эрхлэгч олон мянган эмэгтэйчүүдийн төлөөлөл болж ихэнхдээ хог хаягдалгүй ногоон бизнес, эрүүл эко хүнс, амттан үйлдвэрлэгч, гар урлаач зэрэг сонирхолтой бизнес эрхлэгч бүсгүйчүүдийг сонгон оруулав. Түүнчлэн малчин эмэгтэйчүүдийн төлөөлөл болж Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын иргэн Д.Мөнгөнхун ч малчин эмэгтэйчүүд орон нутагтаа ямар бизнес хийж, хэрхэн хөгжиж болох талаар өгүүлэв.

Ногоон эдийн засаг, ногоон хөгжил, ногоон санхүүжилт, эмэгтэйчүүдийн эдийн засаг, санхүүгийн чадавх, шийдвэр гаргах түвшний оролцоо улам сайжирч хөгжих болтугай.

Ерөнхий эрхлэгч **И.ОТГОНЖАРГАЛ**

ЭМЭГТЭЙЧҮҮД

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ЖААХАН ДЭМЖИХЭД Л ӨӨРЧЛӨЛТ АВЧИРНА

Цаг нь ирлээ

Д.МӨНХЧИМЭГ

“Одоо л бидний цаг. Миний ээжид хүн бүр хоёрхон сонголт байгааг хэлж байсан. Нэг бол сувилагч, үгүй бол багш болно гэж. Иймэрхүү хаалт хязгаар одоо хамаагүй багассан. Хэрвээ бид жинхэнэ асуудлуудыг олж харвал тэдгээрийг шийдвэрлэж чадна” хэмээн “Facebook” компанийн гүйцэтгэх захирал Шэйрил Сандберг “Harvard Business Review”-д өгсөн ярилцлагынхаа үеэр хэлжээ.

Эдүгээ дэлхийн хүн ам найман тэрбумд хүрлээ. Энэ онцгой мөчид бид дэндүү олон ур чадварыг ашиглалгүй өнгөрч байгаагаа хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Эмэгтэйчүүд бизнест



эрчүүдтэй эн тэнцүү оролцвол дэлхийн эдийн засагт 5-6 их наяд ам.доллартай тэнцэхүйц хувь нэмэр оруулна гэж судлаачид үздэг. Ялангуяа цар тахал, дайн дажин, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй хямрал нүүрлэсэн өнөө үед эдийн засгаа сэргээхийн тулд дөрвөн тэрбум эмэгтэйн нөөц бололцоог дээд зэргээр ашиглах нь чухал. Эмэгтэйчүүд хямралын менежментийг илүү сайн хийдгийг Герман, Шинэ Зеланд, Норвеги зэрэг улс цар тахлын үед хэрэгжүүлсэн амжилттай бодлогоороо харуулсан.

Дэлхий даяар эмэгтэйчүүдийн боловсрол дээшилж, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж байгаа ч шийдвэр гаргах түвшинд тэдний оролцоо сул хэвээр. НҮБ-ын гишүүн 193 орноос ердөө 15 улсын төр, засгийн тэргүүнээр эмэгтэй хүн сонгогдон ажиллаж байна. Мөн олон улсын хэмжээнд парламент дахь дөрвөн суудал тутмын нэг нь эмэгтэйчүүдэд ногдож байгаа бол гурван бизнес тутмын нэгийг эмэгтэй хүн эзэмшиж буй.

Тэгвэл Монгол Улсын хүн амын 51 хувийг бүрдүүлж байгаа эмэгтэйчүүд мэдлэг, боловсрол, ажлын туршлагаараа хаа ч гологдохооргүй болжээ. Үндэсний статистикийн хорооны мэдээллээс үзэхэд, дээд боловсролын сургалтын байгууллагуудад 149 мянга орчим оюутан суралцаж байгаагийн 61 хувь нь эмэгтэйчүүд. Мөн ажиллах хүчний 47 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байгаа нь дэлхийн дунджаас хавьгүй өндөр үзүүлэлт юм.

Гэвч УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл ердөө 17 хувь буюу дэлхийн дунджаас найман нэгж хувиар доогуур байна. Олон улсын парламентын холбооноос сар бүр шинэчлэн гаргадаг Парламент дахь эмэгтэйчүүдийн жагсаалтаас үзэхэд Монгол Улс 185 орноос 135 дугаарт эрэмбэлэгджээ. Мөн Монгол Улсад бүртгэлтэй 147 мянга гаруй аж ахуйн нэгж байгаагийн 37 хувь нь л эмэгтэй захиралтай.

Эмэгтэйчүүд шийдвэр гаргах

түвшинд ороолцоогоо нэмэгдүүлбэл улс орныхоо хөгжил, эдийн засгийн өсөлтөд даацтай хувь нэмэр оруулахуйц мэдлэг, туршлагатай байгааг бид харж байна. Тэдэнд зөвхөн жаахан дэмжлэг л хэрэгтэй.

ЭМЭГТЭЙЧҮҮДЭД ЦАГ ГАРГАЖ ӨГЧ...

Амжилттай бизнес эрхлэгчдийн олонх нь 30-49 насандаа бизнесээ эхлүүлсэн байдаг. Харин эмэгтэйчүүдэнэнасаа хүүхэд гаргах, асрахаас эхлээд ар гэрийн ажилд дарагдан өнгөрөөдөг нь нууц биш. Үндэсний статистикийн хорооны Цаг ашиглалтын судалгаанаас үзэхэд эмэгтэйчүүд гэрийн ажил, хүүхэд асрах мэтийн хөлсгүй хөдөлмөрт өдөр бүр дунджаар таван цаг зарцуулж байна. Харин эрчүүд тэднээс 2.5 дахин бага буюу хоёр цагийг л хөлсгүй хөдөлмөрт зориулж байгаа юм.

Хэрэв эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөрийг мөнгөөр үнэлбэл ДНБ-ий 10-39 хувьд хүрэх тойм тооцоо бий. Үүнийг хэрхэн бүтээмж болгож, эдийн засгийн өсөлтөө хурдасгах вэ? Ихэнх хөгжингүй оронд сургуулиуд бүтэн цагаар хичээллэж, гэрийн даалгавар бага өгдөг. Монголд ч ийм жишиг тогтоовол маш олон эмэгтэй цаг заваа цалинтай ажил хийх, бизнес эрхлэх, улс төрд идэвхтэй оролцоход зориулж болох юм.

Мөн айл өрхийн хэмжээнд эхнэр, нөхөр гэрийн ажлаа хуваалцаж хийвэл эмэгтэйчүүд илүү амжилтад хүрэх боломжтой. Амжилттай эр хүний ард сайн эхнэр байдаг гэдэгчлэн амжилттай эмэгтэйн арыг ч сайн нөхөр даах бус уу.

УРАМ ЗОРИГ ХАЙРЛАЖ...

Эмэгтэйчүүд улс төрд орох, эсвэл бизнес эрхлэхээс айх, эмээх, өөртөө итгэлтэй биш байх нь элбэг. Энэ нь эмэгтэйчүүд нэн тэргүүнд гэрийн сайн эзэгтэй байж, нөхрөө халамжилж, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх ёстой. Эмэгтэй

хүн улстөрч, бизнес эрхлэгч болж чадахгүй гэсэн хэвшмэл ойлголттой холбоотой. Үүнийг бид эргэн тойрноосоо байнга авдаг. Зурагтаа асаагаад мэдээ үзэхэд л ямар хүмүүс харагддаг билээ? Улс төр, эдийн засаг, бизнесийн талаар ихэвчлэн эрчүүд ярьдаг шүү дээ.

Ажил хэргээрээ амжилттай яваа эмэгтэйчүүд цөөнгүй ч даруу төлөв байдлаасаа болж олны өмнө, хэвлэл мэдээллээр ярихаас цааргалдаг тал бий. Хэрэв Та тэдний нэг бол амжилтын түүхээ заавал хуваалцаж байгаарай. Таны түүх охид, эмэгтэйчүүдэд урам зориг хайрлаж, амьдралдаа зөв сонголт хийхэд нь тусална гэдэгт итгээрэй.

ХӨРӨНГӨ ОРУУЛЖ...

Эмэгтэй бизнес эрхлэгчид, улстөрчид санхүүжилтийн олон асуудал, бэрхшээлтэй нүүр тулдаг. Наад захын жишээ гэвэл үл хөдлөх хөрөнгө ихэвчлэн эрэгтэйчүүдийн нэр дээр байдгаас эмэгтэйчүүд банкнаас зээл авч, бизнес эхлүүлэхэд барьцаа хөрөнгө дутдаг. Үндэсний статистикийн хорооноос 2018 онд хийсэн “Хөрөнгийн эзэмшил, аж ахуй эрхлэлтийг жен-дэрийн төлөв байдлаар тодор-хойлох нь” судалгааны үр дүнгээс үзэхэд эрчүүд үндсэн сууцаа эзэмших тохиолдол эмэгтэйчүүдээс хоёр дахин их байгаа юм.

Бичил болон жижиг аж ахуйн нэгжүүдийн дийлэнхийг эмэгтэйчүүд удирддаг боловч Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас өгсөн зээл эрэгтэйчүүдэд илүүтэй хүрчээ. Мөн банк, санхүүгийн байгууллагуудын олгосон зээлийн мэдээллийг тайлж уншвал эрэгтэй-чүүдэд эмэгтэйчүүдээс хавьгүй их хэмжээний зээл итгэж, олгодог байгаа юм. Гэтэл зээлийн эргэн төлөлт дээр эмэгтэйчүүд илүү хариуцлагатай ханддагийг судалгаа харуулсан байна.

Энэ нь зөвхөн Монголд биш, дэлхий даяар байдаг асуудал. Тиймээс Засгийн газрууд эмэгтэй

ЭМЭГТЭЙЧҮҮД

Хэрэв эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөрийг мөнгөөр үнэлбэл

ДНБ-ий 10-39

хувьд хүрэх тойм тооцоо бий.

бизнес эрхлэгчдээ эхнээс нь дэмжих санхүүжилтийн механизм нэвтрүүлж байна. Ирландын Эмэгтэй бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадварын гарааны сан, Австралийн Эмэгтэй үүсгэн байгуулагчдыг идэвхжүүлэх санаачилга зэргийг энд дурдаж болно.

Ташрамд дурдахад, эмэгтэйчүү-дийн үүсгэн байгуулсан бизнес урт хугацаанд илүүүрашигтай ажиллаж, өндөр орлого олдгийг судалгаа харуулжээ. Тодруулбал, нэг ам.долларын хөрөнгө оруулалтад ногдох орлогоороо эмэгтэйчүүдийн бизнес эрэгтэйчүүдийнхээс хоёр дахин давдаг байна. Гэсэн ч хөрөнгө оруулагчид эрэгтэйчүүдтэй хамтарч ажиллахыг илүүд үздэг нь хувь заяаны егөөдөл гэлтэй.

БИЗНЕСЭЭ ӨРГӨЖҮҮЛЭХ БОЛОМЖ ОЛГОЖ...

Монголд бүртгэлтэй гурван аж ахуйн нэгж тутмын нэг нь эмэгтэй захиралтай байгааг дээр дурдсан. Үүнийг задалж үзвэл бичил, жижиг аж ахуйн нэгж дэх эмэгтэйчүүдийн оролцоо эрчүүдтэй ойролцоо боловч борлуулалтын орлого, ажилтны тоо нэмэгдэх тусам эрэг-тэйчүүд давамгайлж байна. Тухайл-бал, 200-гаас дээш ажилтантай аж ахуйн нэгжийн 71 хувь нь эрэгтэй захиралтай бөгөөд топ 100 аж ахуйн нэгжийн 24 нь л эмэгтэй удирдлагатай байна.

Эмэгтэйчүүд бичил, жижиг бизнес эхлүүлээ ч түүнийгээ өргөжүүлэх тал дээр бэлтгэл, туршлага муутай байдаг нь үүнд нөлөөлдөг. Тиймээс бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд дараагийн шатанд гарах дэмжлэг хэрэгтэй. Дэлхий даяар энэ асуудлыг шийдэхийн тулд сургалт, зөвлөх үйлчилгээ, нетворкинг үүсгэх эвентүүдийг хийх туршлага амжилттай хэрэгжиж байна. Тухайлбал, Канадын Эмэгтэй аж ахуй эрхлэгчдийн мэдлэгийн төв (WKN) эмэгтэйчүүдийг дэмжих чиглэлээр ажилладаг 250 гаруй байгууллагын сүлжээгээр

дамжуулан 100 мянга гаруй бизнес эрхлэгчийг сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээгээр хангажээ.

ГАНЦ ЭМЭГТЭЙН ХУВЬ НЭМЭР ГАНЦААРДАХГҮЙ...

Америкийн автор, олны танил, нийгмийн төлөө бизнес эрхлэгч Венди Даймонд Хондурас улсад бага орлоготой эмэгтэйчүүдэд би-чил зээл олгох сангийн ажилд сайн дураараа зүтгэж байхдаа эмэгтэй бизнес эрхлэгчдийн амжилтыг тэмдэглэж, шинэ шатад гаргахад зориулсан үйл ажиллагаа хэрэгтэйг ойлгожээ. Түүний санаачилгаар Эмэгтэй ажахуй эрхлэгчдийн өдрийг анх 2014 оны арваннэгдүгээр сарын 19-нд НҮБ зохион байгуулж, жил бүрийн мөн өдөр уламжлал болгон тэмдэглэх болсон байна.

“Дэлхий даяар эмэгтэйчүүд доогуур үнэлэгдэж, бага цалин авч, төлөөлөл цөөтэй, санхүүжилт багатай байсаар ирсэн түүхтэй. Одоо ч тэр хэвээр байна” хэмээн Венди Даймонд “Forbes” сэтгүүлд өгсөн ярилцлагадаа онцолжээ. Тиймээс дөрвөн тэрбум эмэгтэйг хүчирхэгжүүлэх замаар 250 сая нэн ядуу охидод итгэл найдвар өгөх зорилгоор энэ өдрийг санаачилсан байна.

Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэг-дүүлэх нь ядуурлыг бууруулж, тогтвортой хөгжилд хүрэхэд онцгой хувь нэмэр оруулахаас гадна ногоон эдийн засагт ч сайнаар нөлөөлөхийг судлаачид сануулдаг. Учир нь, эмэгтэйчүүд байгаль орчинд ээлтэй ханддаг бөгөөд эрчүүдтэй харьцуулахад хавьгүй бага экологийн ул мөр үлдээдгийг нотолжээ.

Энэ бүхнээс үзэхэд шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь айл өрхөөс эхлээд улс орон, дэлхий нийтэд эерэг өөрчлөлт авчрахаар байгаа юм. Тэдэнд жаахан л дэмжлэг хэрэгтэй. ■



Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадвар судалгааны төвийн захирал Б.Лакшми

Б.Лакшми: Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдэд дэмжлэг чухал

И.ОТГОНЖАРГАЛ

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадвар судалгааны төвийн захирал Б.Лакшмитай жил бүрийн аваннэгдүгээр сарын 19-нд болдог “Олон улсын аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүд”-ийн өдрийг тохиолдуулан ярилцлаа. Эдийн засгийн судалгааны байгууллагыг олон жил удирдаж, аймгуудын өрсөлдөх чадварын судалгаа, ногоон эдийн засаг, эмэгтэй бизнес эрхлэгчдийн талаар бодлогын төрөл бүрийн судалгаа хийж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлж ирсэн тэрбээр энэ сарын 18-нд дээрх аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн олон улсын өдрийг тохиолдуулан Монголын бичил, жижиг, дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн тулгамдсан асуудлыг олон нийтийн анхаарлын төвд аваачих зорилгоор “Жендерийн мэдрэмжтэй уур амьсгалын санхүүжилт” сэдэвт хэлэлцүүлэг хийж байгаа юм. Ингээд Б.Лакшмитай бичил, жижиг, дунд аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоо, эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшний оролцоог нэмэгдүүлэх боломжийн талаар судалгааны бодит тоо баримт түшиглэсэн сонирхолтой ярилцлага өрнүүлээ. ►

“Олон улсын аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн өдөр”-ийг тохиолдуулан Монголд эмэгтэйчүүдийн эдийн засгийн асуудлаар хэлэлцүүлэг хийхийн ач холбогдол юу вэ? Жил бүрийн арваннэгдүгээр сарын 19-нд Олон улсын аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн өдөр гэж болдог. Сүүлийн жилүүдэд эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоо хийгээд аж ахуй эрхлэлттэй холбоотой судалгаа их хийгддэг боллоо. Үүнд мэдээж цар тахлын асуудал хүч нэмэгдүүлж өгсөн байх. Монголд НҮБ, Азийн сан зэрэг байгууллагуудын цар тахлын үр нөлөөний судалгаануудыг харахад цар тахалд хамгийн ихээр өртсөн бүлэг эмэгтэйчүүд байсан. Хөл хорионы үед хүүхдүүд цахим хичээл үзэхтэй холбоотой Ногоон бодлогоо дараагийн шатанд гаргаж хөгжүүлэх шаардлага тулгамдаж байна. Ногоон гэдэг чинь ерөнхий нэр томьёо шүү дээ. Ногоон дотроо юу юуг оруулж, яаж хөгжүүлэх вэ гэдэг бодлого чухал. харж хандах хүнгүй бол ээжүүд, эмэгтэйчүүд гэртээ цаг гаргахаас аргагүй болсон.Тэд ажлаасаа цалингүй чөлөө авах, ажлын цагаа багасгаж цар тахлын үед гэр бүлийнхнээ харж хандахад илүү цагийг зарцуулах болсон нь судалгаагаар гарсан байна. Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн хувьд мөн ялгаагүй ажил бизнестээ зарцуулах цагаа багасгасан. Ер нь судалгаагаар эмэгтэйчүүд аав ээжээ асрах, хүүхдийнхээ боловсролд илүү мөнгө, цаг зарцуулдаг гэсэн үр дүн гардаг л даа. Түүнчлэн бичил, жижиг, дунд бизнесийн салбарыг орон бүрт онцолж үздэг. Яагаад гэвэл ажлын байр бий болгодог салбар. Мөн жижиг гэдэг утгаараа янз бүрийн өөрчлөлтийг хурдацтай хийх боломжтой гэж үздэг. Тиймээс бичил, жижиг, дунд үйлдвэрийг бэхжүүлж хөгжүүлэх асуудал чухал гэдгийг олон улсад олон жилийн өмнөөс онцолж ирсэн. Монгол Улсын хувьд энэ асуудлыг аваад үзэхэд бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн ихэнх хувийг эмэгтэйчүүд бүрдүүлдэг болохоор эмэгтэй аж ахуй эрхлэгчийн асуудалд анхаарал хандуулж, чухалчилж үзэхээс аргагүй. Тиймээс манай Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс энэ удаагийн олон улсын өдрөөр эмэгтэй аж ахуй эрхлэгчдийн холбогдолтой хэлэлцүүлэг зохион байгуулж, хүмүүсийн анхаарлын төвд оруулах нь зөв гэж үзсэн. -Эмэгтэйчүүдийн хурлын сэдэв шинэлэг санагдлаа. “Жендерийн мэдрэмжтэй уур амьсгалын санхүүжилт” гээд. Сүүлийн үед олон улсад хүчтэй яригдаж байгаа ногоон санхүүжилтийн хүрээнд эмэгтэй бизнес

эрхлэгчдийг дэмжих чиглэлээр багагүй зүйл хийж эхэлж байна. Танай хурлын сэдэв бас үүн рүү чиглэж байгаа юу? Олон улсын санхүүгийн чиг хандлага байгаль орчинд ээлтэй ногоон санхүүжилтийг дэмжих бодлого барьж байна. Манай улс 2014 оны зургаадугаар сард ногоон хөгжлийн бодлогоо боловсруулсан. Одоо харахад ногоон бодлого нь төдийлэн сайн явахгүй байна. Эрчим хүчний хэмнэлт гээд бага зэрэг ярьж байна. Байгаль орчинд ээлтэй аж ахуйн үйл ажиллагаа, үйлдвэрлэл явуулахыг ногоон гэдэг. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой шинэ төрлийн цар тахал хүртэл гарч байна. Тийм болохоор ногоон бодлогоо дараагийн шатанд гаргаж хөгжүүлэх шаардлага тулгамдаж байна. Ногоон гэдэг чинь ерөнхий нэр томьёо шүү дээ. Ногоон дотроо юуг оруулж, яаж хөгжүүлэх вэ гэдэг бодлого чухал. Зөвхөн эрчим хүчний хэмнэлтийг оруулах эсвэл агаарын бохирдлоо хэрхэн бууруулж, нүүрснээсээ салах, нүүрсээ дахин боловсруулж, байгаль орчинд ээлтэй зуухыг бий болгох уу, гээд асуудлууд бий. Монгол Улс уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой олон улсын санаачлагуудад идэвхитэй оролцдог. Одоо хүртэл КОП 27 болж байгаа. Эдгээр санаачлагуудаар бид бас тодорхой үүрэг хариуцлага хүлээдэг, жишээ нь хүлэмжийн хий бууруулах. Энэ нь цаашид салбаруудыг ногоон болгож хөгжүүлэх боломжийг бий болгож байгаа юм. Мөн үүнтэй холбоотой олон нэр төрлийн бүтээгдэхүүн бий болно. Аж ахуй эрхлэгчдийн хувьд ч ялгаагүй. Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа эрхлэх шаадлага бий. Том бодлогоо харж хөгжих ёстой. Энэ үүднээсээ аж ахуй эрхлэгч бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хооронд нь холбож, өсөж хөгжих боломж тал дээр мэдээлэлтэй болгох арга хэмжээг хийхийг зорьж байна. Манайд бизнесийн салбар дахь жендерийн ангилсан мэдээллүүд байхгүй хэдий ч судалгаагаар жижиг, дунд бизнесийн салбарын ихэнх хувийг эмэгтэйчүүд эзэлдэг. Харин бизнес томроод ирэхээр эмэгтэйчүүдийн оролцоо багасдаг тал ажиглагдсан. Тэгэхээр аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүд байнгын л бичил, жижиг, дунд ангилалдаа байгаад байх уу. Үүнтэй холбоотой хөшүүргүүд болон бодлогын арга хэмжээг Монгол Улсад бий болгох шаардлагатай учраас энэ удаагийн хэлэлцүүлгийг хийлээ. -Эмэгтэйчүүд байгалийнхаа хуулийн дагуу хүүхэд гаргана, ээжийн үүргийг илүү үүрдэг ч аж ахуй эрхлэх, сурч боловсрох, хөгжиж дэвших талаар илүү идэвх зүтгэлтэй байдаг. Тэгвэл энэ чиглэлд олон улсын судалгаа хэр байдаг юм бол? Олон улсын түвшинд гурав, дөрвөн жилийн өмнө “Коммерц банк” нэг судалгаа хийсэн байсан. Тэр судалгаагаар эмэгтэйчүүд олж байгаа ►



орлогоосоо хүүхдүүдийнхээ боловсролд илүү хөрөнгө оруулдаг, аав ээжийгээ харж хандахдаа ч гэсэн санхүүгийн дэмжлэгүүдийг илүү өгдөг гэдэг үүднээс тэдний эдийн засагт оруулж байгаа хувь нэмэр чухал юм гэдгийг онцолсон байсан. Мөн Үндэсний статистикийн газраас Цаг ашиглалтын судалгааг хоёр жил тутамд хийдэг. Хамгийн сүүлийн судалгаанаас харахад эмэгтэйчүүд хөлсгүй хөдөлмөр буюу гэр орны ажил хийх, хүүхэд харах хоол ундаа хийхэд өдөрт 4.5 цаг зарцуулдаг гэсэн тооцоо гарсан байсан. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр эмэгтэй хүмүүс бусадтай адилхан өдөрт найман цаг ажиллачихаад гэртээ ирэхэд ар гэрийн ажлын ачаалал нуруун дээр нь байдаг. Энэ нь эмэгтэйчүүдэд зориулсан давхар бодлогын арга хэмжээ авах хэрэгтэйг харуулж байгаа болов уу.

Үндэсний статистикийн хороо, АХБ хамтарч 2019 онд Монгол, Гүрж, Молдав зэрэг орныг хамруулсан судалгаа хийсэн. Энэ судалгаагаар ихэнх өмч хөрөнгийг эрэгтэйчүүд эзэмшдэг. Ингэснээр эмэгтэй аж ахуй эрхлэгчийн хувьд барьцаа хөрөнгө хангалттай хэмжээнд байдаггүйгээс бизнесээ өргөжүүлж хөгжүүлэхэд саадтай байдаг тухай дурдагдсан байсан.

Амралтын өдрийн ачаалал, хөлсгүй хөдөлмөрийн 4,5 цагийг задлаад үзэхээр бичил, жижиг, дунд бизнесийн салбарт ажиллаж байгаа эмэгтэйчүүд өөрсдийгөө хөгжүүлэх, сургалтад хамрагдах, мэдээлэл авах зэрэгт цаг гаргаж чаддаггүй гэсэн байсан. Тэгэхээр эмэгтэйчүүдийн бизнес бичил, жижиг дунд хэвээр үйл ажиллагаа явуулаад байгаагийн нэг шалтгаан нь энэ. Тиймээс эмэгтэй бизнес эрхлэгчдийн сургалтад хамрагдаж, нетворкинг үүсгэх, нэг нэгнийхээ бизнесийг дэмжих, мэдээлэл авах гэх мэт

боломжуудаар нь хангаж өгөх шаардлага бий гэсэн үг. Тэгэхгүй бол зөвхөн өөрийн бизнесээ, өдөр тутмын хөлсгүй ажилтайгаа хийгээд яваад байвал эмэгтэйчүүдийн эдийн засгийн болон шийдвэр гаргах түвшний оролцоо яаж нэмэгдэх билээ.

-Гэтэл орон нутагт эмэгтэй аж ахуй эрхлэгчийн асуудал бүр л хүнд байдаг байх.

Орон нутагт нөхцөл байдал хотынхоос бүр өөр байгаа. Орон нутагт эрэгтэйчүүдийн өмчлөл хотыхоос илүү өндөр байдаг. Мөн бичил, жижиг, гарааны бизнес эхэлж байгаа нь бүр их байдаг. Орон нутгийн эмэгтэй бизнес эрхлэгчдээс судалгаа авч явахад төрийн худалдан авалт, тендерт ихэнхдээ эрчүүд ордог. Эмэгтэйчүүд авч чаддаггүйгэдэг. Түүнчлэн “Сайн яваа эрэгтэй хүний ард эмэгтэй хүн байдаг” гэж үг ч бий. Эмэгтэйчүүд эр хүний ар талыг баттай даадаг. Өөрсдийгөө байнга хойш тавих хандлагатай байдаг учраас ялангуяа бичил, жижиг, дунд бизнесийн салбарт хүчээ сорьж яваа эмэгтэйчүүдэд хууль эрх зүйн болоод эдийн засгийн бусад дэмжлэг чухал гэж яриад байгаа юм.

-Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн барьсан. Энэ асуудлаар өнгөрсөн наймдугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор чуулган хүртэл хийсэн. Та уг хуулийн төслийн ажлын хэсгийн Нарийн бичгийн даргаар ажилласан хүний хувьд Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн тухай хууль яагаад хэрэгтэй гэж үзэж байна вэ?

Хуулийн ач холбогдол юунд байна вэ гэхээр нэгдүгээрт, эмэгтэй бизнес эрхлэгч гэж хэн бэ гэсэн тодорхойлолт бий болох юм. Тодорхойлолтод

ЭДИЙН ЗАСГИЙН ОРОЛЦОО

компанийн 51-ээс дээш хувийг эмэгтэйчүүд эзэмшдэг эсвэл компанийхаа тодорхой хувийг эмэгтэйчүүд эзэмшээд мөн гүйцэтгэх захирлыг нь эмэгтэй хүн байна гэсэн хоёр шалгуураар оруулж өгсөн. Эмэгтэй бизнес эрхлэгчийн ийм тодорхойлолт бий болсноор цаашид нэгдсэн ойлголттой болох, жендерийн ангилсан мэдээлэл бий болох, аж ахуй эрхлэгчид хэрхэн хөгжиж байгаа, жижиг, дунд үйлдвэрийн салбарын хэдэн хувийг бүрдүүлж байгаа гэсэн мэдээллийг



бий болгох боломжтой болно. Хоёрдугаарт, Хуульд төрийн худалдан авалт тендер зэрэг зүйлсийг зохион байгуулахад хуульд заасан эмэгтэй аж ахуй эрхлэгчийн тодорхойлолтын шалгуурыг хангаж байгаа эмэгтэйчүүдэд тодорхой хэмжээний хувийн квот өгөх саналыг оруулсан. Жишээ нь ЖДҮ-ийг дэмжих сангаас жил бүр зээл өгдөг. Тэрнийхээ 20-30 хувьд нь шалгуур хангасан эмэгтэйчүүдийн бизнес төслийг багтаах байдлаар тодорхой квот гаргаж болно. Мөн түүнчлэн төсвийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа бүтээгдэхүүн худалдаж авахад тодорхой хувийг нь эмэгтэй аж ахуй эрхлэгчдэд гэх байдлаар зохицуулдаг байх. Квот дээр хатуу тоо тавьж заагаагүй, нээлттэй үлдээсэн байгаа. Энэ нь төсөвт нэмэлт дарамт огт болохгүй. Хуваарилагдсан төсвийн тодорхой хувийг л эмэгтэйчүүдэд чиглүүлдэг байх тухай санаа юм. Гуравт,

хамтран хөгжих санааг оруулж өгсөн. Компани, хоршоо, нөхөрлөл хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа бол энэ дэмжлэг авах боломжтой.

Хуультай болох бас нэг шалтгаан нь Жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль. Энэ хууль 2011 онд батлагдсан. Уг хууль арван жил болсонтой холбоотой Жендэрийн үндэсний хорооноос үнэлгээ хийгдсэн байсан. Үнэлгээнээс харахад гол асуудал сүүлийн арван жилд бизнесийн орчин сайжирсан ч жендэрийн хувьд сайжраагүй гэсэн дүгнэлт гарсан. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр жендэрийн хувьд эмэгтэйчүүдийн ялгаатай байдлыг хангалттай хэмжээнд авч үзээгүйгээс болоод жендэрийн хувьд сайжраагүй гэж хуулийн үнэлгээ гарсан байна шүү дээ. Түүнчлэн манайд бизнесийн салбар дахь жендэрийн ангилсан мэдээлэл байхгүй байна. Үүнтэй холбоотой төрийн худалдан авалт дээр тодорхой давуу эрх эдлэх заалт заах боломжгүй. Яагаад гэхээр өнөөдөр хөгжлийн бэрхшээлтэй иргэн ч гэдэг юм уу тодорхой давуу эрх эдлэх заалтууд байдаг ч эмэгтэй бизнес эрхлэгчдийн асуудлыг тэр дотор оруулах боломжгүй байгаад байна гэсэн дүгнэлт гарсан байна лээ. Тэгэхээр энэ бүхэн хууль хэрэгтэйг хэлж өгч буй хэрэг.

-Хуультай болсноор гарах үр дүн юу байх вэ?

Монгол Улсын хувьд Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх хуулийг гаргаснаар ялангуяа эдийн засаг хүнд байгаа нөхцөлд зээлийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлэх, олон болгох боломж бий болно. Зээл л бол зээл гэж харахгүй. Олон төрлийн зээл бий болоод байна. Тухайлбал, ногоон зээл дотроо эрчим хүч хэмнэх, агаарын бохирдлыг бууруулах гэх мэт төслүүдэд хөнгөлөлттэй зээлүүд өгдөг. Энэ дотор эмэгтэйчүүдийн зээл гэсэн нэг төрөл орж ирж байгаа гэсэн үг. Монгол Улсад энэ санхүүгийн эх үүсвэрүүдийг татах боломжуудыг нэмэх асуудал байгаа юм.

Бодлогын орчинд ийм өөрчлөлт гарч байгаа нь богино хугацаанд өөрчлөлт гараад эмэгтэйчүүд том том бизнес эрхлэгч болно гэсэн ойлголт биш. Бодлогын авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ урт хугацаандаа үр дүнгээ өгдөг. Эмэгтэй бизнес эрхлэгч гэж хэн бэ гэдэг тодорхойлолт гарсантай холбоотой нэгдсэн ойлголттой болно, тодорхой мэдээллүүд нь гарч эхэлнэ. Цаашлаад санхүүгийн төрөлжсөн бүтээгдэхүүнүүдийн хөгжүүлэлт бий болно гээд олон үе шаттай ажлууд хийгдээд явах болохоор богино хугацаанд үр дүн гарна гэж харж болохгүй.

-Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн хуулийн төсөлтэй хобоотой танай байгууллага нэг бус судалгаа хийсэн байсан. Судалгаагаар ямар үр дүн гарсан бэ?

Урьдчилсан хоёр судалгаа хийсэн. Бизнесийн салбар дахь жендэрийн статистикийн үнэлгээ. Жендэрийн мэдрэмжтэй хөрөнгө оруулалтын орчин гэсэн хоёр судалгаа хийгдсэн. Судалгаануудаар юу харагдсан бэ гэхээр эмэгтэйчүүд онцлогтой бизнес эрхэлдэг юм байна. Худалдаа үйлчилгээ, жижиг, дунд үйлдвэрийн салбарт их байдаг төдийгүй эрүүл мэнд, оёдол, гар урлал гэх мэт онцлогтой салбарт бизнес

эрхэлдэг гэсэн судалгаа гарсан. Уул уурхай, ложистик, мэдээлэл технологийн салбарт эмэгтэйчүүд маш бага байдаг. Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн хууль гарсанаар энэ салбаруудад үүсч байгаа жендэрийн тэгш бус байдлыг тэнцвэржүүлэх боломж үүснэ.

Гэтэл эмэгтэйчүүдийн түлхүү хийдэг лаа, саван, гар урлалын гээд тэр онцлогтой бизнесийг нь банкныхан төдийлэн сайн ойлгож, ойшоодоггүй тухай бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төлөөлөл хэлдэг. Тэгэхээр эмэгтэйчүүдийн энэ онцлогтой бизнесийг дэмжих шаардлагатай байна л гэж үзээд байна. Дээр нь ажлын байр ихээр бий болгодог жижиг, дунд үйлдвэрлэгчдээ бэхжүүлснээр эдийн засгийн төрөлжилтөд томоохон хувь нэмэр оруулна гэсэн үг.

-Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх хуулийн төслийг албан бус салбарт ажиллаж байгаа эмэгтэйчүүд, малчин эмэгтэйчүүдэд хэр хүрч үйлчлэх вэ гэдэг асуудал өнгөрсөн наймдугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор хийсэн чуулганы үеэр яригдаж байсан шүү дээ. Та энэ тал дээр юу хэлэх вэ. Мөн уг чуулганы үр дүнг хэрхэн харж байна вэ?

Чуулган зохион байгуулахад олон эмэгтэйчүүдийн байгууллага оролцсон, тэр дундаа 21 аймгийн төлөөл. Чуулганы дараах өдөр МҮХАҮТ дээр 21 аймгаас ирсэн эмэгтэй бизнес эрхлэгчидтэй арга хэмжээ хийсэн.Тэр үеэр бас хуулийг нилээн дэлгэрэнгүй танилцуулсан. Тэгэхээр чуулганы үр дүнг хэрхэн харж байгаа вэ гэхээр хуулийн төслийг УИХ-аар хэлэлцээд, батлаасай гэсэн хүлээлт олон нийтэд бий. Энэ хуулийг баталснаар нь олон улсын түвшинд Монгол Улсын нэр хүндэд эергээр нөлөөлөх үр дүн гарна гэж бодож байна. Чуулганы үеэр албан бус эдийн засгийг дэмжихгүй байна, малчин эмэгтэйчүүдийг хамарч байгаа юу гэдэг асуудал гарч байсан. Албан бус эдийн засгийг дэмжээд байвал албан бус байгаад л байна. Уг нь энэ албан бус салбар чинь албан болох хэрэгтэй байна. Ардчилсан нийгэмд шилжсэнээс хойш өнөөдрийг хүртэл олон жил албан бус сектор, далд эдийн засаг нь томорч ирлээ. Одоо албан бус эдийн засгаасаа салаад бичил , бичлээсээ жижиг, дунд руу томорч хөгжих шаардлага бий. Бүр том болох нь юу юм. Гэхдээ аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүд ядахдаа өөрийн гэсэн үйлдвэрийн орон байртай, арван ажилтантай болоод явах юм бол өрхийн үйлдвэрлэлийн хөгжилд болон улсын эдийн засагт ч хэрэгтэй. Тодорхой хэмжээнд татвараа төлдөг. Татвар төлснөөрөө эмэгтэй бизнес эрхлэгчдийн хувьд төрийн худалдан авалтад оролцоход тодорхой давуу эрхүүдийг бий болгож болно. Малчин эмэгтэйчүүдийн хувьд ганцаараа өрхийн үйлдвэрлэл эрхлээд явах уу, хамтарч хоршоод явах уу гэдэг асуудал гарч байгаа л даа.

-Эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшний оролцоо манайд сайнгүй байна. Өнөөдрийн өрнөж байгаа үйл явдлаас харахад эмэгтэйчүүдийг алдаа гаргасных нь төлөө албан тушаалаас нь авах амархан байгаа зэрэг нь илүү их зүйл хийх хэрэгтэйг сануулж байна гэдэгтэй санал нийлэх үү?

Эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэхтэй холбоотой улс төрийн түвшинг авч үзэх ёстой гэж бодож байна. Ирээдүйд эмэгтэйчүүд улс төрд орох бололцоо нь ямар байгаа юм бэ гэдгийг харах хэрэгтэй байгаа. Улс төрд ороход их хэмжээний мөнгө төгрөг шаардлагатай болдог. Эмэгтэйчүүд тэр хэмжээний мөнгийг гаргаж чаддаггүй. Өнөөдөр эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоо нь илүү байвал цаашлаад улс төрд орох бололцоо нь нээгдэж магадгүй.

Ер нь УИХ-ын сонгуульд ихэнхдээ квот зааж эмэгтэйчүүдийг оруулдаг. Эмэгтэй улстөрчдийн квот 2012 онд 30 хувь байсан. 2016 онд Сонгуулийн тухай хуулиар 20 хувь болгож бууруулсан. 2020 оны сонгуулиар мөн 20 хувийн квот мөрдөгдсөн. Яагаад энэ квотыг тогтвортой 30-40 хувь байлгаж болдоггүй вэ. Нэг өрөөсгөл ойлголт юу байдаг гэхээр сонгуульд эмэгтэйчүүд 20 хувь нэр дэвшлээ гэж байгаа ч гэсэн 20 хувь нь сонгогдоно гэсэн үг биш шүү дээ. Хэрэв УИХ-ын гишүүдийн 20 хувийг эмэгтэйчүүдээс бүрдүүлбэ гэвэл сонгуульд наад зах нь 30-40 хувийн эмэгтэйчүүдийн квот тавьж байж тэндээс 20 хувь нь сонгогдоно. Гэтэл өнөөдөр сонгуулийн тухай хуулиар 20 хувийн квот тогтоочихоод байгаа учраас эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо 10 гаруй хувиас хэтрэхгүй байна. Сонгуулийн тухай хуульд яагаад эмэгтэйчүүдийн квотыг өсгөж болдоггүй юм.

Манайхны дунд эмэгтэйчүүд эмэгтэйчүүдээ дэмждэггүй гэсэн яриа байдаг. Тэр бол худлаа шүү дээ. Би түүнтэй санал нийлдэггүй. Эмэгтэйчүүд эмэгтэйчүүдээ дэмждэг. Сонгуулийн тухай хуульд эмэгтэйчүүдэд ийм бага квот оруулж батлаад хооронд нь өрсөлдүүлж байна шүү дээ. Зөвхөн УИХ биш яам, агентлаг, аймаг, сум, дүүрэг гээд хэдэн эмэгтэй удирдлага байна. Нөгөөтэйгүүр нийгмийн хүрээнд эмэгтэй хүн алдаа гаргаж болдоггүй. харин эрэгтэй хүн болдог гэсэн тийм ойлголт яваад байх шиг. Эмэгтэй хүний гаргасан алдааг өлгөж аваад газар доогуур ортол муулж болдог. Эрэгтэйчүүд хийгээд байж л байна. Тэднийг үйлдлийг хүлээн зөвшөөрөөд бараг од болгоод, алгаа ташаад сууж байгааг юу гэж ойлгох уу.

-Эргээд эмэгтэйчүүдийн эдийн засаг, бизнесийн асуудал руугаа ороход олон улсад эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих бодлого, санхүүжилт нэлээд хүчтэй дэлгэрч байна. Энэ чиглэлд ямар шинэлэг судалгаа байгаа вэ?

Сүүлийн үед Мастер карт гээд судалгаа гарсан байсан. Одоогийн байдлаар энэ судалгаанд 70 орон хамрагдсан. Энэ хэмжээний орон хэдийнэ эмэгтэйчүүдийн аж ахуй эрхлэлттэй холбоотой хууль эрх зүйн өөрчлөлтүүд хийгээд явж байгааг харах боломжтой. Үүгээр улс орон эмэгтэй бизнес эрхлэгчдээ хэрхэн дэмжиж байна, ямар хууль эрх зүйн орчин бий болгож байна гэдгийг харьцуулж гаргадаг судалгаа. Тэгэхээр дэлхий нийтэд эмэгтэй бизнес эрхлэгчдийн асуудал чухлаар тавигдаж байгааг эндээс харж болно. Манай улс ч гэсэн дэлхийтэй хөл нийлүүлээд алхах хэрэгтэй, эмэгтэйчүүдийн асуудал дээр.



НОГООН ЭДИЙН ЗАСАГ




Яагаад ногоон эдийн засаг гэж...

Английн Лондонд төвтэй Ногоон эдийн засгийн холбооны зүгээс Ковид-19-ын дараах эдийн засаг, санхүүгийн бэрхшээл, дэлхий дахины тогтворгүй байдал зэрэгт анхаарал хандуулан үүнд иргэн бүрийн, мөн хувийн хэвшил тэр дундаа орон нутагт үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн оролцоо чухал гэж онцолж буй. Хүйсийн тэнцвэртэй байдал, тэгш оролцоо, ногоон сэргэлт гэсэн ойлголтууд нь эдийн засаг, санхүүгийн сэргэлттэй нягт холбоотой. Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн зүгээс Ногоон эдийн засгийн холбооны Монгол дахь түнш, гишүүн байгууллагын хувьд байнгын мэдээлэлтэй, оролцоотой ажилладаг.

Улс орон бүрийн тулгамдаж буй асуудлууд нэгэн ижил биш ч эргэн сэргэлт, эдийн засаг, нийгмийн

өөрчлөлтүүдийг хийхдээ нэгдмэл дуу хоолойтой байж, хамтран ажиллах нь үр дүнтэй байна.




ХУВИЙН ХЭВШЛИЙН ОРОЛЦОО: ОРОН НУТГИЙН ЖИЖИГ, ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧИД

Өрсөлдөх чадвар сайтай улс орнуудын туршлагаас харахад улс орны эдийн засгийн гол цөм нь хувийн хэвшлээ дэмжих. Цар тахал, үймээн, дайн дэгдсэн сүүлийн жилүүдэд энэ салбар тэр дундаа хувиараа бизнес эрхлэгч, бичил болон жижиг, дунд үйлдвэрлэгчдээ дэмжих, тэдний үйл ажиллагааны гол цөм болсон санхүүжилтийг ногоон байдлаар шийдэх нь хэрэгжүүлж болохуйц, оновчтой шийдэл хэвээр байна. Бельгид төвтэй Файнанс Уоч болон Ногоон эдийн засгийн холбооны зүгээс эрхлэн гаргасан “Хөгжиж буй орнуудын орон нутгийн ногоон бизнес эрхлэгчдийг санхүүжүүлэх нь” судалгааны тайланд дурдсанаар эдгээр улс орнуудад албан бус эдийн засаг, санхүүгийн хүндрэлүүд, мэдээлэл болон чадамжийн дутмаг байдал болон зохицуулалтын ойлгомжгүй байдал зэрэг нь хамгийн ихээр чөдөр тушаа болж байна. Түүнчлэн жендерийн мэдрэмжтэй байх, нас, хүйсээр ялгаварлан гадуурхахгүй байх нь эерэг нөлөөтэйг онцолжээ.

Монгол Улс 2019 онд Ногоон таксономи баталсан



цөөн улсуудын тоонд ордог. Мөн түүнчлэн 2020 оноос Ногоон зээлийн статистикийг Монголбанкнаас гаргадаг болсон.



Энэ оны хоёрдугаар улирлын байдлаар 3555 зээлдэгчдийн 329,6 тэрбум төгрөг байна. Эдгээр зээлүүдийн дийлэнхийг ногоон барилгын салбарт нийт 57 зээлдэгчдэд 85,8 тэрбум, Тогтвортой хөдөө аж ахуй, газар ашиглалт, ойн болон эко аялал жуулчлалын 424 зээлдэгчдэд 84,3 тэрбум, Тогтвортой ус, хаягдлын хэрэглээний 114 зээлдэгчдэд 64,2 тэрбум, Эрчим хүчний хэмнэлтийн 1609 зээлдэгчийн 61,5 тэрбум төгрөгийн, бохирдлоос сэргийлэх, бууруулах үйл ажиллагааны 279 зээлдэгчийн 3,6 тэрбум төгрөгийн зээл олгожээ.

Ногоон санхүүжилтийн эх үүсвэрүүд харьцангуй сайн бүрдсэн байдаг хэдий ч цаашид илүү хөгжүүлэх боломжууд байгаа юм.

Цаашид хийгдэх шаардлагатай ажлууд

- Ногоон эдийн засаг, ногоон үйлдвэрлэлийн

талаар бизнесүүдэд ойлголт дутмаг

- Хүү багатай, хугацаа урттай санхүүгийн эх үүсвэр бага
- ЖДҮ эрхлэгчид дийлэнх нь эмэгтэйчүүд байдаг ба 2019 оны байдлаар нийт ЖДҮ эрхлэгчдийн 68 хувь нь эмэгтэй захиралтай байна. Гэсэн хэдий ч бизнесийн зээл авахад шаардагддаг барьцаа хөрөнгийн дийлэнх нь эрэгтэйчүүдийн нэр дээр өмчлөлтэй байдаг тул эмэгтэйчүүд барьцаа байршуулахад хүндрэлтэй тулгардаг.

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВИЙН ТУХАЙ

ЭЗБӨЧСТ нь Монгол Улсын эдийн засаг, бизнес, засаглалын орчныг таатай болгох, улмаар өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулах зорилго бүхий улс төрөөс хараат бус, ашгийн бус байгууллага юм. Тус төв нь анх 2010 анх үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн Монгол Улсын өрсөлдөх чадварыг олон улсын аргачлалын дагуу хэмжиж, энэ чиглэлээр өргөн цар хүрээний мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна. Төвийн зүгээс Швейцарт төвтэй Дэлхийн өрсөлдөх чадварын төвтэй хамтран Монгол Улсын өрсөлдөх чадварын бие даасан, иж бүрэн тайланг 2010 оноос эхлэн гаргасан.

Судалгаа, үйл ажиллагааны гол чиглэлүүд:

- Монгол Улсын өрсөлдөх чадварын судалгаа
- Аймгуудын өрсөлдөх чадварын судалгаа
- Улаанбаатар хотын дүүргүүдийн өрсөлдөх чадварын судалгаа
- Макро эдийн засгийн тойм, судалгаа
- Улирал тутмын банкуудын өрсөлдөөний тойм
- Салбарын судалгаа
- Сургалт, хэлэлцүүлэг

- Улс төрөөс хараат бус, ашгийн бус,
- Мэргэжлийн тинк танк буюу судалгаа, шинжилгээний байгууллага,
- Монгол Улсын өрсөлдөх чадварыг жил тутам тасралтгүй хэмждэг.
- Дэлхийн өрсөлдөх чадвар, судалгааны тэргүүлэх байгууллагуудтай хамтран ажилладаг, олон улсын аргачлал ашигладаг. ■



Дэлгэрэнгүй мэдээллийг:
www.ecrc.mn | www.nogoonhutuch.mn | www.aimagindex.mn

ЖЕНДЭР

Т.Энхбаяр: Жендэр хэн нэгэнд давуу тал олгох арга хэрэгсэл биш, тэгш бус байдлыг тэгш болгох асуудал

И.ОТГОНЖАРГАЛ

Жендэрийн үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Т.Энхбаяртай ярилцлаа.

-Та өөрийнхөө байгууллагын үйл ажиллагаа болон сүүлийн үед анхаарч хэрэгжүүлж байгаа ажлаасаа товч мэдээлэл өгнө үү?

Монгол Улс жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг 2011 онд баталсан. Хуулийг батлахаас өмнө жендэрийн асуудлыг анхаарч ирээгүй гэвэл тийм биш. 1995 онд БНХАУ-ын Бээжин хотноо 170 гаруй орны төлөөлөгч оролцсон Дэлхийн эмэгтэйчүүдийн IV Их хуралд манай улс анх удаа бүрэлдэхүүнээ явуулсан. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэлхийн дуу хоолойд анхаарлаа хандуулах нь зүйтэй гэж үзсэн. Ингээд 1995 оноос хойш иргэний нийгмийн байгууллагууд, хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг эмэгтэйчүүдийн хөдөлгөөнүүд Монголд нэлээд идэвхжиж жендэрийн хуулийг батлуулах, Жендэрийн хорооны бүтцийг батлуулах, энэ нь хүн төрөлхтөн байгаа цагт байх ёстой асуудал юм байна гэдгийг гаргаж тавьсан.

Дэлхий дахинд жендэрийн асуудал анх эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаар эхэлсэн байдаг. Өөрөөр хэлбэл, эмэгтэйчүүд сонгууль өгөх, хөдөлмөр хийх, боловсрол эзэмших, эмэгтэйчүүд эрүүл аюулгүй орчинд аж төрөх, сонголт хийх боломж байгаагүй. Эмэгтэй хүнийг дэлхий нийтэд хүйс гэж хүлээн зөвшөөрөхгүй байсан. Тиймээс эмэгтэйчүүд хүйсийнхээ хувьд хүлээн зөвшөөрөгдөх ёстой гэдэг асуудлыг



гаргаж тавьснаар жендерийн асуудлыг дэлхий дахинд авч үзсэн.

-Жендэрийн үндэсний хорооны үндсэн үндсэн чиг үүрэг юу вэ?

Манайд 1996 оноос хойш жендэрийн хууль батлах хөдөлгөөн өрнөж явсаар 2011 он хүртэл арав гаруй жилийг үдэж, хамгийн сүүлчийн ажлын хэсэг 2006 онд байгуулагдсан. Жендэрийн хууль 2011 онд батлагдахад Ази Номхон далайн бүсийн цөөхөн ийм хуультай орнуудын тоонд Монгол Улс багтаж байлаа. Түүхийг харахад энэ хуулийг батлуулахад хамгийн их хүчин чармайлт гаргасан олон улсын байгууллага НҮБ-ын Хүн амын сан байдаг юм билээ. Хуульд хороо гэдэг зүйлийг оруулж өгсөн.

Жендэрийн хороог Ерөнхий сайд тэргүүлдэг. Хороо нь төр болон төрийн бус байгууллагын тэнцүү оролцоотой орон тооны бус байгууллага. Засгийн газрын тогтоолоор 2018 оноос хойш Жендэрийн хорооны Ажлын албыг Ерөнхий сайдын дэргэд бие даасан байдлаар ажиллуулж эхэлсэн. ►

Эмэгтэйчүүд хүйсийнхээ хувьд хүлээн зөвшөөрөгдөх ёстой гэдэг асуудлыг гаргаж тавьснаар жендерийн асуудлыг дэлхий дахинд авч үзсэн.

Жендэрийн үндэсний хорооны үндсэн чиг үүрэг бол жендэрийн эрх тэгш байдлыг хангах үзүүлэлт жендэрт суурилсан статистикт үндэслээд Монгол Улсын салбаруудын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогууд, хууль тогтоомжууд, төрийн байгууллагын гаргаж буй шийдвэрүүд, хүний нөөцийн чадавхид жендэрийн асуудал яагаад чухал вэ гэдгийг таниулах мэдрүүлэх, оруулах, төлөвлөхөд оршиж байгаа юм.

-Жендэр гэж юу вэ?

Хүний эрх гэдэг хүнд олгогдсон жам ёсны эрхүүд. Тэр дундаа жендэр гэдэг эрэгтэй, эмэгтэй хоёр хүйс байгалиасаа ялгаатай. Эрэгтэй эмэгтэй хүний 12 шинж гээд шинжлэх ухаан тогтоочихлоо. Энэ 12 шинж тухайн хүмүүс нийгмийн харилцаанд орохоороо ялгаатай байдлуудыг бий болгоод байна. Тиймээс үүнд нь нийцсэн ялгаатай бодлого явуулах. Нэг бодлого явуулаад байхаар энэ ялгаатай байдлаас хамаараад тэгш бус байдал үүсээд байна гэдгийг өнөөдөр жендэрийн шинжлэх ухаан гаргаад ирсэн. Өнөөдөр хөгжлийн бодлогоо эрэгтэй эмэгтэй гэх ялгаатай байдлууд нь бусад салбарт орохоороо асуудал үүсгэдэг. Тиймээс ялгаатай тэгш гарааны нөхцөлийг бий болгоход жендэрийн бодлого төлөвлөлт, төсөвлөлтийг ашиглах хэрэгтэйг ухуулах ойлгуулах, жендэрийн арга аргачлалыг хэрэглэхэд манай хороо бүх төрийн байгууллагуудтай хамтарч ажилладаг.

Монголчуудын хувьд жендэрийн хэвшмэл ойлголт муу

нөлөөтэй байна. Үүнийг хэрхэн өөрчлөх ёстой вэ?

Хүүхэд тээгээд, төрүүлээд, өсгөх хугацаа нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг хязгаарладаг. Эмэгтэйчүүд ажил эрхлэхгүй, шийдвэр гаргах түвшний оролцоо нь нэмэгдэхгүй байгаа үндсэн шалтгаан хүүхэд төрүүлэх хугацаа. Эмэгтэй хүн дөрвөн хүүхэд төрүүлж өсгөхөд хөдөлмөр эрхлэлтийн карьер 10-15 жилээр алдагддаг. Энэ нь карьер хийх боломжтой насанд нь бий болдог. Эмэгтэйчүүдийн ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй явуулах вэ гэдэг нь жендэрийн шинжлэх ухаантай уялдаатай. Гэтэл “эмэгтэйчүүдэд эрх нь байгаа. Эмэгтэйчүүд боловсролтой хэдий ч дарга болохгүй байна” гэдэг. Дарга болох карьер, санхүү нь хаана байна. Эмэгтэйчүүд эдийн засгийн хувьд хараат бус байж, хөдөлмөрлөх эрх нь тасралтгүй явж чадаж байгаа юу. Та хүүхэд гаргах уу, карьер хийх үү. Та нөхөрт гарах уу, ажил хийх үү гэсэн дэнсэн дээр байнга аваачдаг. Эмэгтэйчүүдэд ажил хийх дэд бүтцүүд нь байж л шийдэгдэнэ. Өнөөдөр эрчүүд яагаад бага наслаад байна. Тэгвэл эрэгтэй хүний эрүүл мэндийн байдал жендэрийн хэвшмэл ойлголтоос хамаарч байна. Нийгмээс эрэгтэй, эмэгтэй хүний оноосон дүрүүдийг бий болгочихсон. Жендэрийн шинжлэх ухаанаар энэ бол хэвшмэл ойлголт гэж хэлээд байгаа юм. Тэгэхээр эрчүүдийн ажлын байр, жендэрийн мэдрэмжгүйгээс үүсэлтэй хүний эрүүл мэнд, аюулгүй байх орчинд асар сөргөөр

нөлөөлсөн байна. Үүнийг яаж шийдвэрлэх юм бэ гэдэг өөрөө асуудал. Салбар бүрийн хөгжлийн онцлогтой. Тэгэхээр Жендэрийн хорооны эхний том бодлого бол Жендэрийн тухай хууль. Дараа нь энэ хуулийг хэрэгжүүлэх дунд хугацааны бодлогууд. Түүний дараа нь салбар бүр өөрийн салбарын онцлогт нийцсэн салбарын жендэрийн бодоготой байна. Орон нутаг бүр өөрийн хөгжлийн гарц шийдэлд нийцсэн жендэрийн дэд хөтөлбөртэй. Гэхдээ эдгээр бодлого хөтөлбөр нь бие даасан биш, тухайн салбар, орон нутгаас гарч байгаа бодлого хөтөлбөрүүдэд шингээх замаар хэрэгжүүлнэ.

Жендэрийн үндэсний хорооноос 12 салбарт жендэрийн бодлого амжилттай батлуулаад, хэрэгжилтийг нь хангуулж байна. Одоо шинээр байгуулагдсан соёлын салбар болон харилцаа холбооны салбарын жендэрийн бодлогыг боловсруулж байна. 21 аймаг жендэрийн дэд хөтөлбөр батлан хэрэгжүүлж дуусаад дараагийн хөтөлбөрийн төлөвлөгөөгөө гаргана.

Жендэрийн үндэсний хорооны эрхэлж байгаа үндсэн том мандатын сэдэв бол жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсөвлөлт, хянат шинжилгээ мониторингийг бүх шатанд хөгжүүлэх. Ингэхдээ тэргүүн ээлжинд төрийн алба байна гэж үзсэн. Төрөөс маш олон шийдвэр гаргаж байгаа. Миний чиний эрхийг ч дэмжиж байгаа бас хязгаарлаж байгаа. Тиймээс төрийн албыг нэн тэргүүнд жендэрийн

ЖЕНДЭР

мэдрэмжтэй болгох. Дараа нь хувийн хэвшил байна. Хүнд ээлтэй ажлын байр, хөдөлмөрийн орчин байна уу гэдэг асуудал. Цаашлаад иргэний нийгмийн байгууллагууд санаачилгаараа хийгээд явж байна.

Хуультай, хороотой болсноор манай улсын жендэрийн мэдрэмжтэй байдалд хэр өөрчлөлт гарч байна вэ?

Би Жендэрийн хорооны Ажлын албаны даргаар ажиллаад зургаан жил болж байна. Намайг энэ ажлыг авах үед жендэрийн асуудлыг зүгээр л хүйсийн тэнцвэрт байдлыг хангах асуудлаар төсөөлж байсан. Хоёрдугаарт, сонгууль болохоор эмэгтэйчүүдийн квот ярьдаг асуудлаар төсөөлдөг. Гуравдугаарт, жендэрийн хуулийг ашиглаж эмэгтэйчүүдийг дарга болгодог гэсэн ойлголт хамаатуулдаг байна. Гэхдээ Жендэрийн үндэсний хорооны шинжээчдийн бүлэг, экспертүүд, эмэгтэйчүүдийн эрхийн хөдөлгөөн, иргэний нийгмийн байгууллагын санаачилга нь төрийн байгууллагын баримталж байгаа бодлого, иргэдийн ойлголтоос аль хэдийнэ давсан байсан.


Сүүлийн зургаан жилд бидний гаргаж чадсан амжилт бол тогтвортой хөгжлийн зорилтод оруулж, жендэрийг олон улсаас ч амбицтай шахаж байна. Нөгөө талаас ардчилсан засаглалтай орнуудын хувьд жендэр, хүний эрх гэдгийг өргөн хүрээнд шинжлэн судалж байна. Харин ахиц хэрхэн харагдаж байна гэвэл хүн байвал жендерийн асуудал байх юм. Бид бие биенийхээ ялгаатай өөр гэдгийг хүлээн зөвшөөрье, жендэр гэдэг нь хэн нэгэнд давуу тал олгох арга хэрэгсэл биш. Тэгш бус байдлыг тэгш болгох асуудал юм. Түүнээс эмэгтэйчүүдийг мандуулаад, эрэгтэйчүүдийг дорд үзэж буй асуудал огт биш. Зөв зүйтэй хүнд ээлтэй хөгжлийг дэмжихэд жендэрийн арга зүйг ашигла гэсэн санаа гэдгийг түвшин түвшиндээ ойлгож, ойлгосон. Жендэрийн асуудлыг бид сууриар нь харж чаддаг боллоо. Дээр нь

нас хүйсээр ялгаварладаг, хүйсийг дорд үздэг асуудлаар бид нийгэмд том сигнал өгч чадсан болов уу гэж бодож байгаа. Дараагийн нэг том ахиц бол гэр бүлийн хүчирхийллийг хүйст чиглэсэн хүчирхийлэл гэдгийг нийтээрээ ойлгодог болсон. Ойлголт, хандлага нэг болоод ирэнгүүт асуудал гүнзгийрч байна. Шинэ үе жендэрийг бүр гайхамшигтайгаар гаргаж байгаа. Ерөөсөө л итгэлцэл. Бие биенээ хүлээн зөвшөөрөх байдал. Хүйсээс үл хамаараад хүнийг хүндэтгэх хандлага бий болж байгаа гэсэн үг. Энэ бол гэр бүлийн харилцаанд ч ажлын байранд ч ахиц гарч байгаагийн илэрхийлэл. Гагцхүү эдгээр ахицыг бид хэмжиж чадахгүй байгаа учраас сайныгаа олж харахгүй байгаа юм. Бид үүнийг байнга ярих

ёстой. Хэвшмэл ойлголтыг нийгэмд түрээд ирэхээр хүйст тулгуурасан ялгаварлан гадуурхалт багасна. Аяндаа эрэгтэй, эмэгтэй хүмүүст тулгамдаж байгаа хүйсийн асуудал, тэр асуудлыг хариуцсан мэргэжилтний ойлголт нэмэгдээд ирэхээр тухайн хүн бичиж байгаа цаасаа хүртэл өөрөөр хардаг болох юм.


-Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн хувьд хүйсийн ялгаатай байдлаас болж бизнесийн зээл, хөтөлбөр дэмжлэг авч чаддаггүй гэдэг. Эмэгтэйчүүдийн бизнес эрхлэх боломж, эдийн засгийн оролцоог хэрхэн сайжруулах вэ?

Дэлхийн тогтвортой хөгжлийн тавдугаар зорилтод охид эмэгтэйчүүдийг эдийн засгийн хувьд хүчирхэгжүүлэх гэсэн томъёолол орсон. Яагаад энэ нэр



Шинэ үе жендэрийг бүр гайхамшигтайгаар гаргаж байгаа. Ерөөсөө л итгэлцэл. Бие биенээ хүлээн зөвшөөрөх байдал. Хүйсээс үл хамаараад хүнийг хүндэтгэх хандлага бий болж байгаа гэсэн үг. Энэ бол гэр бүлийн харилцаанд ч ажлын байранд ч ахиц гарч байгаагийн илэрхийлэл.





томьёо хүчтэй орж байна гэхээр манайд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар бас энэ нотлогдчихсон. 2021 онд бид Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн үр дагаварын үнэлгээг зүйл заалт бүрээр нь хийсэн. Тус хуулиас хэрэгжээгүй хоёр зорилт байгаагийн нэг нь эдийн засгийн хүрээнд дэх жендэрийн эрх тэгш байдлын баталгаа. Нөгөө нь улс төрийн хүрээнд дэх жендэрийн тэгш байдлын баталгаа. Энэ хоёрын хэрэгжилт хангалтгүй гарсан. Улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоо квот байгаа хэрнээ 30 хувьд хүрч чадахгүй байна. Үүнийг цаашид бид ахиулах ёстой. Эдийн засгийн оролцооны хувьд эмэгтэйчүүд ямар нэгэн хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө өмчилдөггүй. Энэ нь эмэгтэйчүүдийн аж ахуй эрхлэх, бизнестэй байх, ажил олгогч болох, эдийн засгийн чадавхтай байх зорилгоор бизнес эрхлэхэд зээл бараг олддоггүй. Угаасаа манай нүүдэлчин ахуйтай холбоотой монгол эмэгтэй хүний сэтгэхүйд өрхийн тэргүүн, үр хүүхэд, хань ижил минь гэдэг. Энэ нь эмэгтэй хүний бие даасан байдалд нь сөрөг нөлөөтэй. Эмэгтэйчүүдэд нийгэмд гарч байгаа элдэв үзэгдлүүдээс хамаараад янз бүрийн бэрхшээл тулгарч байна.

-Тэгэхээр бичил, жижиг, дунд аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засгийг сайжруулах чиглэлд юуг хийх хэрэгтэй вэ?

Ер нь бол эмэгтэйчүүдийн эдийн засгийн мэдлэг, хараат бус байдлыг бага байхаас нь бэхжүүлэх ёстой юм билээ. Энд хамгийн эхний гарц нь хүүхдийг бид өөрийн гэсэн хадгаламжтай болгохоос эхлэх хэрэгтэй. Хэрэв орлоготой ажил төрөл хийж байгаа бол чиний өөрийн хэрэглээ хэрэгцээ чинь юу байгаа вэ гэдгийг ойлгуулах. Нөгөө талаас ямар ч орлогогүй хүүхдээ харж байгаа ээж байна. Тэгвэл энэ гэр бүлийн эзэгтэйн үнэлэгдэхгүй байгаа хөлсгүй хөдөлмөрийг эдийн засгийн үнэлгээгээр үнэлэхэд би ямар оролцоотой байгаа вэ гэдэг сэтгэлгээг суулгаж өгөх хэрэгтэй. Хөлсгүй хөдөлмөр гэдэг нэр томьёо олон улсад үүсээд 20,30 жил болчихлоо. Бид үүнийг өнөөдөр үнэлж чадахгүй байгаа ч үнэлэх хэмжээний мэдлэг ойлголтыг авч байгаа. Эмэгтэйчүүд “Энэ миний мөнгө биш, манай нөхрийн мөнгө” гэдэг хандлага ойлголтыг ерөөсөө гаргахгүй байх ёстой.

Ижил үнэ цэнэ бүхий ажилд ижил цалин олгодоггүй байх. Хөлсгүй хөдөлмөрийг эдийн засгийн үнэлэмжээр үнэлдэг байх. Үүнийг орлогод тооцдог байх гэсэн

ойлголтууд олон улсад түрж орж ирж байгаа. Манайд ч бий болно.

Тэгэхээр одоо байгаа бичил, жижиг бизнест хоёр арга замыг харж байна. Нэгдүгээрт, зээлийг хүртээмжтэй болгох. Барьцаа хөрөнгийн шаардлагыг багасгах. Эмэгтэйчүүдийн зээлийн эргэн төлөлт сайн хийдэг чадварт эрсдэлийг нь үүрүүлж, урт хугацаатай, барьцаа багатай зээл олгох нь жендэрийн мэдрэмжтэй зээлийн үйлчилгээ юм. Тэгэхээр аль салбарт эмэгтэйчүүд олонх байна тэр нь ямар амьдралыг үүрээд хувь нэмэр оруулж байна гэдгийг бид жендэрийн дүн шинжилгээ хийж хараачээ гэдгийг Засгийн газарт санал тавьдаг. Жишээ нь 10 их наядын зээлийнхээ хүйсээр ангилсан мэдээллийг аваад ир гэхээр аль ч төрийн байгууллага гаргаж өгч чадахгүй байна. “Энэ зээлд нэг үнэлгээ хийчих. Тэгэх юм бол энэ удаа чадахгүй ч дараагийн том зээлийг үр дүнтэй өгч чадна. Маш олон хүн зээл авч чадахгүй байна. Зөвхөн хэдхэн бүлэг этгээд авч байна. Магадгүй тэр дотор эмэгтэй эзэнтэй компани авч л байгаа байх. Гэхдээ нийгмийн масс хэсэг ийм жижиг байгаад байна. Тиймээс энд тохирсон зээлийн үйлчилгээ, хүртээмжийг бий болгоод, эргэн төлөлтөөр нь барьцаа хийгээд итгэл үзүүлээд өгөөчээ” гэж хэлдэг. Энд нэг баримтлах зүйл нь албан бус эдийн засгийг дэмжиж болохгүй. Албан эдийн засгаа хөгжүүлэх бодлогоо төр бариад зээлээ хүртээмжтэй болгох байдлаар явах юм бол эмэгтэйчүүд өөрсдөдөө таарсан жижиг зээлээ аваад, татвараа төлөөд явна. Хүсэх юм бол шийдвэрлэх арга зам зөндөө.

Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан байгаа. Энэ асуудлаар Ерөнхийлөгчийн ивээл дор чуулган хийсэн. Та энд ямар үр дүн гараасай гэж бодож байна вэ?

Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн

ЖЕНДЭР

энэ хуулийг бичих, санаачилга сэдэл нь анх Европийн сэргээн босголт хөгжлийн банкны бүсээс таван улсыг оруулан хэрэгжүүлж байгаа олон улсын том төсөлд Монгол Улс багтсан юм билээ. Энэ төслийг Монголд оруулж ирэх гэж МҮХАҮТ-ын дэргэдэх Эмэгтэй бизнес эрхлэгчдийн зөвлөлийн зүгээс танхимтайгаа хамтраад болон бие дааж олон жил явсан хөдөлмөрийн үр дүн гэж өөрсдөө онцолдог юм билээ. Монгол Улсад дээрх олон улсын төслийн нэгжийг байгуулмаар байна. Үүнд Жендэрийн үндэсний хороо оролцоод яваач гэдэг хүсэлтийг анх ЕСБХБ-ны зүгээс манайд тавьсан. Бид үүнийг аль нэг салбарт оччихоор болохгүй. Салбар бүрийн төлөөллийг оруулж Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн бизнесийн хуулийн төслийг явуулах юм байна гээд Төслийн удирдах хороог Жендэрийн үндэсний хорооны тогтоолоор байгуулсан. Ингээд тухайн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар ахлуулсан Төслийн удирдах хорооноос уг төслийн зохицуулагч нэгжээр Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийг оруулсан юм.

Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоог сайжруулах хуулийн төслийн гурван том зорилгын нэг нь хууль эрх зүйн орчныг бий болгох. Хуулийн төслийг Их хуралд өргөн барих ажлыг Сарангэрэл гишүүн манлайлж ажилласан. Хэлэлцэх асуудал нь парламентаар шийдэгдээд явна гэж харж байгаа. Жендэрийн үндэсний хороо уг хуулийн төслийг концепц, агуулгын хувьд бүрэн дэмжиж байгаа. Хууль зүйн хувьд томьёоллыг сайжруулах асуудлуудаа засаад явах нь зүйтэй гэдэг саналыг Жендэрийн үндэсний хорооны дэргэдэх Шинжээчдийн бүлэг өгсөн.

Хууль батлагдан гарснаар гарах үр нөлөө нь юу байх вэ?

Судалгааны тайлангаас харахад бизнес эрхлэгч эмэгтэй гэдэг тодорхойлолтыг хууль эрх зүйн орчинд суулгахаар олон улсын санхүүгийн байгууллагаас бичил, жижиг бизнес эрхэлж байгаа эмэгтэйчүүдэд санхүүгийн хувьд олон талт дэмжлэг ирнэ гэж ойлгосон. Яагаад заавал эмэгтэй бизнес эрхлэгчдийг онцолж байгаа вэ гэвэл, тэдэнд зайлшгүй бэрхшээл байдаг учраас дэмжлэг хэрэгтэй гэдгийг Монгол Улс хууль эрх зүйн орчноороо тодорхойлоод өгчихсөн байна гэдэг энэ чиглэлд орж ирэх олон улсын анхаарал, тусламж дэмжлэг, олон

улсын байгууллагын хүчин чармайлт илүү нэмэгдэх боломжтой. Тэгвэл төрөөс олгох хязгаарлагдмал нөөц шаардлагагүй болж төр илүү бодлогын дэмжлэгээ үзүүлээд явах боломжтой.

Мэдээж аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн бизнес санхүүгийн дэмжлэг сайжирна гэдэг нь Монгол хүний амьдралын чанарт ахиц гарна гэсэн үг. Түүнээс биш, татвар санхүүгийн дэмжлэг үзүүл гэсэн санаа бол биш. Хуулийн гол зорилго эмэгтэй бизнес эрхлэгч гэж хэн бэ гэдэг тодорхойлолт оруулах. Ингэснээр олон улсын том бодлогод манай улс нэгдэж нийлэх, дэмжлэг авах. Улмаар олон бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн бүтээгдэхүүн үйлчилгээ олон улсад гарах боломжууд бий болно гэж харж байна.

Хоёр дахь том зорилт төслийн хүрээнд банк санхүүгийн байгууллага бичил, жижиг, дунд бизнесийн салбарыг хүйсээр ангилсан жендэрийн статистик мэдээлэлтэй болох. Ингэснээр Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, ББСБ-ууд мэдээллийн сангаа сайжруулах ажил руу орно. Төслийн гурав дахь зорилт жендэрийн мэдрэмжтэй банк санхүүгийн үйлчилгээг бий болгох чиглэлд банкуудтай хамтарч ажиллана. ■



Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн тэгш бус байдлыг халах нь

Д.МӨНХЧИМЭГ

/Хэвлэл мэдээллийн зөвлөлийн хараат бус зөвлөх/

Та өөрийн төлөөллийг өдөр тутмын мэдээнээс хэр элбэг хардаг вэ. Дэлхийн хүн амын тэн хагасыг бүрдүүлдэг эмэгтэйчүүдийн дуу хоолойг хэвлэл мэдээллээр маш бага хүргэгдийг Та мэдэх үү?

Олон улсын хэвлэл мэдээллийн мониторингийн судалгааг 1995 онд анх хийхэд мэдээний субъект буюу мэдээгээр гарсан хүмүүсийн ердөө 17 хувь нь эмэгтэйчүүд байж. Үүнээс 25 жил өнгөрөхөд энэ үзүүлэлт 25 хувьд хүрчээ. Байдал энэ чигээр үргэлжилбэл мэдээний агуулгаас жендэрийн тэгш байдлыг харахын тулд дор хаяж 67 жил хүлээх хэрэгтэйг судлаачид анхааруулдаг.



Олон улсын хэвлэл мэдээллийн мониторингийн төсөл, эмэгтэй эх сурвалжийн хувь хэмжээ

ОЛОН УЛСЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН МОНИТОРИНГИЙН ТӨСӨЛ, ЭМЭГТЭЙ ЭХ СУРВАЛЖИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ

Мөн мэдээний агуулга дахь эх сурвалжуудын 25 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байгааг задалж үзвэл гэрийн ажил болон эцэг эхийн үүргээр гарсан хүмүүсийн 68 хувь нь эмэгтэйчүүд байгаа юм. Тэгвэл улс төрийн мэдээний эх сурвалжуудын 18 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байгааг Олон улсын хэвлэл мэдээллийн мониторингийн төслийн үр дүн харуулдаг.



Монгол Улсын хувьд Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс 2021 онд хийсэн судалгаагаар өдөр тутмын сонины улс төрийн мэдээллийн эх сурвалжийн 14

хувь, мэдээллийн сайтуудын эх сурвалжийн 9.5 хувь л эмэгтэйчүүд байна. Хэвлэл мэдээллээр 20-30 улс төрчийг л олон давтамжтайгаар байнга гаргаж байгаагийн 10 орчим хувь нь л эмэгтэйчүүд байгааг мөн судалгаа харуулсан.



Өдөр тутмын сонин 14.3%



Мэдээллийн сайт 9.5%

Эмэгтэй улс төрчид болон тэдний улс төрийн байр суурийг сэтгүүлчид анхаарч үздэггүйг УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг бидэнд өгсөн ярилцлагынхаа үеэр онцолж байв. “Нэг үйл ажиллагаа болж байна гэж бодъё. Тэнд эмэгтэй улс төрчид оролцож байлаа ч сэтгүүлчид ихэвчлэн эрэгтэйчүүдээс яриа авдаг. Мэдээнд эмэгтэйчүүдийн байр суурийг огт гаргахгүй байх тохиолдол элбэг” хэмээн тэрбээр хэлсэн юм. Одоогийн парламентад байгаа УИХ-ын 13 эмэгтэй гишүүний нэг.

Эмэгтэйчүүдийг улс төрийн мэдээнд цөөн гаргадгаас гадна тэднийг хэвшмэл ойлголтын дагуу дүрслэх нь элбэг. Тухайлбал, хэр сайн гэрийн эзэгтэй вэ, хэдэн хүүхдийн ээж вэ гэдгийг онцлохоос гадна хувцаслалт, нүүр будалт, биеэ авч явах байдалд нь хэт ач холбогдол өгөх нь бий.

Үүнийг өөрчлөхийн тулд “Мэдрэмжтэй мэдээлье” нэгдлийг Хэвлэл мэдээллийн зөвлөл болон Анлимитэд медиа группийн хамтарсан консорциумаас БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг (КОЙКА), НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн хүрээнд үүсгэн байгуулсан. “Мэдрэмжтэй мэдээлье” нэгдэл нь жендэрийн мэдрэмжтэй, ёс зүйтэй сэтгүүлч, редакторуудын мэдлэг, чадвараа сайжруулах, харилцан туршлага солилцох, салбартаа манлайлах, уншигч, үзэгчдийнхээ итгэлийг хүлээх нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилготой. Нэгдлээс шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш бус байдлын асуудлыг даацтай мэдээлэх, нийгэм дэх хэвшмэл ойлголтыг халахад чиглэсэн чанартай, ёс зүйтэй



бүтээлүүд гаргах гишүүдийнхээ санаачилгыг урамшуулан дэмждэг.

Эдүгээ “Мэдрэмжтэй мэдээлье” нэгдэл нь 200 гаруй идэвхтэй гишүүнтэй бөгөөд өргөжин тэлсээр байна. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд “Улс төрийн мэдээллийн агуулгад жендэрийн тэгш байдлыг хангах нь” сургалтын хөтөлбөр боловсруулж, 500 гаруй сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтныг хамруулсан сургалт, үйл ажиллагаанууд зохион байгуулсан.

“Сэтгүүлчид санаатай гэхээс илүүтэй санамсаргүйгээр эмэгтэйчүүдээс яриа авахыг орхигдуулчихдаг нь бүтээлээ маш хурдан хугацаанд гаргадагтай холбоотой болов уу” хэмээн “Nikkei Asia”, AFP болон бусад олон улсын хэвлэлд ажилладаг чөлөөт сэтгүүлч Б.Халиун хэлэв. “Эрүүл мэнд, боловсрол мэтийн сэдвээр ярих эмэгтэйчүүдийг олоход асуудалгүй. Харин уул уурхай, эдийн засаг, банк санхүү мэтийн салбарт яах аргагүй эрэгтэйчүүд давамгайлчихдаг. Тиймээс эх сурвалжийн дата сан сэтгүүлчдэд хэрэг болно гэдэгт итгэлтэй байна” хэмээн тэрбээр тэмдэглэсэн юм.

“Мэдрэмжтэй мэдээлье” нэгдлээс эх сурвалжийн дата сан бүрдүүлэх

Хакатон зохион байгуулж, улс төр, эдийн засаг, уул уурхай, хөдөө аж ахуй, технологийн чиглэлээр ярилцлага өгөх боломжтой 400 гаруй эмэгтэй эх сурвалжийн мэдээллийн сан бүрдүүлсэн. Үүнийг нэгдлийн сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагуудад өгч, ашиглуулж байгаа.

Мөн Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс “Мэдрэмжтэй мэдээлье” редакцын менторшип хөтөлбөрийг өнгөрсөн оны зургаадугаар сараас хэрэгжүүлсэн бөгөөд GoGo.mn мэдээллийн сайт, “Зууны мэдээ” сонин, Архангай медиа группийн хамт олныг эхний ээлжинд амжилттай хамруулна. Хоёр сарын хугацаатай энэ хөтөлбөр нь редакцын удирдлагад бодлогын болон менежментийн зөвлөгөө өгч, хэвлэл мэдээллийн салбарт ялгарч, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, BBC-ийн 50:50 төсөл болон олон улсын бусад амжилттай туршлагаас судлах, суралцах, хамтран ажиллах боломж нээж өгөх зорилготой.

“Бид менторшип хөтөлбөрт хамрагдсанаар сониныхоо нийтлэлийн бодлогыг шинээр гаргахдаа жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай тусгасан. Хамгийн гол нь BBC телевизийн 50:50 төслийн түнш болсон нь бидний хувьд том дэвшил боллоо” хэмээн “Зууны мэдээ” сонины хариуцлагатай нарийн бичгийн дарга Х.Мөнхжаргал хэлэв. Эдүгээ “Зууны мэдээ” сонин дугаар болгондоо эх сурвалжийн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангахад

анхаарч ажилладаг болсон төдийгүй “Хэвшмэл ойлголтоо өөрчилъё”, “Эмэгтэйчүүдийн манлайлал” гэсэн хоёр булан шинээр нээж, тогтмол хөтөлж байгаа юм.

Түүнчлэн баг, хамт олны мэргэжлийн, ёс зүйн ур чадварыг дээшлүүлж, жендэрийн мэдрэмжтэй өнцгөөс мэдээлж, сурвалжлах, хэвлэл мэдээллийн бүтээлийн агуулга дахь жендэрийн тэгш бус байдал, хэвшмэл ойлголтыг халах мэдлэг, ур чадвар олгох нь хөтөлбөрийн чухал зорилтын нэг. “Менторшип хөтөлбөр бидний багаар ажиллах чадварыг нэмэгдүүлсэн. Зөвхөн сэтгүүлч, зураглаач зэрэг үндсэн мэргэжлийн ажилтнуудаас гадна менежер, эх бэлтгэгч, сумын сурвалжлагч гээд бүгд нэг түвшний ойлголт, мэдлэгтэй болсноор хамтын бүтээл сайжрах том хөшүүрэг болж байна” хэмээн Архангай медиа группийн захирал О.Амарзаяа тэмдэглэлээ.

Тэгвэл GoGo.mn BBC-ийн 50:50 төслийн албан ёсны түнш болсон төдийгүй эх сурвалжийнхаа хүйсийн тэнцвэрт байдлыг хадгалах зорилгоор “Тэнцвэр” санаачилга гаргаж, уншигчдадаа зарласан билээ. “Хөтөлбөрт хамрагдсанаар өдөр тутамд оруулж буй мэдээ, нийтлэл, сурвалжилгынхаа эх сурвалжийн хүйсийн тэнцвэртэй байдалд бүгд ижил оролцоотойгоор анхаарал хандуулж, юуны төлөө зорьж байгаа, энэ нь яагаад чухал гэдгийг олж харсан нь хамгийн чухал байлаа. Мөн хүйсийн тэнцвэрийг хэрхэн хангаж байгаа талаар бүртгэл хөтөлж эхэлснээр бид сэтгүүл зүйн бүтээлүүдээ үнэлж, дүгнэж, өөрчлөх боломжтой болсон” хэмээн GoGo.mn мэдээллийн сайтын ерөнхий редактор Р.Адъяасүрэн онцлов.

Эдүгээ редакцын менторшип хөтөлбөрийг MYONPT дээр хэрэгжүүлж байгаа бөгөөд ирэх жилээс илүү олон хэвлэл мэдээллийн байгууллага хамрагдах боломжтой. Ийнхүү сэтгүүл зүйд уншигч, үзэгч, сонсогчдоо бүрэн гүйцэд төлөөлөхүйц чанартай бүтээл хийх ур чадварыг төлөвшүүлж, иргэдийн хэвлэл мэдээлэлд итгэх итгэлийг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулахаар “Мэдрэмжтэй мэдээлье” нэгдэл ажиллаж байна. ■

Б.Оюунгэрэл: Монгол ЭМЭГТЭЙЧҮҮД ИЛҮҮ ЭРХ ХҮСЭЭГҮЙ

Б.САНЖААХАНД

Монголын эмэгтэйчүүдийн холбооны ерөнхийлөгч Б.Оюунгэрэлтэй ярилцлаа.

-Монголын эмэгтэйчүүдийн холбоогоор ойрд сонин сайхан юутай. Ямар ажилд илүү төвлөрч ажиллаж байна вэ?

Миний бие Монголын эмэгтэйчүүдийн холбооны ерөнхийлөгчөөр сонгогдоод дөрвөн жилийн нүүр үзэж байна. Ажил авснаасаа хойш жил бүр нэг сэдвийг онцгойлон авч үзэж агуулга дээр нь төвлөрч ажилладаг. 2019 онд “Хүчирхийллийн эсрэг хүн бүрийн оролцоо” буюу бага насны хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа бэлгийн хүчирхийллийн асуудлаар нийгэмд шүгэл үлээсэн. “Бүжингийн чимээгүй хашгираан” гээд Төрийн ордонд акц хийж байсан. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах таван санал гаргаад өнөөдрийг хүртэл явж байна. 2020 онд архины асуудлыг хөндөж “Архигүй баярын ширээ” гэсэн уриалга дэвшүүлж, архигүйгээр баяр ёслол тэмдэглэдэг зөв боловсон хэрэглээнд анхаарч, архитай нь биш тархитай нь ажиллах ёстой гэж үзсэн. Өнгөрсөн онд “Хаалга” акцыг зохион байгуулаад, хаалганы цаана үйлдэгддэг хүчирхийлэл бол гэмт хэрэг гэдгийг олон нийтэд ойлгуулахыг хичээсэн. Манайхан хүчирхийлэл гэдэг үгэнд дасал болчихсон байдаг. Гэтэл тэрний цаана хүний амь амьдрал, хувь заяатай холбоотой асуудал

яригддаг. Нөгөө талдаа Гэр бүлийн хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналууд гаргаад, өнөөдрийг хүртэл явж л байна.

-Танайх “Хавдаргүй монгол” төслийн хүрээнд юу хийж байгаа вэ?

Манайх энэ жил эмэгтэйчүүдийнхээ эрүүл мэндийн чиглэлд түлхүү ажиллая гээд “Хавдаргүй монгол эмэгтэй” нийгмийн зорилтот төслийг санаачлан хоёр аймагт ажиллалаа. Говь-Алтай аймагт нэг сар ажиллаж нийт 5884 эмэгтэйд хөхний болон умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэг оношилгоог хийсэн. Төслийн үндсэн зорилго эрүүл мэндийн боловсрол олгох юм шүү дээ. Мөн сумдын эмч нарт хавдрын эрт оношлогоо хийх ажлын байрны сургалт зохион байгуулсан. Төслийн хүрээнд үзлэг оношлогоо хийх байсан. Түүнчлэн үүгээр дамжуулж судалгаа хийх зорилготой.

“Хавдаргүй монгол” төслийн хүрээнд эмч нарын баг явахаас гадна соён гэгээрүүлэх ажлыг давхар зохион байгуулсан. Тухайлбал, ажилласан хоёр аймгийнхаа бүх суманд хөдөлгөөнөөр дамжуулаад эрүүл байх зөв дадал хэвшилд уриалж өглөө бүр 07:00 цагт сумдад зумбо фитнесс, аэробекийн

багшаар үйл ажиллагаагаа эхлүүлдэг байсан. Мээ Говь-Алтай аймгийн 18 суманд бүжиг, фитнессийн багшийг бэлдэж байна.

-Та орон нутгаар чамгүй явлаа. Хөдөө, орон нутагт эмэгтэйчүүдийн аж амьдрал ямар байна вэ?

Эмэгтэйчүүдийн аж ахуй эрхэлж, ажиллаж хөдөлмөрлөн сайхан амьдрах амьдралын төлөөх идэвх чармайлт орон нутагт ч гэсэн маш сайн байдаг. Гэхдээ нэг зүйл анзаарагдсан. Тэдэнд мэдээлэл дутагдалтай байгаа санагдсан. Сумдын түвшинд хөдөлмөр эрхлэлттэй холбоотой төрөөс өгч байгаа боломжуудыг тэд мэдэхгүй байна.

-Эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлд ямар санал хэлэх вэ?

Эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлт дээр хоёр асуудлыг хэлэх байна. Нэгдүгээрт, Батлан даалтын сан, Хөгжлийн банк, ЖДҮС-гаас олгож байгаа дэмжлэгийн зээлд ихэнхдээ эрчүүд хамрагддаг. Хэдийгээр жендэрийн ялгаа гаргаж эмэгтэйчүүдийг дэмжинэ гэж ярих ёсгүй ч албан ёсны хэллэгээр тусгай арга хэмжээ авах гэж үздэг. Жишээ нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалт 10 насны зөрүүтэй болчихлоо. Тэгвэл эрчүүдийн эрүүл мэндийг



Монголын эмэгтэйчүүдийн холбооны ерөнхийлөгч Б.Оюунгэрэл

хамгаалахын тулд тусгай арга хэмжээ авахыг үгүйсгэхгүй. Тэгвэл эмэгтэйчүүдийг эдийн засгийн хувьд чадавхжуулж, санхүүгийн хувьд бие даасан хараат бус байлгах түүгээр дамжуулаад жендэрт суурилсан хүчирхийллийг бууруулах талаар тодорхой хэмжээний тусгай арга хэмжээ авч болно. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих төрийн тусгай арга хэмжээ, хууль гаднын орнуудад байдаг. Тэгээд дэмжлэг тодорхой түвшинд хүрээд ирэхээр тэрийгээ цуцалчихдаг. Нөгөө талд бидний уламжлалт хэвшмэл ойлголт бий.

Өв хөрөнгийг зөвхөн хүүдээ өвлүүлдэг. Өмч хөрөнгө нөхрийн дээр бичигддэг. Жишээлбэл, малчид өрхийн тэргүүний нэр дээр мал нь тоологддог. Сүүлийн үед малчид эрүүл мэнд, нийгмийн даатгалын үйлчилгээнд тодорхой хэмжээнд хамрагдаж байна. Гэтэл эхнэрийн нэр дээр мал тоологдохгүй байгаа учраас эрүүл мэнд, нийгмийн даатгалын үйлчилгээ авч чадахгүй байна. Цөөн тооны малчин эмэгтэй сайн дурын даатгал төлж байна. Мөн өөрийн нэр дээр өмчгүй учраас малчин эмэгтэйчүүдэд зээл авах боломж бүрдэхгүй.

Цаашдаа эмэгтэйчүүдийг дэмжье гэвэл хамгийн наад зах нь эцэг эхчүүдэд охидод ч гэсэн өмч хөрөнгө өвлүүлдэг болох ойлголтыг өгөх ёстой. Хөрөнгөгүйгээсээ болоод эмэгтэйчүүд бие даасан шийдвэр гаргаж, санхүү хөрөнгө зарцуулах эрх эрх чөлөө нь хумигдаж байна. Түүний цаана хүчирхийлэлтэй холбоотой асуудал яригддаг.

Дараагийн асуудал ялангуяа хөдөө орон нутгийнхныг мэдээлэлжүүлэх шаардлагатай. Жишээ нь, өнгөрсөн жил Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр гэж батлагдсан. Гэтэл уг хөтөлбөрийн талаар орон нутагт огт мэдэхгүй байна. Мэдээлэл авлаа гэхэд төслөө бичиж чадахгүй. Төсөл хэрхэн бичих, хөтөлбөрт яаж хамрагдах талаар дахиад мэдлэг мэдээлэл өгөх хэрэгтэй болно. Төслийнхөө талаар мэдэж аваад, төслөө бичиж чаддаг болчихвол өөрөө хийгээд эхэлнэ. Иргэдийг мэдлэгжүүлж мэдээлэлжүүлэх нь маш чухал. Төрөөс маш олон хөтөлбөрүүд батлагдаж хэрэгжиж байна. Хөрсөн дээрээ буухгүй, хүмүүс мэдэхгүй байна. Мэдэхгүй хүн яаж оролцох вэ. Мэдээллийг нь өгөөд байхад оролцохгүй бол “хохь нь” гэхээс өөр яах вэ.

-Нийгэмд ялангуяа шийдвэр гаргах түвшний эрчүүдийн дунд эмэгтэй, эрэгтэй гэж ялгах хэрэггүй гэсэн хандлага байгаа ажиглагддаг. Яагаад эмэгтэйчүүдийг дэмжих ёстой вэ?

Манай эрчүүд ихэвчлэн ингэж ярьдаг. Эмэгтэйчүүд эрчүүдтэйгээ нийлээд архи ууж байна. Арабын хүүхнүүд шиг гивлүүр зүүхгүй байна. Дуртай ажлаа хийж байна. Та нарын ямар эрх хязгаарлагдаад байгаа юм бэ гэдэг. Гэтэл шийдвэр гаргах гэдэг асуудал өөр.Та ажил хийгээд цалин авч байгаа бол тэр мөнгөө юунд зарцуулахаа мэдэх эрх мэдэл өөрт чинь үүсч байна. Ажил хийхгүй байгаа, өвчтэй зовлонтой хүн асраад, тодорхой хугацаанд ажилгүй суухад эмэгтэй хүн нөгөө талын санхүүгийн хараат байдал руу ордог. Орлогогүй эмэгтэйд сая төгрөг өгсөн ч бай, 100 мянган төгрөг өгсөн ч бай тэр хүн тэгж зарцуулсан гээд заавал тайлбарлаж тайлагнах хэрэгтэй болдог. Манай эмэгтэйчүүд өнөөдөр цалингаа авчихаад дураараа үрээд байгаа зүйл байхгүй. Дуртай зайрмагаа өөрийн мөнгөөр авч идэх чинь эрх чөлөө шүү дээ. Тийм учраас эмэгтэйчүүдэд зориулсан тусгай арга хэмжээ авах шаардлагатай гэж хэлээд байгаа юм.

-Тусгайлсан арга хэмжээ гэснээс Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх хуулийн төсөл УИХ-д өргөн баригдсан байгаа шүү дээ. Тэр хуулийн төслийг та хэрхэн харж байна вэ?

Ер бол хууль бүх зүйлийн суурь учраас хуультай болчихсон байхад хэрэгжилтийг хангах тухай асуудал л яригдана. Гэтэл хуультай больё гэхээр нийгмээрээ эргээд доромжилдог. Өөрсдөдөө зориулж хууль хийх гэлээ, эмэгтэйчүүд яахаараа тусгайлсан хуультай болох ёстой юм гэх мэтээр. Гэтэл энд хэрэгцээ шаардлага нь байна. Өнөөдөр хуульгүй учраас боломж нөхцөл нь бүрдэхгүй байна. Олон улсад эмэгтэйчүүд рүү хандаж тусгайлсан арга хэмжээ авдаг. Түүнийг нь Монголд нутагшуулж болно шүү дээ. Гэхдээ Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн хуулийн томъёоллыг бид сайн харах хэрэгтэй. Эмэгтэй бизнес эрхлэгч гэж хэнийг хэлэх юм. Хэрвээ цоорхойтой хууль гарвал тэр хуулийн цоорхойг ашиглаад эрэгтэй бизнес эрхлэгч нь эмэгтэй рүүгээ шилжих асуудал гарах вий.

Мөн аж ахуй эрхлэгч гэдэг жагсаалтад

малчин эмэгтэйчүүдийг оруулмаар байна гэдэг саналыг гаргасан юм. Малчдыг бид малчин л гэж хараад байгаа. Энд бүхэл бүтэн үйлдвэрлэл явагдаж байна. Тэрийг бизнес гэж харахгүй байна. Тэгвэл малчныг бизнес ангилал руу оруулснаар маш том эдийн засгийн эргэлт нэмэгдэнэ. Тэр дундаа эмэгтэйчүүд. Би сүүлийн үед малчин эмэгтэйчүүдийн асуудлыг нэлээд ярьж байгаа. Монголын нийт хүн амын 10 гаруй хувь нь малчид. Үндсэндээ Монголын өв уламжлал, нүүдлийн соёлыг тэд тээж яваа. Монголын ондоошлыг харуулах салбар л даа.

Төрийн бодлого мал руу нь хэт анхаараад малчнаа огт хайхрахаа байчихсан. Малчдын хөдөлмөрийн 80 гаруй хувь нь эмэгтэйчүүдйн нуруун дээр байна. Үндсэндээ бол Монголын нүүдлийн соёл иргэншилд маш том аюул учирчихаад байна гэдгийг онцолмоор байгаа юм. 300 гаруй мянган малчны 40 хувь нь эмэгтэйчүүд. Өөрөөр хэлбэл, хүйсийн харилцаа алдагдчихсан байна гэсэн үг л дээ.

Өнгөрсөн жил КОИКА-аас хийсэн судалгаагаар “Та ирээдүйд охиноо малчин болгох уу, хүүгээ малчин болгох уу” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 27 хувь нь хүүгээ, 0.5 хувь нь охиноо гэсэн байсан. “Яагаад та охиноо малчин болгохгүй байгаа вэ” гэсэн дараагийн асуултад хөдөөд нийгэм соёл, эрүүл мэндийн үйлчилгээ авч чадахгүй байна гэсэн байна. Малчид хөдөлмөр хүнд гэж хэлээгүй. Зүгээр л нийгэмтэй харилцах харилцаа, мэдлэг мэдээлэл авах, хөрөнгө санхүүгийн хэрэгцээ байгааг илтгэсэн.

-Эмэгтэйчүүдийн манлайлал болон улс төрийн шийдвэр гаргах түвшний оролцооны талаар юу хэлэх вэ?

Эмэгтэйчүүдийг өмссөн хувцас, идсэн уусан зүйл, санамсаргүй алдаан дээр нь дөрөөлж нийгмийн сүлжээгээр яаж “цовдолж” болдог вэ гэдгийг бүгдээрээ харлаа. Гэтэл улсаа зарсан, эхнэр хүүхдээ хэдэн янзаар сольдог, хулгай дээрэм хийдэг, авлига авдаг хүмүүсийг бид яаж хамгаалж үлдэж байгааг бас л харж байна. Эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшний оролцоо зарим улсад 60 хувьд хүрсэн нь ч байна. Тийм улс буцаад эмэгтэйчүүдийн оролцоог 50 хувиас дээш гаргаж болохгүй гээд тусгай арга хэмжээ авах жишээтэй. Монгол эмэгтэйчүүд илүү эрх огт хүсээгүй. Ижил тэнцүү эрх л хүсэж байгаа. Ижил тэнцүү бизнесийн гараанаас хөдлөх, ижил тэнцүү боломжийг хүртэх, ижил тэнцүү шийдвэр гаргалтад оролцох. Түүнээс биш, дарга болох гээд эрэгтэйчүүдтэй сандал суудал булаацалдаад барьцаад байгаа асуудал огт биш. Эрэгтэй эмэгтэй хүмүүс байгалиас заяагдмал ялгаатай талтай. Асуудлыг харах өнцөг, харилцааны



Нандин хайрцаг

хүчирхийлэлтэй тэмцэх болон Хүүхэд хамгаалах хуулиа алдаа, оноотой ч бай баталлаа.

Монголчууд өнөөдөр эмэгтэйчүүддээ ээлгүй хандаж байгаа бол маргааш таны охинд энэ асуудал тулгарна гэж бод. Эргэлзээгүй зүйл. Яагаад гэвэл, таны “болно” гэж бодсон цагаас хүчирхийлэл түгэн дэлгэрч, та тэрийг өөгшүүлж байгаа оролцогч болоод явдаг юм шүү.

-МЭХ-ноос ерөнхий боловсролын сургуулиудад “Нандин” хайрцаг байршуулж байгаа юм билээ. Уг хайрцгийн талаар мэдээлэл өгөхгүй юу?

“Хавдаргүй Монгол” эмэгтэй төслийн хүрээнд “Нандин” нэртэй ариун цэврийн 200 ширхэг хайрцаг хийлгэж тараагаад сумын сургууль, дотуур байранд байршуулах уриалга гаргасан. Өнгөрсөн аравдугаар сарын 11-нд Олон улсын охидын эрхийг хамгаалах өдрөөр Төрийн ордонд “Нандин” гэсэн арга хэмжээг 331 сум, нийслэл дүүргүүдээс нийлсэн 1000 гаруй хүүхдийг оролцуулж зохион байгуулсан. Цаашид уламжлал болгон зохион байгуулах нь зөв юм байна гэдэг ойлголтыг өгсөн. “Нандин” арга хэмжээг “Ариун цэврийн хэрэглэл ичих зүйл биш” уриатайгаар хийсэн. Нийгэм даяараа ариун цэврийн хэрэглэлийг эмэгтэйчүүдийн хэрэглэл гэж хүлээж авдаг. Гэтэл үүний цаана жендэрт суурилсан хүчирхийллийг бууруулах соёл гэж ойлгож энэ ажлыг эхлүүлсэн. Харин “Нандин” хайрцаг сургуулийн анги танхим бүрт байршсанаараа хөвгүүдийг охидуудаа илүү ойлгож хайрладаг, хүндэлдэг, дэмждэг болгохын тулд уг хайрцаг нь нандин соёл тээгээд явж байгаа юм.



А.Солонго: Эмэгтэй бизнес эрхлэгчдэд тэгш боломж, адил түвшний гараа хэрэгтэй

Д.ОЮУНЧИМЭГ

“Бурамхан” брэндийн хатуу чихрийн үйлдвэрлэлийг үүсгэн байгуулагч “Цайдам трэйд” компанийн захирал А.Солонготой ярилцлаа.

Тэрбээр “Шарк Танк” нэвтрүүлэгт “Candy land” төслөөрөө оролцон амжилттай хөрөнгө оруулалт татсан юм.

-Таны энэ гоё амттаны бизнесийг анх яаж эхлүүлж, өнөөдрийн “Бурамхан” үйлдвэрийг бий болгов гэдгээс яриагаа эхэлье.

- Миний гэрийнхээ гал тогооны гурван литрийн саванд буцалгаж эхлүүлсэн чихрийн бизнес маань 30 гаруй ажлын байр бий болгож өнөөдрийн “Бурамхан”-ы хамт олныг бий болголоо. Хоногт нэг тонн чихэр үйлдвэрлэх хүчин чадалтай.

Сүүлийн жилүүдэд амаргүй цаг хугацааг өнгөрүүлж байна. Эхний ээлжинд тэсэж үлдэх нь бидний зорилго байсан. Жижиг, дунд үйлдвэрлэгчдэд валютын ханш, инфляцийн өсөлт хүндээр тусдаг хэдий ч цар тахалтай жилүүдэд чамгүй амжилттай ажилласан. Амаргүй байгааг тэр бүр яриад байхыг хүсэхгүй байна. Мэдээж хичээсний үр дүнд ямартай ч хэцүү үеэ даван тууллаа.

-Цар тахал бизнесийн

салбарын нэг хэсэгт нь маш хүнд туссан бол хүнсний компаниудад зэрэг нөлөөтэй байсан. Та ковидын үед ямар тактикаар ажилласан бэ?

-Аливаа зүйл хоёр ба түүнээс олон талтай. Цар тахлын үед хүн бүрт хүнд байсан боловч монголчууд үндэсний үйлдвэрлэлээ дэмжих ёстой. Импортын хараат байдлыг эрс бууруулах хэрэгтэй гэдэг мэссэжийг өгч чадсан. Энэ нь хүн бүрийн сэтгэл зүйд тодоор дүрслэгдэж үлдсэн гэж хардаг. Тэр дундаа хүнсний үйлдвэрлэл тэргүүн эгнээнд байх учиртайг ойлгуулж чадсан.

Хэдийгээр ковид маш том шок болсон ч манай улсын төр засаг

дорвитой арга хэмжээ авчээ гэж бодсон. Учир нь саяхан үйлдвэрлэгчдийн хамтаар Швейцарийн үйлдвэрлэлтэй танилцаад ирсэн. Тэдний шинэ санаа, амжилтын түүхээс хуваалцах завшаан олдсон хэрэг. Тэгж явах үед гадныхан ковидын үеэр танай улсын төр засаг ямар арга хэмжээ авсан бэ гэж асуусан. Бид эхлээд юу ч хийгээгүй гэгцээсэн ч дор бүрнээ ажлын байрыг хадгалж үлдэх гурван хувийн хүүтэй зээл, тог, цахилгааны төлбөрийг тэглэсэн, НДШ-ийн хөнгөлөлт зэрэг нэлээд ажлыг зохион байгуулсан гэдгийг эргэж санасан. Учир нь хүн бүр “Тэр үед ийм арга хэмжээ авсан” гэх мэтээр ярилцсаар багагүй ажил

Манай компани 200 жилийн настай байгаасай гэж хүсч байна. Учир нь манайх Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу бүх стандартыг хангасан нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч.



хийснийг нь бүгд дуу нэгтэй зөвшөөрсөн. Үүгээр юуг хэлэх гэсэн бэ гэвэл, бид ямарваа нэгэн дэмжлэг, тусламжийг тухайн цаг үетэй нь хамт мартчихдаг юм байна. Харин олуулаа ярилцаад суухаар хүн бүрт өөрт нь ойрхон туссан зүйлээ мартдаггүй юм байна гэдгийг анзаарсан.

-Төр засгаас гарч байгаа бодлого, шийдвэр зорилтот бүлэгтээ хүрч чадахгүй байгаа нь гарах эерэг үр дүн, өгөөжийг

Гэхдээ эмэгтэй хүн юугаараа ч давуу биш бас сул биш. Эмэгтэй, эрэгтэй гэж ялгалгүй тэгш харилцаа л хэрэгтэй. Үүний тулд хүмүүсийн хандлага нь орчин үетэйгээ нийлж өөрчлөгдөх ёстой. Тиймээс эмэгтэй бизнес эрхлэгчдэд тэгш боломж, адил түвшний гараа өгөх хэрэгтэй гэж боддог.

бууруулдаг гэж хардаг. Таны бодлоор?

-Санал нэг байна. Тухайлбал, зорилтот хөтөлбөрүүд нь “бай”-гаа оновол гарах үр дүн маш сайн байна. Хэрэв буруудвал сөрөг үр дагавартай. Цар тахлын үед ажлын байрыг хадгалах гурван хувийн хүүтэй зээлд манай компани хамрагдсан. Авсан зээлээ яг горимын дагуу зарцуулсан. Түүнчлэн зээлээ графикайн дагуу төлж барагдуулах үүргээ ухамсартайгаар биелүүлж байна. Магадгүй зорилгоо гажуудуулаад үнэтэй тансаг машин аваад уначихсан бол би үйлдвэрлэлээ дампуурлын ирмэгт хүргэх байсан байх. Харин зориулалтын дагуу зарцуулсан учраас хүнд цаг үеэ даван туулж үйлдвэрлэл маань тогтвортой ажиллан цаашид илүү өргөжин хөгжих боломжийг нээж байгаа юм.

Тэгэхээр сонгон шалгаруулалт бодит эзэндээ хүрч чадвал гарах үр дүн өгөөжтэй байна. Харин танил тал харах эсвэл зориулалтын бусаар зарцуулах нь эрсдэл дагуулахын сацуу үйлдвэрлэлийг дампууруулах шалтгаан болно л доо. Мэдээж олон дунд сайн муу зүйл бишгүй гарна.

-Монголд бизнес эрхлэхэд тийм ч амар биш. Тэр дундаа компанийн захирал эрэгтэй, эмэгтэй хүн байх нь ялгаатай байдлыг үүсгэдэг тухай ярьдаг. Ялангуяа эмэгтэй бизнес эрхлэгчид илүү хүнд, бартаатай зам туулж байна гэдэг шүү дээ. Та ямар бодолтой байдаг вэ?

-Миний бодлоор эмэгтэй бизнес эрхлэгчид эрчүүдийг бодвол илүү хариуцлагатай, нандин чанартай байдаг гэхэд дэгсдүүлсэн болохгүй байх. Үүнийг хүн бүр л хэлдэг. Жишээлбэл, банкны зээл төлөлтөд хариуцлагатай ханддаг нь эмэгтэйчүүд. Мөн ажилчдынхаа нийгмийн асуудалд түлхүү анхаардаг нь ч эмэгтэй бизнес эрхлэгч. Гэхдээ эрчүүд муу, хариуцлагагүй, ажилчдынхаа нийгмийн асуудалд анхаардаггүй гэж бодохгүй байна. Тэд аливаа зүйлийг том зургаар нь далайцтай харж ажлаа эрхэлдэг бол эмэгтэйчүүд жижиг чимхлүүр ажлыг ч орхигдуулахгүйгээр шийдвэрлэж урт хугацааг туулдаг гэж болно. Түүнчлэн эрэгтэй захиралтай амжилттай яваа бизнесийн ард маш сайн санхүүч эмэгтэй ажиллаж байгаа гэдэгт итгэдэг.

Гэхдээ эмэгтэй хүн юугаараа ч давуу биш бас сул биш. Эмэгтэй, эрэгтэй гэж ялгалгүй тэгш харилцаа л хэрэгтэй. Үүний тулд хүмүүсийн хандлага нь орчин үетэйгээ нийлж өөрчлөгдөх ёстой. Тиймээс эмэгтэй бизнес эрхлэгчдэд тэгш боломж, адил түвшний гараа өгөх хэрэгтэй гэж боддог.

-Онцолж асуумаар байна л даа. Учир нь та өрхийн үйлдвэрлэлийг массынх болгож чадлаа шүү дээ. Тэгвэл гарааны бизнест төрийн дэмжлэг хэрэгтэй гэхээр санхүүгийн эх үүсвэр гэж хэт өрөөсгөл ойлгож, хандах юм?

-Бизнес эрхлэнэ гэдэг тэр дундаа үйлдвэрлэл хөгжүүлнэ гэдэг үнэхээр хүнд. Тэгэхээр жижиг, дунд, бичил бизнест татварын ялгаатай бодлого хэрэгжүүлж дэмжих учиртай. Жижиг бизнес эрхлэгч атлаа томчуудтай адил хэмжээнд л татвар төлж байна. Харин ялгаатай татвар хэрэгжүүлэхдээ ангилалаа оновчтой тодорхой байлгах ёстой. Учир нь манай “томчууд” хөнгөлөлтөд хамрагдахын тулд компаниа жижиглээд дунд орчихдог жишээ бий.

Муухай монгол хүний араншин гэх үү. Эсвэл хувиа бодсон чанар гэх үү. Энэ зүйлийг одоо бүрмөсөн өөрчлөх зайлшгүй шаардлага бий. Үүний тулд том, жижиг гэдгээ зөв тодорхойлоод өөрсдийнхөө нөөц бололцоонд тулгуурласан татвар төлдөг. Тэр ч бүү хэл, хамтарч ажилладаг. Бие биедээ зөвлөн тусладаг байх нь илүү өгөөжтэй болов уу. Магадгүй хоорондоо хамтарч ажилласнаар экспортын хэмжээ өсч бодит хөрсөнд ажил хэрэг болно л доо.

-Монголчууд бүхий л зүйлийг өөрөө л хийчихвэл болчихно гэж боддог. Манай



томоохон компаниуд ороогүй салбар гэж алга. Тэгэхээр хамтран ажиллана гэдэг юу л бол?

-Монголчууд гурван сая гаруйхан ам бүлтэй. Дээрээс нь импортоос хамааралтай хэрэглээтэй. Гэтэл бизнес эрхлэхдээ шуудайд хийсэн үхрийн эвэр шиг хэзээ ч хоорондоо эвлэрч, нэгдэж чаддаггүй. Бид дотооддоо хөлөө жийлцэж суухын оронд томчууд нь жижиг дундтайгаа нэгдээд чухам ямар саад бэрхшээл тулгарвал хэрхэн давах туулах талаар зааж, зөвлөж болно шүү дээ. Мөн алдааг дахин давтахгүй байхын тулд ямар гарц шийдэл байгаа талаар ч зөвлөж болно. Өөрөөр хэлбэл, чихрийн

томоохон үйлдвэртэй бид хамтарч ажилладаг гэж бодъё. Тэгвэл чихэр хийхэд ямар арга зам байна. Урт хугацаа шаардах бол түүнийг нь товчлох арга бий юу гэхчилэн тулгарч болох саад бэрхшээлийг хэрхэн даван туулах, магадгүй хийсэн алдааг нь давтахгүй байх талаар ярилцаж болно шүү дээ.

-Эмэгтэйчүүдийн манлайлал гэж юуг хэлэх вэ, таныхаар?

-Эмэгтэйчүүдийн санасан ажил бүтэж байгаа бол “Бүтсэнгүй ээ” гэж хэлэх хүн олдохгүй гэж боддог. Манлайлал гэдэг нь хүчирхэг байхыг хэлж болно. Мөн өөрөө үлгэрлэн дууриалгах “луужин” байх ёстой. Бусдын хайр хүндлэлийг хүлээсэн өөрийнхөөрөө хүчирхэг байхыг хэлэх болов уу.

-Танай компанийн ирээдүйн зорилго?

-Манай компани 200 жилийн настай байгаасай гэж хүсч байна. Учир нь манайх Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу бүх стандартыг хангасан нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч. Бид дэлхийн бизнес болохыг зорьж байгаа. Үүний тулд тэгээс эхлүүлсэн бизнесээ бага багаар ахиж, урагшлуулахыг хүсч байна.

Эмэгтэйчүүд хүчтэй байж нэгнийгээ дэмждэг байгаасай гэж боддог. ■



Б.Эрдэнэдэлгэр: Жижиг, дунд бизнесийн зээлийн 51 хувийг эмэгтэй бизнес эрхлэгчдэд олгосон байна

ХААН Банкны Гүйцэтгэх захирлын орлогч
Б.Эрдэнэдэлгэртэй ярилцлаа.

-Тогтвортой санхүүжилт гэж юуг хэлж байна вэ. Тогтвортой, урт удаан хугацаанд санхүүжилтээр хангах тухай ойлголт юм уу, эсвэл эх дэлхийдээ ээлтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийг дэмжихийг хэлээд байна уу?

Аль аль нь энэ ойлголтод хамаарна. Дэлхий нийтээр уур амьсгалын өөрчлөлт эрчимтэй явагдаж буй энэ цаг үед бизнес эрхлэгчдийн өмнө байгальд ээлтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах хэрэгцээ шаардлага улам бүр нэмэгдэж байна. Банк санхүүгийн салбар санхүүгийн хөшүүргээр дамжуулан иргэд болон бизнесийн эко хэрэглээг нэмэгдүүлэх, хүлэмжийн хийн

ялгарлыг бууруулах бизнесийн аливаа төсөл, хөтөлбөрүүдийг ногоон зээлээр санхүүжүүлдэг. Мөн үүнээс гадна ХААН Банкны хувьд 100 сая төгрөгөөс дээш дүнгээр олгож буй бүх төрлийн бизнесийн зээлүүддээ байгаль орчин, нийгэмд үзүүлэх эрсдэлийн үнэлгээ хийдэг. Эрсдэлийг нь бууруулах шаардлага тавих замаар хариуцлагатай бизнесийг санхүүжүүлж, ингэснээрээ ногоон эдийн засгийг дэмжиж, Тогтвортой хөгжлийн зорилгуудад хувь нэмрээ оруулж байна. Үүнийг л Тогтвортой санхүүжилт буюу ногоон санхүүжилт гэж нэрлэж буй. Мэдээж санхүүгийн зуучлалын үйлчилгээ үзүүлдэг байгууллагын хувьд банк тогтвортой санхүүжилтийг хэрэгжүүлэгч гол оролцогч тал

болж байна. Өөрөөр хэлбэл, зээл, санхүүжилт олгохдоо тухайн бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа байгаль орчин, нийгэмд ямар нэгэн хор нөлөөгүй, эрсдэл багатай байхыг үнэлэх, эрсдэлийн түвшнээс хамааран тухайн учруулах хор нөлөөг багасгахад анхаарч ажиллах үүрэг хүлээж буй юм.

-Санхүүгийн байгууллагууд өнгөрсөн 10 жилийн турш тогтвортой санхүүжилтийг хэрэгжүүлж байгаа хэдий ч өнөөдрийн байдлаар ногоон зээлийн хэмжээ нийт багцын хоёр хүрэхгүй хувийг эзэлж байна. Нийт олгож буй зээлийн дүнгээр ХААН Банк системийн хэмжээнд гуравны нэг хувийг эзэлдэг. Үүнээс ногоон зээлийн олгож буй хувь хэмжээ ямар байгаа бол?

ХААН Банк Монголын тэргүүлэгч банкны хувьд зах зээлд эзэлж байгаа нийт хувь хэмжээ, активын болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээгээр системийнхээ 34 орчим хувийг эзэлж байна. Зээлийн багцад эзэлж байгаа хувь хэмжээ мөн ижил. ХААН Банкны хувьд харилцагчдадаа есөн төрлийн ногоон зээлийн бүтээгдэхүүн санал болгож байгаагаас энэ оны III улирлын байдлаар 75 тэрбум төгрөг буюу банкны системийн хэмжээний нийт ногоон зээлийн 24.5 орчим хувийг дангаар бүрдүүлж байна. Тухайлбал, бид тогтвортой хөдөө аж ахуй, бэлчээрийн чанар, мал, амьтны эрхийг зөрчихгүй байхад анхаарч үйл ажиллагаа эрхэлж буй хариуцлагатай мал аж ахуй болон эко аялал жуулчлалыг дэмжих, ногоон барилга барих эрчим хүчний үр ашгийг бий болгох замаар хэмнэлт үүсгэж, урт хугацаанд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах нь уур амьсгалын сөрөг нөлөөллийг багасгах боломж гэж үзэж байна. Энэ ч үүднээс эрчим хүчний үр ашиггүй хэрэглээг хамгийн багадаа 20 хувиар бууруулах бизнесийн үйл ажиллагааг тааламжтай нөхцөлөөр, ногоон зээлийн бүтээгдэхүүнээр санхүүжүүлж байна.

-Өнгөрсөн хугацаанд тогтвортой санхүүжилтийн чиглэлээр гадны байгууллагуудаас танай

банк нэлээд хэмжээний эх үүсвэр татсан. Энэ талаар тодруулахгүй юу?

ХААН Банк нь 2015 оноос хойш нийтдээ 118 сая ам.долларын ногоон санхүүжилтийг EBRD, FMO, responsAbility (Global Climate Partnership Fund) зэрэг гадны санхүүгийн байгууллагуудаас татсан. Эдгээр санхүүжилтийг сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлт бүхий бүтээгдэхүүн үйлчилгээ, дахин боловсруулалт, хог хаягдлын менежмент болон ногоон барилга байгууламжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дотоодын аж ахуйн нэгж, иргэдэд бизнесийн болон хэрэглээний зээлийг тогтвортой олгож үйл ажиллагааг нь дэмжин ажиллаж байна. Тухайлбал, 2021 онд GCPF болон FMO-гоос татсан эх үүсвэрээр хөдөө аж ахуй, зочлох үйлчилгээний салбар, барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй харилцагч байгууллагуудад 19.5 тэрбум төгрөгийн зээл олгоод байна. Мөн бид саяхан ЕСБХБ-тай 70 сая ам.долларын урт хугацаат санхүүжилтийн гэрээ байгууллаа. Энэ гэрээний хүрээнд нийт 60 сая хүртэлх ам долларыг байгаль орчинд ээлтэй ногоон зээлийг санхүүжүүлэх, 10 сая ам.долларыг Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор ХААН Банканд олгоод байна. Олон улсын байгууллагууд сүүлийн жилүүдэд эх үүсвэр олгож буй байгууллагуудынхаа үндсэн бизнесийн ашигт ажиллагаанаас гадна тогтвортой санхүүжилтийн чиглэлээр юу хийж байна вэ гэдэгт онцгой анхаарч, шалгуур үзүүлэлт тавих болсон. Өөрөөр хэлбэл, Монгол шиг хөгжиж буй оронд санхүүгийн эх үүсвэр олгохдоо санхүүгийн болон санхүүгийн бус маш олон үзүүлэлтээр шалгаж, тухайн санхүүжилт авч буй байгууллага нь хэр тогтвортой үйл ажиллагаа явуулж байгааг чухалчилж үздэг болсон.

-Тухайлбал, ямар томоохон төслүүдийг хэрэгжүүлээд байна вэ?

Тогтвортой санхүүжилтийн

хүрээнд Европын сэргээн босголт хөгжлийн банк (ЕСБХБ)-наас Монгол Улсад тогтвортой эрчим хүчний хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор MON-SEFF төслийн зээлийг олгож эхэлсэн. Эрчим хүчний зохистой хэрэглээг бий болгох, хэмнэх, сэргээгдэх эрчим хүч болон ногоон эдийн засгийг дэмжих үндсэн зорилготой тус хөтөлбөрийн хүрээнд ХААН Банк 2015 оноос хойш нийт 24 харилцагчид 37,3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. Өнөөдөр эдгээр бизнес эрхлэгчид хөнгөлөлттэй нөхцөлөөр ХААН Банкнаас санхүүжилт авч, бизнесээ өргөжүүлэн, дэлхийд гарах том зорилгоо биелүүлэхээр ажиллаж байгаад бид талархаж байна.

Өнгөрсөн онд ХААН Банк Швейцарь улсад төвтэй хөрөнгө оруулалтын менежментийн компани “responsAbility Investments AG”-ийн удирдаж буй хөрөнгө оруулалтын сан болох Дэлхийн уур амьсгалын хамтын ажиллагааны сан (ДУАХАС)-тай урт хугацааны зээлийн гэрээ байгуулж, нийт таван сая ам.долларын санхүүжилт авч, 2022 онд дахин найман сая ам.долларын эх үүсвэрийг дахин татсан. Үүнийг хүлэмжийн хийн ялгаруулалтыг хамгийн багадаа 20 хувь бууруулах эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүнүүд болон сэргээгдэх эрчим хүчний төсөл, эко тээвэрлэлт, ногоон барилга байгууламж зэрэг чиглэлүүдийг санхүүжүүлэхэд зарцуулж байна. Энэхүү зээлийн хувьд харилцагчийн бизнес төсөлд хөндлөнгийн зөвлөх үйлчилгээний байгууллага дүгнэлт гарган, зөвлөмж өгч хамтран ажилладгаараа онцлог юм. Түүнчлэн 2021 оны есдүгээр сард Европын таван хөгжлийн банк болон санхүүгийн байгууллагаас ХААН Банканд нийт 120 сая ам.долларын, 5-7 жилийн хугацаатай санхүүжилт олгосноос 20 сая ам.доллар нь ногоон зээлийг санхүүжүүлэхэд зарцуулж байна. 2018 оноос хойш жил бүр дэлхийн ногоон санхүүжилт олгогч банк санхүүгийн байгууллагуудын шилдэг сайн туршлага, үр дүн, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг

оруулж буй хувь нэмрийг үнэлэн шилдэг банкуудыг шалгаруулсаар ирсэн. Энэ онд ХААН Банкны ногоон санхүүжилтийн чиглэлээр хэрэгжүүлсэн ажлууд, санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнг үнэлэн Ази, Номхон далайн бүс нутгийн шилдэг ногоон санхүүжилт олгогч банкаар шалгаруулсан сайхан мэдээг бид хүлээн авлаа.

БОАЖЯ-тай хамтран хөнгөлөлттэй нөхцөлөөр “Ногоон зээл” бас олгодог байх аа?

Тийм ээ. Өмнө дурдсанчлан гадаад эх үүсвэрээс буюу олон улсын санхүүгийн байгууллагуудын санхүүжилтээс гадна банкны өөрийн эх үүсвэрээр болон БОАЖЯ-тай хамтарсан хөтөлбөрүүдийн хүрээнд мөн “Ногоон зээл”-ийг санхүүжүүлж байна. Тухайлбал, 2019 оноос БОАЖЯ-ны Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороотой хамтран “Агаар орчны бохирдлыг бууруулах ногоон зээл”-ийн бүтээгдэхүүн гаргаж, гэр хорооллын айл өрхийн агаар, хөрсний бохирдлыг бууруулахад чиглэсэн 14 төрлийн зориулалтын дагуу 2-8 хувийн хүүтэй ногоон зээл олгосон. 2020 онд ХААН Банк ногоон бизнес эрхлэгч ААН, иргэдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор өөрийн эх үүсвэрээр санхүүжүүлэн зах зээл дэх бусад төрлийн бүтээгдэхүүнээс илүү таатай нөхцөл бүхий бизнесийн ногоон зээлийн шинэ бүтээгдэхүүнүүд гаргасан. Үүнд, ногоон эргэлтийн хөрөнгийн зээл, ногоон хөрөнгө оруулалтын зээл, ногоон санхүүгийн түрээс, ногоон бизнесийн зээлийн шугам, Тогтвортой ноос, ноолуурын нийлүүлэлтийг дэмжих ногоон зээлийг нэрлэж болно.

-Ногоон зээлийн амжилттай хэрэгжиж байгаа жишээ татахгүй юу?

Тогтвортой хөгжлийг цогцлооход санхүүгийн салбар чухал үүрэг гүйцэтгэж буй тул ХААН Банк энэ жил хийсэн брэндийн шинэчлэлдээ “Тогтвортой хөгжилд манлайлагч банк байна” гэж үнэт зүйл, стратегидээ тусгасан байгаа. Энэ ч үүднээс эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, ►

үйлчилгээг санхүүжүүлэх зэргээр уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг дэмжсээр байна. Үүний нэг жишээ бол бид Монгол Улсын нарийн ногооны дотоодын хэрэгцээг хангах бүрэн автомат өвлийн хүлэмжийн төслийг ногоон зээлээр санхүүжүүллээ. “Төгс ургац” ХХК-ийн орчин үеийн, дэвшилтэт, ухаалаг технологитой голланд загварын бүрэн автоматжсан, дөрвөн улирлын хүлэмжийн төсөлд 12 тэрбум төгрөгийн ногоон зээлийг таван жилийн хугацаатай, хамгийн тааламжтай нөхцөлөөр олгосон. Жилийн аль ч улиралд ургац авах боломжтой энэ хүлэмжийн төслийг санхүүжүүлснээр харилцагч өөрийн үйл ажиллагаандаа 24 хувийн эрчим хүчний хэмнэлт, нүүрсхүчлийн хийг 50 хүртэл хувиар бууруулах үр өгөөж гаргахаас гадна импортыг орлох, эрүүл, баталгаатай хүнс иргэдэд хүрэх боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Ногоон санхүүжилтийн хүрээнд бид эрчим хүч, усны хэмнэлт бүхий дулаан алдагдал багатай ногоон барилга барих болон “хуучин” барилгын дулаан алдагдлыг бууруулах үйл ажиллагааг санхүүжүүлж байна.

-Олон улсаас татсан эх үүсвэрийн 10 сая ам.долларыг Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд зарцуулна гэж та түрүүн хэлсэн. ХААН Банкны хувьд байгууллага доторх болон гадагш чиглэсэн үйл ажиллагаандаа жөндөрийн эрх тэгш байдал, хүртээмжийн асуудлыг хэрхэн авч үзэж байна вэ?

Манай банкны хувьд нийт ажилтны 67 хувь, удирдах түвшний ажилтны 56 хувь, гүйцэтгэх удирдлагын багийн 45 хувь нь эмэгтэйчүүд байна. Гүйцэтгэх удирдлагын хувьд жөндөрийн тэгш байдал гэдгийг аль ч хүйсийн хүн бай, тэгш эрх, тэгш боломж олгох бодлого баримталдаг. Өөрөөр хэлбэл, ур чадвартай, зөв хандлагатай, үнэхээр өөрөө хичээл зүтгэлтэй бол ямар ч хүн удирдах түвшний

албан тушаал хаших, сургалт хөгжлийн арга хэмжээнд хамрагдах боломжууд нээлттэй. Харилцагч талаас харвал, манай нийт зээлийн багцын 48 хувийг эмэгтэйчүүд, ЖДБ-ийн зээлийн 51 хувийг эмэгтэй бизнес эрхлэгчдэд олгосон байна. Иргэдийн банкны нийт зээлийн 47 хувь, хадгаламж эзэмшигчдийн 48.5 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа нь монгол эмэгтэйчүүд санхүүгийн хувьд харьцангуй чадавх сайн байгааг харуулж байна. Харин эсрэгээрээ бизнесийг удирдаж байгаа нөхцөлөөр нь ангилан харвал, нийт зээлийн багцын 70 хувь, ЖДБ-ийг удирдаж буй хүмүүсийн 72 хувийг эрчүүд эзэлж байгаа нь гүйцэтгэл, менежмент талдаа эрчүүд давамгай байгааг харж болно. Ийм ч учраас манай ЖДБ-ийг дэмжих төвөөс өнгөрсөн онд Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 400 харилцагчийг Дэлхийн түвшний менежер, сегментийн зэрэглэл ахиулах хөтөлбөр, Бизнесийн менежментийн цогц сургалтад хамрууллаа. Энэ хүрээнд мөн туршлага солилцох хоёр удаагийн арга хэмжээ зохион байгуулж, тэднийг чадавхжуулах шат дараатай алхмуудыг хийж ажиллалаа. Үүнээс гадна нийгмийн хариуцлагын хүрээнд Эмэгтэйчүүдийг дэмжих хөгжлийн хөтөлбөрийг 2021 онд хэрэгжүүлэн 120 асрагч, сувилагчдыг хамруулсан бол “Охидын код бичих хөтөлбөр”-ийн дөрвөн оролцогчид тэтгэлэг олгон, нэг оюутныг ажлын байранд дадлага хийлгээд байна. Мөн өрх толгойлсон 20 эмэгтэйг “Өрх гэр-Ногоо” төсөлд хамруулан хашаандаа ногоо тарьж борлуулах боломж олгосон гэхчилэн цөөнгүй ажлыг дурдаж болно.

-Цаашдаа ХААН Банк ногоон санхүүжилтийн чиглэлээр ямар бодлого баримталж ажиллах вэ?

Өнгөрсөн онд манай банк өөрийн ногоон зээлийн үйл ажиллагаа, зээл олгох чадамж болон ногоон зээлийн зах зээлийн боломж нөөцийг тодорхойлуулах зорилгоор Германы зөвлөх үйлчилгээний компаниар үнэлгээ хийлгүүлэн сайжруулах чиглэлүүдээ тодорхойлуулсан.

Цаашид ХААН Банк Тогтвортой санхүүжилтийг бүрэн хэрэгжүүлэхэд банкны үйл ажиллагаа, бодлого журамд байгаль орчин, нийгэм, засаглалтай (ESG) холбоотой эрсдэлүүдийг таних, бууруулах арга хэмжээнүүдийг тодорхойлох, хэрэгжүүлэх, үнэлүүлэх шаардлага үүсэж байна. Үүнтэй холбоотойгоор Олон улсын зээлжих зэрэглэлийн агентлагууд болон үнэлгээний байгууллагаар үнэлүүлэхээр төлөвлөж байна. Мөн энэ оны гуравдугаар сарын 29-30-нд зохион байгуулагдсан “Ногоон санхүүжилт бүс нутгийн чуулган”-ы үеэр Монгол Улсын Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга болон Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлаас бүрдсэн Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл “Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг”-ийг баталсан. Уг замын зургийг баталснаар 2030 он гэхэд ногоон зээлийн хэмжээг банкны салбарт 10 хувьд хүргэх, цаашлаад Монгол Улсыг бүс нутагтаа тогтвортой санхүүжилтийн мэдлэг, манлайллын төв болгох зорилт дэвшүүлсэн. ХААН Банкны хувьд энэ зорилтод хүрэх бүрэн боломж, нөөц бололцоо бий гэж харж байна. Дунд хугацаандаа буюу 2025 он гэхэд бид зээлдэгчийн уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх үр нөлөө, түүнд авсан арга хэмжээний үр ашгийг бие даан хэмжих, банкны өөрийн багцад эзлэх ногоон зээлийн багцыг хамгийн багадаа 10 хувьд хүргэхээр төлөвлөөд байна. Үүний тулд бид Ногоон зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг төрөлжүүлэх, орон нутгийн онцлогийг харгалзан ногоон зээлийн бүсчилсэн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, тогтвортой санхүүжилт, ногоон зээлийн ойлголтыг бизнес эрхлэгч аж ахуйн нэгж, эмэгтэй бизнес эрхлэгчид, иргэд гээд өргөн цар хүрээг хамруулж, таниулахаас гадна байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн үнэлгээний тогтолцоог илүү сайжруулж ажиллах чиглэлд онцгой анхаарал хандуулж байна. ■

Ш.Ариунаа: Аль ч хэсэгт эмэгтэйчүүдийн оролцоо чухал

А.АРИУНЖАРГАЛ

Монголын Эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбооны тэргүүн Ш. Ариунаатай ярилцлаа.



-Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудалд яагаад анхаарал хандуулах болов. Танай байгууллага хэдийд байгуулагдсан бэ?

Магистрт сурч байхдаа ангийн хэсэг эмэгтэйчүүдтэй ярьж байгаад энэ байгууллагыг бий болгосон юм. Яагаад гэвэл, бид бүгдээрээ бага насны хүүхэдтэй, ажил хийдэг, сурдаг хүүхнүүд байсан. Тэгээд л “Энэ нийгэмд хүүхэдтэй, ажилтай, тэгээд сурдаг ээж хэцүү шүү гэж ярилцан “Энэ асуудлыг бүгдээрээ шийдье. Бид нар шиг асуудалтай

ээж олон байгаа шүү дээ” гээд 2014 онд байгууллагаа үүсгэн байсан түүхтэй.

-Завгүй ээжүүд асуудал шийдэх ажлаа юунаас эхэлсэн бэ?

Анхны ажлаа “Эмэгтэйчүүдэд ээлгүй нийгэм байна. Цэцэрлэгийн тарах цагийг өөрчлөх асуудлаар хэвлэлийн бага хурал хийсэн. Бидэнд ямар нэгэн мөнгө төгрөг, өрөө танхим юу ч байгаагүй, тэр үед. Ер нь эмэгтэйчүүд хүүхдээ харах, ажил хийх аль алийг хүсч байгаа асуудал дээр бид

санал зөрөлдсөн. Нэг хэсэг нь эмэгтэйчүүд чинь хүүхдээ хараад гэртээ суух сонирхолтой байгаа юм биш үү гэсэн. Нөгөө хэсэг нь тийм ч гэсэн ажлаа хиймээр байгаа юм биш үү гээд. Тэгээд үүнийг шийдэхийн тулд “Эмэгтэйчүүд ба ажил эрхлэлт” чуулганыг 2015 онд хийсэн. Тус чуулганаас “Эмэгтэйчүүд хүүхдээ өсгөж хүмүүжүүлэнгээ ажлаа хиймээр байна” гэсэн үр дүн гарсан. Ингээд л эмэгтэйчүүд хүүхдээ харангаа ажил хийх боломж юу байх вэ гэдэг хүслийн жагсаалт гаргаж



ажилдаа шуударсан даа. Эрх зүйн таатай орчин хэрэгтэй. Ажил олгогчын зүгээс таатай хандмаар байна. Ажлын цагийг зүй зохистой зохицуулмаар байна. Зайнаас ажиллах хэрэгтэй байна гэсэн хэд хэдэн шаардлагыг нийгэмд танилцуулж эхэлсэн. Ковидоос өмнө зайнаас ажиллах шаардлагыг нэг ч байгууллага хүлээж аваагүй. Харин цар тахлын үед нийгмээрээ цахимаар ажиллаж болох дадалд суралцлаа шүү дээ.

Энэ хооронд юу хийсэн бэ гэвэл, Цагаандавааны хогийн цэг, Нарантуул зах болон гадаа талбайд худалдаа наймаа эрхэлж буй эмэгтэйчүүд, малчин эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрх хэрхэн зөрчигдөж байгаа талаар санал асуулга, жижиг судалгаа явуулж, баримтжуулсан. Энэ судалгааны дүнгээ Засгийн газарт танилцуулахад “Монголд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй адилхан хөдөлмөр хийх ёстой. Асуудал байхгүй шүү дээ” гэсэн утгатай албан бичиг ирсэн. Ингээд бид энэ чинь юу болоод байна вэ,төр ингэж бодож байгаа бол юу ч өөрчлөгдөхгүй. Тиймээс бусад төрийн бус байгууллагатай хамтраад ажлын байр, бэлгийн дарамтын талаар олон төрлийн сургалт, судалгаа нөлөөллийн ажлууд хэдэн парламент дамнаад хийлээ.

Тэрний хүчинд Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт орсон.

-Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг батлуулахад та бүхний оролцоо их байсан гэж сонссон. Ямар ажлууд хийж, хөтөлбөртэй болох үр дүнг гаргасан бэ?

Дээр ярьсан нөлөөллийн ажлуудын үр дүн. Ялангуяа нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин сүүлийн 10 гаруй жил тухайн насны эрчүүдээс 15 гаруй функтын зөрүүтэй гарч, 2030 он хүртэл өөрчлөгдөхгүй үр дүн харагдсан. Яагаад гэвэл, 2030 он хүртэл хүн амын дийлэнх нь нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд эзлэх учраас төрөлт ихсэх нь тодорхой. Бага насны хүүхэдтэй шалтгаанаар ажиллах хүчнээс гадуур тооцогдсон эмэгтэйчүүд 2018 онд 78 мянга байсан бол 2020 оны тоогоор 110 мянга болж өссөн. Тэгэхээр төрийн бодлогоор тусгай арга хэмжээ авахаас өөр аргагүй. Энэ асуудлыг нааштайгаар шийдвэрлүүлэхийн тулд Хүний эрхийн зөвлөлд илтгэл, тайлан илгээх зэргээр ажиллаж, НҮБ-ын индэр дээрээс Монгол Улсад эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхэд тусгайлан анхаарч ажиллах зөвлөмж өгүүлсэн юм.

-Танай холбооноос “Тайгын бэрүүд” төслийн хүрээнд ямар ажлуудыг хийж байна вэ?

Дэлхий даяар уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэл бууруулах чиглэлд анхаарал хандуулж, үүнд эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг ашиглах стратеги гаргаж, ГАГГА хөдөлгөөн өрнөсөн, манай байгууллага энэхүү хөдөлгөөнд нэгдсэн. Манай холбоо Хөвсгөл аймагт салбартай учраас “Уур амьсгалын өөрчлөлт ба эмэгтэйчүүд” анхны сургалтаа тэнд эхлүүлсэн. Хөвсгөл аймаг уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их өртөж байгаа бүсүүдийн нэг. Хөвсгөлийн хойд сумд бол дэлхийд хөндөж болдоггүй экосистемийн “бүтэн хамгаалж үлдэх 25 бүс нутаг” -ийн тавд ордог гайхалтай байгальтай, үлгэрийн орон. Гэтэл анхны сургалтаар Орон нутгийн иргэд, эмэгтэйчүүд “...усны ундарга эрс багассан, маш их хуурайшсан, мөсжилттэй газрууд нь устсан, олон төрийн ургамлын ургац муудсан, загасгүй болсон, жимс бага гарах болсон...” зэрэг өөрчлөлтүүд гарсан талаар өөрсдөө ярьж, жагсаалт гаргасан. Уур амьсгалын эдгээр өөрчлөлтүүдээс хүний хүчин зүйл нөлөөлсөн асуудлыг нь ялгаж хараад хүмүүс бид өөрсдөө байгалиа дордуулж буйг олж

Хайртай нутаг орон байгалиа хамгаалж унаган төрхөөр нь авч үлдэх, үр хүүхэддээ буй чигээр нь үлдээе гэвэл тэдний амьжиргаанд нь хүрэлцэхүйц орлого байх ёстой гэдэг нь зүй ёсны асуудал юм.

харсан. Иймд байгаль эх дэлхий, ус, мод, газартаа буруу харьцаж байгаа хүний сөрөг дадлыг өөрчлөх, хайрлах сэтгэл ухамсар суулгах талаар бид хамтран суралцаж байна. Тэнд амьдарч буй эмэгтэйчүүд намрын улиралд байгалиасаа аньс жимс түүж амьдрал ахуйдаа нэмэрлэхээс өөр өрхийн нэмэлт орлого олох боломж хомс учраас хот руу ирж ажил хөдөлмөр эрхэлдэг. Ер нь хайртай нутаг орон байгалиа хамгаалж унаган төрхөөр нь авч үлдэх, үр хүүхэддээ буй чигээр нь үлдээе гэвэл тэдний амьжиргаанд нь хүрэлцэхүйц орлого байх ёстой гэдэг нь зүй ёсны асуудал юм. Бид байгальд ээлтэй аялал жуулчлал, бизнесийг хөгжүүлэхийг зорьж, “Тайгын бэрүүд” төслийн эмэгтэйчүүд бид дэр үйлдвэрлэж эхлээд байна. Мөн байгалиа хамгаалах үүднээс нутагтаа гялгар уут хэрэглэхээ болиод гарын доорх материалаа





ашиглаж даавуун тор хэрэглээндээ нэвтрүүлэх санаачилга гаргасан.

Хөдөлмөрийн тухай хуульд тодорхой зохицуулалт оруулсан гэж ярьсан. Онцлох ямар заалтууд байна?

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга нь хөдөлмөрлөх эрхийн дөрвөн суурь зарчимд суурилсан. Эмэгтэйчүүдэд ээлтэй нэг бус заалт бий. Тухайлбал зайнаас ажиллах боломжийг бий болгосон, ажилтны ар гэр амьдралын тэнцвэрийг хангах үүргийг ажил олгогч нарт даалгасан, ямар ч байгууллага хүүхэд хамгааллын бодлоготой байна гэдгийг ажил олгогчдод даалгаж хууль эрх зүйн орчныг нь бүрдүүлж өгсөн. Ажлын байрны дарамт, ажлын байрны бэлгийн дарамтыг хориглосон, урьдчилан сэргийлэх үүргийг Ажил олгогчид өгсөн гэх мэт.

-Танай холбоо Дэлхийн эмэгтэйчүүдийн чуулганд жил бүр Монголынхоо эмэгтэйчүүдтэй оролцдог. Энэ ямар онцлогтой чуулган байдаг вэ?

Дэлхийн эмэгтэйчүүдийн дээд чуулган 1993 оноос эхэлсэн. Үндсэн санаа зорилго нь эмэгтэй хүний тархи, оюунаар эдийн засгийг удирдуулвал ямар байх вэ гэдгийг онцолж, жил бүр чуулахдаа ярилцдаг. Дандаа том том корпорацийн шийдвэр гаргах түвшний хүмүүс оролцдог учраас үнэхээр манай бизнес эмэгтэйчүүд хөрөнгө оруулалт олох бүрэн боломжтой. Хурлын ач холбогдол бол эхний өдөр нь засаг төрийн дугуй ширээний уулзалт болдог. Түүн дээр улс орнуудын төр засаг нь манай эдийн засагт эмэгтэйчүүд маань ийм оролцоотой байдаг, тэдний хувь нэмрийг нэмэгдүүлэхэд ийм ийм арга хэмжээ авсан гэж өөр хоорондоо туршлагаа солилцож, тэргүүн туршлага шалгаруулдаг. Өнгөрсөн жил гэхэд Азиас анх удаа Малайз улс төрийн болон төрийн өмчийн компанийн засаглалд буюу ТУЗ-д суудлын квотыг хуувиар тогтоосон учраас шагналыг нь авч байх жишээтэй.

Манай холбоо уг чуулганд 2014 онд оролцож, түүнээс хойш жил бүр шийдвэр гаргах түвшний хүмүүст танилцуулсаар ирсэн ч гадаад томилолт байхгүй гэсэн нэрийдлээр хойшлуулсаар ирсэн. Эмэгтэйчүүдийн манлайллыг эдийн засгийн шийдвэр гаргах түвшинд яаж оролцуулах вэ гэдгийг ярьдаг. Урам зориг авдаг, нүд нээж чих онгойсон мэдээллүүд авна, чадвал хөрөнгө оруулалт олох боломж байдаг гэдгийг хэлмээр байна.

Яагаад эмэгтэйчүүдийг улс орон нийгмээрээ заавал дэмжих ёстой вэ гэдгийг хэлээч?

Маш энгийнээр тайлбарлая. Энэ амьдралд бид өрөөсөн нүдээрээ хараад гудамжаар яваад үз. Хоёр нүдээрээ орчлон хорвоог бид харахад ямар байдаг вэ гэдэг нь ерөөсөө л энэ нь арга билгийн ухаан. Улсаа сайн сайхан хөгжүүлэе гэсэн бодол хүн бүрт бий. Энэ хоёр нийлж байж хамтаараа зөв гэдэг нь гарч ирнэ. Тийм учраас аль ч хэсэгт эмэгтэйчүүдийн оролцоо чухал. ■



Б.ОРГИЛ: ЖИЖИГ, ДУНД БИЗНЕСҮҮД ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛ ЭРГЭЛТ

Эдийн засгийн гол эргэлт болсон жижиг дунд бизнесүүдийг Худалдаа хөгжлийн банк ямар бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дэмжин ажиллаж байгаа талаар Худалдаа хөгжлийн банкны, Жижиг дунд бизнесийн газрын захирал Б.Оргилтой ярилцлаа.

-Танайх тусдаа жижиг, дунд бизнесийн газар гэж байгуулсан байна. Тусдаа ийм газартай болсны хувьд жижиг, дунд бизнес эрхлэгчдэд олгож байгаа давуу талууд нь юу вэ?

Өмнө нь бид жижиг дунд бизнес эрхлэгчдийг корпорэйт харилцагч эсвэл иргэдийн харилцагч гэдэг хоёрхон сегментэд хуваадаг байсан. Энэ нь иргэдэд тавигдаж байгаа зээлийн шалгуур, тухайн хүмүүсийн зээлийг гаргахад судалгаа хийж байгаа аргачлал нь нэг бол жижиг зээлийн судалгаа шиг, эсвэл бүр том зээлийн судалгаа шиг хийгддэг. Энэ дунд байгаа хэсэг нь тухайн харилцагчдаа зориулсан байдлаар зээлийн судалгаа хийх, тухайн харилцагчийн материалыг бүрдүүлэхэд бага зэрэг хүндрэл үүссэн.

Бид энэ орон зайг хамгийн зөвөөр шийдэх

нь харилцагчдадаа болоод банкандаа шийдвэр гаргах төвшинд нь энгийн бөгөөд хялбар байдлаар судалгаа шинжилгээ хийх. Харилцагчтайгаа илүү ойртож, бизнесийг нь өргөжүүлэхэд илүү түлхэц болно гэж үзэж, энэ моделийг сонгож, моделийн дагуу бизнесээ өргөжүүлээд ажиллаж байна.

-Гол нь бизнесийн зээлийг илүү богино хугацаанд гаргах, санхүүгийн зөвлөгөө өгөх зорилготой гэсэн үг үү?

Тийм. Худалдаа хөгжлийн банкныг яагаад гурван сегментэд хувааж байгаа вэ гэвэл, харилцагч бүр өөрийн гэсэн зан төлөвтэй. Хийж байгаа бизнес бүр нь өөрийн гэсэн соёлтой.

Тухайн харилцагч жижиг бизнес эрхэлдэг бол иргэд суурьтай бүтээгдэхүүн дээрээ тухайн бизнесийг хөгжүүлдэг. Тухайн харилцагчид зориулсан бүтээгдэхүүн

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК БА
ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ



Боломжит орлого нь 100 саяас 3.5 тэрбум хүртэлх борлуулалтын орлоготой айлыг жижиг, дунд сегментийн айл гэж тодорхойлж байна. Гэхдээ энд харилцагч бүрийг өөрөөр тодорхойлж үздэг.

үйлчилгээ, холбогдох хамгийн бага хүүтэй зээлийн эх үүсвэр санал болгох, банкны суурь бүтээгдэхүүн хэрэглэхийг санал болгодог. Иргэдийн банкны жижиг зээлүүд сайжирч, өөрийн гэсэн байр сууриа эзлээд ирэхээр жижиг, дунд бизнесийн сегмент рүү ордог.

Бид үүнийг илүү сайн, хүүгийн хувьд ямар байх ёстой, мөнгөн урсгалыг яаж тооцох ёстой, сар бүр оруулдаг санхүүгийн хэрэгцээг яаж тооцох, яаж хуримтлал бий болгох, эрсдэлээ хэрхэн зөв удирдах зэрэг талаас нь харилцагчдадаа зөвлөгөө өгдөг. Үүний дагуу харилцагчаа дахиад хөгжүүлж, бойжуулаад байгууллагын банк руу шилжүүлдэг.

-2020 оны байдлаар 63 мянга

гаруй жижиг, дунд бизнес байна гэсэн судалгаа бий. Ковидын үед энэ тоо өөрчлөгдсөн үү. Танайд жижиг дунд бизнес эрхэлдэг хэчнээн харилцагч байна вэ?

Өнгөрсөн оны байдлаар яг жижиг, дунд бизнесийн банкны газрын бүртгэлд 60 мянган харилцагч байсан. Үүнд дэлгүүр ч ажиллуулдаг хүн бий. Томоохон сүлжээ ресторан ажиллуулдаг хүмүүс ч бий. Ийм харилцагч 60 мянга байсан. Сая эхний хагас жилийн байдлаар тооцоход 65 мянга болж өссөн байна. Энэ бол амжилттай тоо.

-Та бүхний тодорхойлдог жижиг, дунд бизнес гэдэг тодорхойлолтод ямар байгууллага хамаардаг вэ. Нийтлэг бол

жилийн 300 саяас нэг тэрбум төгрөгийн орлоготой, 15-аас дээш хүнтэй гэж үздэг бил үү?

Банк тэр стандартын дагуу зээлэх боломжтой хэмжээг нь 350 саяас нэг тэрбум төгрөг хүртэлх гэж үздэг. Боломжит орлого нь 100 саяас 3.5 тэрбум хүртэлх борлуулалтын орлоготой айлыг жижиг, дунд сегментийн айл гэж тодорхойлж байна. Гэхдээ энд харилцагч бүрийг өөрөөр тодорхойлж үздэг.

Жишээлбэл, найман нэрийн дэлгүүртэй хүний сарын борлуулалт 120 сая төгрөг байдаг бол тухайн хүн манай жижиг, дунд сегментийн айл. Энэ хүнд зориулсан банкны ямар бүтээгдэхүүн байх вэ гэдгийг тооцож, бүтээгдэхүүнээ хөгжүүлж



ажилладаг.

-Жижиг, дунд бизнесийн ихэнх нь зээлтэй байдаг. Бизнесийн гол хөрөнгө оруулалт нь зээл гэж харж болох уу?

Энэ жаахан өрөөсгөл ойлголт. Жишээлбэл, Оргил гэдэг хүн бизнес эрхлэхийн тулд өөрт байгаа 15 сая төгрөгт тааруулаад бизнес эрхэлж болно. Гэхдээ тэр бизнес эрхэлж байх хугацаандаа өөрийнхөө 15 сая төгрөгийн хэдэн хувийг нь эргэлтийн хөрөнгөдөө зориулах, хэдэн хувийг нь эрсдэлийн сан болгож, байнга бэлэн байдалд байлгах вэ гэдгээс хамаараад бизнесээ явуулдаг. Зарим жижиг дунд бизнес эрхлэгчдийн эргэц нь томорч эхэлдэг. Эргэц нь томроод ирэхээр тэр хэмжээгээрээ зээлийн хэрэгцээ үүсэж эхэлдэг. Тэр үүсэж байгаа хэрэгцээг хангахын тулд зээл авч байгаа гэж ойлгож болно.

2015-2017 оны хооронд жижиг, дунд бизнес эрхлэгчдийн зээлжих чадварын хэмжээ бага байсан. Ойролцоогоор 150-350 сая төгрөгийн хооронд зээлжих чадвартай байдаг байлаа. Сүүлийн хоёр жилийн хугацаанд тус бизнес эрхлэгчдийн суурь чадамж маш сайжирсан байна. Дээшээ тэрбум, түүнээс ч дээш зээлжих чадамжтай болсон. Энэ нь бас нэг давуу тал гэж харж байна.

-Та жижиг, дунд бизнесийн харилцагчдаа судалдаг байх. Ер нь нийтлэг хандлага нь юу байдаг вэ?

Зарим хүн маш зоригтой байдаг. Би зээл авах ёстой. Тэгж байж л миний бизнес амжилтад хүрнэ гэж хардаг хэсэг бүлэг байдаг. Зарим нь үнэхээр тоног төхөөрөмжөө шинэчлэхгүй л бол манайх цаашаа өсөхгүй юм байна гэдэг өнцгөөр хардаг хүн ч бий. Зарим нь "Надад зээл гарах болов уу, гарахгүй болов уу" гэж эргэлздэг хэсэг бүлэг байдаг.

Бидний зөвлөдөг зүйл бол харилцагч зүгээр л банканд дээр ирээд уулзах ёстой. Өөрийнхөө бодож байгаа бодлыг банкны ажилтан, санхүүгийн зөвлөгч гэдэг өнцгөөс хараад, яавал дээр вэ гэдэг зөвлөгөөг авах хэрэгтэй.

Банк бол гурван өнцгөөс харж зөвлөнө. Нэгдүгээрт, оруулж байгаа хөрөнгө оруулалт нь тухайн бизнест хэр их өгөөжтэйг тодорхойлно. Хоёрдугаарт, үүнийг хийснээр зах зээлд хэдэн хувийг эзлэх вэ. Чадамж нь дээшлэх үү гэдэг тооцооллыг хийж өгнө. Бид зах зээлийн судалгааг нь ч хийдэг. Жишээлбэл, энэ шүүс зах зээлд үйлдвэрлээд гарахад хэдэн хувьтай байх, одоо яг хэдэн хувьтай байна. Тэр өнцгөөс нь бүх тооцооллыг гаргаад, та үүнийг солих хэрэгцээ байна уу. Түүний оронд арай илүү маркетинг, сурталчилгаа хийгээд, илүү

далайцтай болсны дараа өөрчлөх хэрэгтэй биш үү. Эсвэл хаяг, шошгоо жаахан өөрчлөөд бусдад жаахан танигдах байдлаар яваарай гэх мэт зөвлөгөө өгдөг.

-Танай онцлох бизнес гэвэл ногоон бизнес. Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээл гаргаж байгаа юм байна. Ногоон бизнес гэхээр ямар бизнесүүдэд зээл олгоно гэсэн үг вэ?

ХХБ нь тогтвортой хөгжил, уур амьсгалын асуудалд тусгайлан анхаарал хандуулж, ач холбогдол өгч ажилладаг түүхтэй. Үүний хүрээнд ХХБ нь уур амьсгалын өөрчлөлт, ногоон хөгжлийн чиглэлээр дэлхийд хамгийн томд тооцогддог Уур амьсгалын ногоон сангийн итгэмжлэгдсэн байгууллага болсон. Мөн Монгол Улсдаа анх удаа Тогтвортой санхүүжилтийн хүрээ бодлогын баримт бичгийг боловсруулж олон улсын мэргэжлийн хөндлөнгийн байгууллагын дүгнэлт гаргуулсан туршлагатай. Мөн тогтвортой хөгжлийн зорилтуудаас Чанартай боловсролыг дэмжих, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эдийн засгийн өсөлтийг дэмжих, Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах гэсэн дөрвөн зорилтыг үйл ажиллагаандаа тусгаж ажилладаг. Үүний хүрээнд ногоон бизнесийн зээл, эмэгтэй бизнес эрхлэгч нарыг дэмжих зээлийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлсэн. Тус зээлүүдийн хувьд Ногоон бизнес гэдэг нь байгаль орчинд ээлтэй хөрсний бохирдол үүсгэхгүй, хог дахин боловсруулах чиглэлд бизнесийн үйл ажиллагаа нь чиглэж байвал давуу талыг үүсгэнэ. Үүний хүрээнд нэлээн олон компани манайхаас тэр зээлийг авсан. Жишээлбэл, "Тосон тогоо" гэж компани байдаг. Хаягдал дээр байгаа хайлшнуудыг цуглуулж, хайлуулаад, цутгалт хийж, тогоо үйлдвэрлэдэг. Энэ нь Монголын зах зээлд 15-20 хувийг эзэлдэг. Маш эрэлттэй тогоо байдаг. Суурь нь бөөрөнхий биш, хавтгай учир эрэлт ихтэй.

-Эмэгтэй бизнес эрхлэгчдийн зээл төлөлтийн хугацаа хойшлогддоггүй, хугацаандаа, найдвартай төлдөг гэсэн судалгаа байдаг?

Эмэгтэй бизнес эрхлэгчид санхүүгийн хариуцлага сайтай. Жишээлбэл, өнгөрсөн онд эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих 6.4 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.

Бид эмэгтэй л бол, бизнес нь эмэгтэй удирдагчтай, хөрөнгө оруулагч нь эмэгтэй байвал гэдэг үндсэн шалгуур тавьдаг. Тухайн бизнест олгож байгаа зээлийн хэмжээ бизнесийн цар хүрээ, чадамжаас нь хамааран өөр өөр байдлаар гардаг. ■



Н.Амгалан-Эрдэнэ: Монголд бизнес эрхлэнэ гэдэг шийтгүүлж байгаа мэт санагддаг

Д.ОЮУНЧИМЭГ

Хог хаягдлын зөвлөх үйлчилгээ үзүүлдэг “Өнгө нэм” компанийн гүйцэтгэх захирал Н.Амгалан-Эрдэнэтэй ярилцлаа.

-Хог хаягдлын зөвлөх үйлчилгээ үзүүлдэг компани гэхээр сонирхолтой санагдаж байна. Үйл ажиллагааныхаа онцлогийг товчхон хэлэхгүй юу ?

-Манайх хог хаягдлын менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллага байж байгаад энэ жилээс үйл ажиллагаагаа өргөжүүлэн ХХК болсон. Бид хог хаягдлыг мөнгө гэхээс илүү хэрхэн менежмент хийх ёстой вэ гэдэгт анхаарлаа хандуулж ажилладаг. Хэрэглэгчийн

хэрэглэсэн бүтээгдэхүүний сав баглаа боодол байгаль орчинд хог болж үлдэж болохгүй. Үүнийг хэрхэн дахин боловсруулж бүтээгдэхүүн болгох вэ. Хэрэглэгч хэрэглэснээс илүү хөнөөлтэй байгаа учраас үйлдвэрлэгч, хэрэглэгчид илүү хариуцлагатай байгаасай хэмээн хүсч ажиллаж байна. Мэдээж бизнес хийж ашиг олохын тулд компани байгуулсан учраас хогийн сав борлуулах болон зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.

-Хогийг хүмүүс харсан дуулснаараа мөнгө гэж ярих нь их болж. Гэхдээ бодож байгаа шигээ үр шим өгдөг эсэхийг нь мэдэх гэж оролдох нь бага байна.

Хог мөнгө мөн үү?

Нийгэмд байгаа хандлагыг харахаар хогоо зарж мөнгө олохыг зорьж байна. Гэтэл хог хаягдал гэдэг байгаль орчин, хүний амьдрах орчинд ямар хор хөнөөл учруулж байгааг ойлгож, ухаарахыг орхигдуулсан. Үнэн хэрэгтээ хог гэдэг тухайн бизнес аль хэдийнэ ашгаа олчихсон зүйл шүү дээ. Гэтэл түүнээсээ ашиг олох гээд байгаа нь хэцүү асуудал. Учир нь хог овор ихтэй, жин багатай. Тухайлбал, машин дүүрэн гялгар уут ачлаа гэхэд харагдах байдал нь маш их хэмжээний мөнгө олж байгаа мэт. Үнэн хэрэгтээ тэр нь нэг тонн ч хүрэхгүй шүү дээ. Тэгэхээр үүнийг

ХОГНЫ МЕНЕЖМЕНТ

бизнес гэж харуулах нь хүндрэлтэй. Гэвч нөгөө талдаа бүтээгдэхүүн болгож үйлдвэрлэж байгаа газруудын хувьд бол жинхэнэ бизнес. Жишээлбэл, гялгар уутыг хайлуулж бохирын хоолой үйлдвэрлэж байна. Үүнийг нүхэн жорлонд ашиглаж болно. Тэр ч бүү хэл аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд ч хэрэглэж болно. Ингэснээр хөрсний бохирдлоос найдвартай хамгаалах боломж бүрдэж байгаа юм. Бохир усыг хөрсөнд шингээхгүй байх нь хөрсний бохирдлоос сэргийлж байна гэсэн үг л дээ.

-Хогны менежмент гэж сүүлийн жилүүдэд нэлээдгүй ярих болсон. Нэг талаасаа манай улсын хувьд шинэ тутам хөгжиж байгаа салбар. Энэ чиглэлээр үйлдвэрлэл явуулдаг аж ахуйн нэгж цөөхөн байх тийм үү?

-Манай компанийн хувьд дахин боловсруулах үйлдвэрүүдийг цэвэр түүхий эдээр хангах зорилготой. Нөгөөтэйгүүр бид



ӨНГӨ + IEM

ХОГ ХАЯГДЛЫН
МЕНЕЖМЕНТИЙН ТӨСӨЛ

компаниудад зөвлөгөө өгөхөөр хогны савны худалдаа хийх зайлшгүй шаардлага гарсан учраас НҮТББ-аас ХХК болж өөрчлөгдсөн юм шүү дээ.

Ер нь бизнес гэхээс илүү нийгэм рүү чиглэсэн ажлыг хийдэг. Харин одоо ашиг олж болохуйц худалдаа, үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ эрүүл бизнесийн системийг хэрэгжүүлж ажиллахыг зорьж байна. Нэг үеэ бодвол хүмүүс хогоо ангилж хаядаг болж байна. Түүнийг дагаад дахин боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид гарч ирж байгаа.

-2016 онд гялгар уут, хуванцар сав дахин боловсруулдаг үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцаж очсон юм. Тэнд хашааны шон гэх мэт зүйлийг гялгар уут хайлуулж хийдэг байсан санагдана?

-Хогны менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд бүр жижгээсээ эхлээд томоо хүртэл байгуулагдаж байна. Сүүлийн жилүүдэд манай улсад хог хаягдлын салбар эрчимтэй хөгжиж байна. Хаягдал цаасан хайрцаг боловсруулан өдөрт 35

хайрцаг үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр байгуулагдсан. Мөн АПУ-ны ус ундааны савыг боловсруулах үйлдвэр байгуулагдаж байна. Түүнээс гадна ахуйн хэрэглээний хуванцар савыг барилгын арматур, хэв хашмал үйлдвэрлэн барилгын компаниудад борлуулж байгаа гэх мэтээр хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүд хөгжсөөр. Тиймээс манай компани эдгээр үйлдвэрүүдэд цэвэр түүхий эдийг нь нийлүүлэхийг эрмэлзэж байгаа. Өөрөөр хэлбэл, ангилж ялгах шаардлагагүйгээр тухайн хэрэгцээтэй байгаа түүхий эдийг нь нийлүүлдэг. Одоо бол хогийн цэгээс хүмүүс түүж дахиварын цэгүүдэд өгнө. Түүнийг нь ангилж ялгаад үйлдвэрүүдэд борлуулдаг. Энэ шат дамжсан үйлдлийг нэг шат дамжлагатай болгохыг хичээж байгаа юм. Тодруулбал, олон улсын жишигт хүргэж, цогц үйлчилгээ үзүүлэн хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхийг зорьж байна.

-Тэгвэл хог хаягдлын менежмент гэж юу вэ?

-Хог хаягдлын менежмент гэдэг нь хог хаягдал үүссэнээс эхлээд эцсийн зайлуулалт хийгдэх хугацааны процессийг хэлж байгаа хэрэг. Тэгэхээр процесс хооронд хийгдэж байгаа хог хаягдал, тээвэр, сургалт, зөвлөгөө зэрэг мэдлэг олгох бүхий л ажлыг манай компани хийж байна.

-Нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллага байхдаа ямар томоохон ажлууд хийж байв?

-Хамгийн сүүлийн жишээ гэвэл, өнгөрсөн жил гялгар уут цуглуулан борлуулсан орлогоороо хүүхдийн тоглоомын талбай хийж өгсөн. Ингэхдээ орчны бохирдлыг бууруулахад юу хийж болох вэ гэдгийг хүмүүс мэддэг болсон. Агаар орчны бохирдолд голлон нөлөөлж байгаа хүчин зүйлийг хүн бүр мэдэж байгаа. Гэтэл мэдсээр байж ямар нэг зүйл хийхгүй бол хүнийг үл хайхрах хүчирхийлэлд өртүүлдэг юм байна. Тиймээс нэг ч гэсэн алхам хийж үүнээс сэргийлэхийг хүссэн. Ингээд “Пластик центр”, “Лантуун дохио” болон манай байгууллага хамтраад эхний ажлаа хийхээр тохиролцон хандив босгохоос илүүтэй хүмүүсийн гялгар уутан хог хаягдлыг худалдан авч түүнийг нь дахин боловсруулан бүтээгдэхүүн үйлдвэрлээд хүүхдэд тоглоомын талбай барьж өгөх ажлыг эхлүүлсэн. Хэдийгээр хүссэн хэмжээндээ хүртэл бүтцийг нь угсарч чадаагүй хэдий ч маш олон компани хаягдал гялгар уутаа өгсөн.

-Хог хаягдлын менежментийн компанийг эмэгтэй хүн удирдана гэдэг амаргүй байх. Та эмэгтэй, эрэгтэй бизнес эрхлэгчийн ялгаатай байдлын талаар юу боддог вэ?

-Эмэгтэй бизнес гэж тусдаа ойлголт байхгүй.



Харин монголчууд бизнесийн мэдлэг хомс гэж анзаарсан. Учир нь бизнес эрхлэнэ гэдэг нь хэт их ашиг олохоос илүүтэй компанийн зөв засаглалтай. Тайлан тооцоо нь хууль журмын дагуу шилэн байх ёстой гэж боддог. Өөрөөр хэлбэл, миний эхлүүлж байгаа бизнес маань ногоон байх хэрэгтэй. Үүний тулд адаглаад санхүүгийн тайлан тооцоо маань ямар ч асуудалгүй шаардлага тулгардаг. Гэтэл би компани үүсгэн байгуулж бизнес эрхэлж байгаа хэдий ч санхүүгийн мэдлэг дутмаг байгаагаа ойлгосон. Энэ нь миний мэргэжилтэй холбоотой байж болно хэмээн өөрийгөө зөвтгөхийг оролдсон нь манай улсад хувиараа аж ахуй эрхэлж байгаа бүхий л хүнд тулгамддаг асуудал юм байна. Нөгөөтэйгүүр хөрөнгө оруулагч болон хөрөнгийн эх үүсвэр татаж байгаа нь ч ялгаагүй эдийн засгийн мэдлэг хомс байгааг анзаарсан.

-Тэгвэл хөрөнгө оруулалтыг хэрхэн үр ашигтай зарцуулах вэ. Магадгүй та бизнесээ цааш хөгжүүлж, өргөжүүлэхийн тулд юу хийх вэ?

-Би уг нь аливаад шүүмжлэлтэй ханддаг хүн биш. Гэхдээ зайлшгүй

хэлэх шаардлага гарч ирэх юм. Хэрэв манай улсын эдийн засагт оролцогчдыг чадавхитай болгохыг хүсч байвал иргэдийн санхүүгийн мэдлэгийг сайжруулах хэрэгтэй болов уу. Тухайлбал, бидний ажиллаж байгаа салбар шинэ тутам. Миний хувьд гурвуулаа хамтарч бизнесээ эхлүүлсэн. Тиймээс дэм дэмэндээ алдаа оноогоо ярилцан, гарц шийдэл эрэлхийлж ажилладаг. Монголчуудын хэлдгээр гурвуулаа хамт байгаа учраас дутуугаа нөхөөд ажиллаж чаддаг. Харин ганцаараа бизнес эхлүүлж байгаа хүмүүсийн тухайд илүү хүндрэл гардаг юм байна гэдгийг энэ хугацаанд анзаарлаа. Яагаад гэвэл, бизнес эрхлэнэ гэдэг зөвхөн хөрөнгө оруулаад болчихдог зүйл биш. Маш олон хүчин зүйлийн нөлөө бий.

Манай улсад хамгийн мэргэжлийн байх ёстой нь эрүүл мэндийн салбар. Гэтэл системийн гажуудалд орчихсон байгааг салбарын эмч ярьж байгааг сонсоод "Юунаас үүдэн гажуудах болов" гэх бодол зурсхийсэн. Магадгүй хүмүүсийн тэр дундаа бизнесийнхний ярьдаг монголчуудын хэт туйлширч улстөрждөг нь сөрөг нөлөө үзүүлдэг байж болно.

Нөгөөтэйгүүр, Монголд бизнес эрхлэнэ гэдэг шийтгүүлж байгаа юм шиг мэдрэмжийг авдаг. Хэрэв эдийн засагт хувь нэмэртэй байлгахыг зорьж байгаа бол бизнесийнхэнд уян хатан хандах учиртай. Тухайн компани өртэй байж болно. Түүнийгээ барагдуулахын тулд дансыг нь хаана гэдэг хэзээ ч болохгүй зүйл. Учир нь бизнест ямар нэг асуудал тулгарлаа гэхэд юу юуны духанд хүрэлгүй тухайн байгууллагын дансыг хаачихдаг. Энэ нь маш их халгаатай. Данс нь хаалттай учраас мөнгө орж ирэх боломжгүй. Гэсэн атлаа өрөө төл гээд байдаг юм билээ.

Баялаг бүтээх гээд явж буй бизнесийнхэнд том ч бай, жижиг ч бай, гарааных ч бай, бичил ч бай адилхан хүндэтгэлтэй хандаж, ойлгож, төрийн бодлого зохицуулалтаар дэмжиж, хөгжүүлэх хэрэгтэй санагддаг. ■



ХОЛБОО БАРИХ

📍 БЭЭТ, Баянхошуу дэд төв
☎ +976 70110250
📱 WBCMongolia

📍 БЭЭТ, Өвөрхангай аймаг
☎ +976 88121792
📱 WBCUurkhangai





ХӨТӨЛБӨР

Систем дараалалтай видео контент, тест болон лайв хичээлүүдийг хүссэн үедээ хүссэн газраасаа үзэх

ХИЧЭЭЛ

Бизнесээ эхлүүлэхэд тань туслах бүх түвшний бүрэн цогц видео хичээлүүд




МЕНТОР

Бизнесээ амжилттай эхлүүлж чадсан эмэгтэй бизнес эрхлэгчдээс хүссэн асуултуудаа асууж уулзалт товлон зөвлөгөө авах

ЛАЙВ ХИЧЭЭЛ

Шууд дамжуулагдах хичээлийн үеэр баш нараасаа асуулт асууж зөвлөгөө авах боломж



ГАЗАР ТАРИАЛАН

Ногоон үйлдвэрлэгч

Б.ДАРХАНБААТАР

Манай сэтгүүлийн зочин “Тинц” компанийн үүсгэн байгуулагч Б.Туяагийн ярилцлага уншигч та бүхэнд сонирхолтой бас өгөөжтэй байна гэдэгт итгэлтэй байна. Учир нь эх орны хөрсөнд тарьж ургуулсан төрөл бүрийн хүнсний ногооны зуун хувийн цэвэр шүүсний үйлдвэрлэл эрхэлдэг тэрбээр хог хаягдалгүй органик үйлдвэрлэгч болох чин хүсэлтэй. Энэхүү зорилгоо зүгээр бодоод явах биш, санаа бүрдээ шингээж, үйлдэл болгон хэрэгжүүлж яваа “ногоон” бизнесмэн. Тиймээс эрүүл мэндийн амин дэм “Ногоодой” брэндийг амжилттай бий болгож чадсан юм. Ингээд түүний ярилцлагыг хүргэе.



“Ногоодой” брэндийг бий болгож, хэрэглэгчдийг амин дэмтэй хүнсний бэлдмэлээр хангах үйлдвэрлэл эрхлэх бизнесийн санаагаа анх хэрхэн олсон бэ?

Хүмүүс анх бизнесээ эхлэхдээ том зорилготой, том сэтгэж ордог бол би огт тэгээгүй. Би одоогоос арваад жилийн өмнө Солонгост таван жил ажиллаж,

амьдарсан. Ингэхдээ гурван жил нь эрүүл мэндийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрт ажилласан. Тэгээд эх орондоо ирээд юу хийж орлого олохоо мэдэхгүй хэсэг хугацаанд байсан. Манайхан Солонгост их очиж ажилладаг хэрнээ тэр хөгжилтэй оронд янз бүрийн үйлдвэрлэл дээр ажиллаж туршлага, ноу хау сурч

ирсэн хүмүүст шууд орчих ажлын байр бэлэн байдаггүй шүү дээ. Энэ байдал намайг өнөөдрийн “ногоодой” брэндийг бий болгох шалтгаан руу түлхсэн гэх үү дээ /инээв/. Одоогоос арваад жилийн өмнө чинь ажлын байр хүссэнээр олддоггүй, байгаа заримд нь орох гэхээр нас заана. Ажилгүй хэсэг байж байгаад Солонгос руу буцах



Үүнийг уншуулаарай




Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн Төв - WBC Mongolia



АППАА ТАТАХ

Та өөрийн утасны AppStore эсвэл Play Store руу орж “WBC Mongolia” гэж хайж аппаа татна.

AppStore Play Store





гэсэн чинь виз гараагүй. Тэгээд л Солонгост сурсан зүйлээ хийе гээд л 2017 оноос “Тинц” команийнхаа үйл ажиллагааг эхлүүлсэн дээ.

-Бизнес нь өнөөдөр хэр амжилттай явна вэ?

Манайх тийм том үйлдвэрлэл биш л дээ. Цехийн хэмжээний бичил бизнес эрхэлдэг. “Ногоодой” нэрийн дор хүрэн манжин, сонгино, байцаа, лууван, хар сармис, цагаан гаа, улаан чавга гэсэн таван төрлийн хүнсний ногооноос эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Бүрэн хүчин чадлаараа ажиллавал хоногт 3500 ширхэг бүтээгдэхүүн гаргах боломжтой. Хандлах, жигнэх хоёр төрлийн тогоонд сонгино, хар сармис, цагаан гаа, улаан чавгыг хандалдаг. Байцаа, лууван, хүрэн манжингийн шүүсийг дулаан боловсруулалтын аргаар үйлдвэрлэдэг.

-Ногоогоо зуун хувь дотоо-доосоо авдаг уу?

Дээрх хэлсэн таван төрлийн ногооноос цагаан гаа, улаан чавга хоёрыг одоогоор импортоор авч байна. Монголд тарьдаггүй учраас. Бусад нь бүгд монгол ногоо. Цагаан гааг Монголд тариалах боломжтой эсэхийг Дарханы ургамал газар тариалангийн хүрээлэн судалж байгаа юм билээ. Гэхдээ тариалах боломжтой бол нэлээд хөрөнгө мөнгө, цаг хугацаа шаардана. Зарим хүн биднээс “Танайх яг монгол ногооны шүүс байж чадах уу” гэж асуудаг, итгэдэггүй. Одоо чинь хүмүүс нэг үеэ бодоход

хэрэглэж байгаа хоол хүнсэндээ маш их анхаардаг болчихсон шүү дээ.

Манайх “Сэлэнгэ органик”, “Цэвэр хөрсний шим” гэсэн хоёр хоршооноос гарал үүсэл нь баталгаажсан ногоо авч, үйлдвэрлэлээ явуулдаг. “Сэлэнгэ органик” бол ил хөрсний тариалалтаар хамгийн анхны зуун хувийн органикийн гэрчилгээ авсан хоршоо. “Цэвэр хөрсний шим” нь хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлсэн ногоочдын бүтээгдэхүүнийг борлуулдаг. Тийм болохоор хэрэглэгчид манай бүтээгдэхүүний гарал үүсэлд бүрэн итгэлтэй байж болно гэж хэлэх байна. Үйлдвэрлэлийн хувьд Солонгос цаг агаарын тааламжтай орон болохоор сар сараараа ногооны бүтээгдэхүүнээ хийдэг. Алимны сар гарахаар алимны шүүсээ хийнэ. Өвөл болохоор эмийн ургамлын шүүс хийх гэдэг ч юм уу.

-Танайх бүтээгдэхүүнүүдээ бүх сүлжээ дэлгүүрээр борлуулдаг уу?

“И-март”, “Оргил”, CU, “Эфс”, “Гацуурт”, “Тэнгэр” худалдааны төв зэрэг дэлгүүрээр борлуулдаг. Мөн хоёр онлайн шоп дээр байршдаг. Дээр нь манайх өөрөө хүргэлт хийдэг.

-Танайхыг үйлдвэрлэлээс гарсан хог хаягдлаараа компост бордоо хийдэг гэж сонссон. Хаягдалгүй ногоон үйлдвэрлэл эрхэлдэг гэсэн үг үү?

Шүүс шахахаар ногооны хальс, эд нь болох хаягдал нэлээд гардаг. Тэр манайд нэлээд асуудал болж байсан. Тэгээд шийдэл эрэлхийлж байгаад компост бордоо хийсэн. Яг одоогоор бол хараахан зуун хувь компост болоогүй. Анх яасан гэхээр чийгийн улаан хорхой ашиглаад эко бордоо хийсэн. Энэ нь өрхийн үйлдвэрлэлд хангалттай сайн болох юм билээ. Манайхаас өдөрт багадаа 50-100 кг хаягдал гардаг. Тэгээд ч хүйтрэхээр чийгийн улаан байхгүй болчихдог учраас байнга гаргах боломжгүй. Тиймээс манайх саяхан Азийн сангийн дэмжлэгтэйгээр үйлдвэртээ бордооны машин суурилуулсан. Тэр машины маань дамар нь сайн дийлэхгүй байгаа. Трийгээ сайжруулчихвал манайх хаягдлаа зуун хувь компост бордоо болчихно. Ингэснээр түүхий эд ханган нийлүүлэгч компаниудынхаа ногоо авчирсан машинд манайх буцаагаад бордоогоо ачуулаад явуулчихна. Иймэрхүү байдлаар хаягдалгүй, органик үйлдвэрлэгч болохыг зорьж байна. Солонгост бол бүх үйлдвэрлэл иймэрхүү циклотой явагддаг.

-Ногооны хальс хөрсийг сайн бордох уу?

Бордоон дээр манайх ХААИС-ийн хөрс судлалынхантай хамтарч ажиллаж байгаа. Бүх ногооны хальс тодорхой эрдэс агуулдаг. Жишээлбэл, хүрэн манжингийн хальс гэхэд хөрсөнд нэлээд сайн эрдэс болж өгдөг юм билээ.

-Маш мундаг байна шүү. Би танаар үнэхээр бахархаж байна. Манай сэтгүүлийн олон уншигч ч мөн бахархах байх. Түрүүн яриандаа үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлж байгаа гэж дурдсан. Энэ стандартыг жижиг байтугай том үйлдвэрүүд ч тийм амархан нэвтрүүлээд байдаггүй л дээ. Энэ талаараа тодруулж мэдээлэл өгөхгүй юү?

За баярлалаа. Би ч өөрийгөө тийм мундаг сайн гэж боддоггүй. Тэрбитгий хэл, брэнд энэ тэр гэж ярихаасаа ч санаа зовоод байдаг л даа /инээв/.

Манайх үйлдвэрийн зохистой дадал буюу /GMP/ нэвтрүүлэхээр бэлтгэл ажил нэлээд сайн хийсэн. Бэлтгэл хангах явцад үл тохирол гараад,

Анхаасаа зээл олдохгүй гэдэг хувилбараар бизнесээ хийвэл илүү зүгээр юм болов уу гэж боддог. Борлуулалт боломжийн байгаад, өөрөө санхүүгийн сахилга баттай байж чадвал зээлийн дарамтад орж байснаас тэр нь илүү суурь нь ганхахгүй явах юм болов уу гэж боддог.

сайжруулах гэхээр хөрөнгө мөнгө шаардлагатай болоод түр хойш тавьчихсан байгаа. Үүнийг ер нь бол цаг алдахгүй хийнэ. 2020 онд Жижиг, дунд үйлдвэрийн сангаас авсан зээлээ дээрх стандартыг нэвтрүүлэхэд зориулсан. Угаасаа ч тэгэх л гэж авсан.

Би Солонгост ажиллаж байхдаа стандарт энэ тэрт төдийлэн анхаарч, сайн сонирхож байгаагүй юм билээ. Одоо бодохоор харамсаад байдаг юм. Хүн ер нь их сониуч байх ёстой юм байна гэж бодсон.

Миний ажилладаг байсан үйлдвэрийн ногооны хальсыг бордооны үйлдвэрээс ирээд авчихдаг байсан. Мэдсэн бол би тэр бордооны үйлдвэрт ажиллаж үзэх байсан юм билээ. Яагаад ингэж бодоод байна гэхээр бид бичил, том гэхгүй ямар ч үйлдвэрлэл, бизнес байсан шаардлагатай стандарт юмыг нэвтрүүлэх талдээр анхнаасаа хариуцлагатай ажиллах ёстой. Энэ нь би сайндаа биш л дээ. Би Азийн сангийн хог хаягдлын менежментийн сургалтад хамрагдаад ойлгож ухаарсан зүйлээ хийж байгаа хэрэг. Гадуур дандаа л маркетинг, санхүү, хүний нөөцийн чиглэлээр сургалтууд байдаг шүү



дээ.Тэгвэл Азийн сангийн сургалт бид нар шиг бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд хэрэгтэй зүйлийг илүү заадаг.

Манайхан хогоо эх үүсвэр бүр дээрээ ангилаад сурчих хэрэгтэй. Азийн сангийн хог хаягдлын менежментийн судалгаагаар хүнсний хог хаягдал асар их гардаг юм билээ. Гэр хорооллын айлууд ядаж гарч байгаа ногооны хальсаа хашааныхаа газарт цацаад байхад хөрс маш гоё болно. Сонгинын хальс бол бактери маш сайн устгадаг. Мөн өрхийн хэрэгцээнд сонгинын хальстай усаар төмс, ногоогоо усалж болно. Ногооноос хаях зүйл үнэхээр байдаггүй.

-Танайх ЖДҮС-гийн зээлд хамрагдсан гэж байсан. Тэр зээлээ зориулалтын дагуу маш сайн ашигласан байна. Ер нь танайх шиг ийм хог хаягдалгүй ногоон бизнес эрхэлж байгаа хүмүүст зээлийн хүртээмж хэр байдаг вэ?

2017 оноос эхлээд үйлдвэрлэл хийхдээ анх Солонгост ажиллаж олсон жаахан мөнгөөрөө эхний хөрөнгө оруулалтаа хийгээд явсан. Харин аз болж 2020 онд ЖДҮС-гийн зээлд хамрагдаж, 100 сая төгрөг авсан. Тэрний хүчинд үйлдвэрээ GMP стандартад тохируулаад маш сайн засварласан. Түүнчлэн тоног төхөөрөмжүүдээ гар ажиллагаа багатайгаар шинэчилсэн.

ЖДҮС-гаас зээл авах тэр олон мянган хүсэлт дотроос шалгарч, зээл авч чадсандаа баяртай байгаа. Угаасаа ч тус сангийн зээл өгөх чиглэлд нь манай салбар орчихсон байсан. Дээр нь зээлээр хүмүүс тоног төхөөрөмж, агуулах, барилга авч үйл ажиллагаагаа өргөтгөнө гэх нь их. Манайх болохоор хог хаягдлаа хэрхэн шийдэх төсөл байсан болохоор онцлогтой байсан байх магдлалтай.

-Үйлдвэрлэлээ цаашид хэр өргөжүүлж томруулах бодолтой байна вэ?

Үйлдвэрлэлээ дараагийн түвшинд гаргая гэхээр надад менежмент дутагддаг тал бий. Үнэнийг хэлэхэд би өөрийн бизнесийг хийхээс өмнө удирдах түвшинд ажиллаж байсан туршлагагүй. Тийм болоод ч тэр үү, үйлдвэрлэлээ богино хугацаанд томруулж өргөжүүлэх гэхээр яаран хөдлөөд, алдаа гаргачих болов уу гэсэн болгоомжлол байдаг. Тийм болохоор зориглодоггүй. Хүмүүсийн зарим нь “Томхон хөдлөх хэрэгтэй. 100-хан сая төгрөгөөр юу хийдэг юм” гэж л байдаг. Би бол олдож байгаа мөнгийг яг зориулалтын дагуу зарцуулж чадвал үр дүнтэй байж чадна гэж боддог.

Тэгээд ч би хувь хүнийхээ хувьд мөнгийг зууг зуу гэхгүй, хоёр зууг хоёр зуу гэхгүй хуримтлуулж, хүнд төвөг болохгүй амьдрахыг боддог. Солонгост ч гэсэн ингэж л тэсэж тэвчиж байж хэдэн төгрөг хуримтлуулсан. Тэр мөнгөөрөө өөрийн үйлдвэрлэлээ босгож ирсэн. Тийм болохоор санхүүгийн байдал хувь хүнээс их шалтгаалдаг зүйл.

Мөн бид нар шиг бичил бизнес эрхлэгчдэд зээл авах боломж гарч ирэхэд барьцаа хөрөнгөгүй гээд

барагтай олддоггүй шүү дээ. Ер нь тэгээд анхаасаа зээл олдохгүй гэдэг хувилбараар бизнесээ хийвэл илүү зүгээр юм болов уу гэж боддог. Борлуулалт боломжийн байгаад, өөрөө санхүүгийн сахилга баттай байж чадвал зээлийн дарамтад орж байснаас тэр нь илүү суурь нь ганхахгүй явах юм болов уу гэж боддог.

-Уншигчдад маань санхүүгийн хариуцлагын талаар маш хэрэгтэй зөвлөгөө өглөө. Танд бол өнөөдрийн түвшинд мөнгө төгрөгнөөс илүү үйлдвэрлэлийн менежментийн маш сайн зөвлөгөө өгөх туршлагатай, чадвар өндөр зөвлөх л хэрэгтэй байгаа юм байна гэж ойлголоо. Зөв үү?

-Яг тийм. Манайх 2017 оноос өнөөдрийг хүртэлх хугацаанд бичлээсээ гарч чадалгүй, нэг хэвэндээ л байна. Гэхдээ байнга урагшилж л яваа. Би бол байгаль орчиндоо ээлтэй, худлаа уриа лоозон ярихгүйгээр өмнөх ажлаа хариуцлагатай хийж, органик үйлдвэрлэгч болохыг зорьдог хүн. ■



Б.Оюун-Ундрах: ИТГЭЛЦЛИЙН ҮНДСЭН ДЭЭР ЗЭЭЛ ОЛГОДОГ БАЙМААР БАЙНА

Сониноор сагс сүлжиж, хаягдалгүй ногоон үйлдвэрлэл эрхэлдэг “Handy craft” компанийн үүсгэн байгуулагч Б.Оюун-Ундрахтай хаягдалгүй үйлдвэрлэл, бичил, жижиг, дунд бизнес эрхлэлтийн орчны талаар ярилцлаа.



Гар урлалаар хийж болох бүхий л төрлийн бүтээгдэхүүнийг хийхээс гадна би өөрөө дизайнер мэргэжилтэй учраас арьсан болон цаасан урлал, оёдол, дизайны чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

-Бизнесийн санаагаа анх яаж олсон бэ. Гар урлалын чиглэлээр дагнаад хэдэн жил ажиллаж байна вэ?

Намайг Оюун-Ундрах гэдэг. “Урлах эрдэм”-ийн дээд сургуулийг хувцас дизайны мэргэжлээр 2013 онд төгсөж мэргэжлээрээ жил гаруй ажилласан. Багаасаа л гар урлал сонирхдог байсан. 2015 онд сүлжмэл сагсны нэг өдрийн сургалтад сууж өнөөдрийг хүртэл дагнан ажиллаж байна. Анх бизнес болгоно гэж бодоогүй сонирхлоороо хийж эхэлсэн. Хүүхдээ харж байх хугацаандаа л хийнэ гэж бодсон боловч захиалга нэмэгдэх бүрт баярлаад урам зоригтой хийдэг болсон. Би бүтээгдэхүүнээ хаана борлуулах вэ гэж санаа зовдоггүй. Учир нь захиалгаар хийдэг. Анх эхэлж байх үедээ сагсаа бариад олон газраар явдаг байсан л даа. “Цэцэгт мэндчилгээ”-ний захиалга орж ирээд, тасралтгүй дөрвөн жил хамтарч ажилласан анхны минь ажил байлаа. Одоо бол томоохон тавилгын компаниуд, бэлэг дурсгалын дэлгүүрүүд гээд олон газраас захиалга орж ирдэг.

-Танайх хэдэн нэр төрлийн бүтээгдэхүүн хийдэг вэ?

Гар урлалаар хийж болох бүхий л төрлийн бүтээгдэхүүнийг хийхээс гадна би өөрөө дизайнер арьсан болон цаасан урлал, оёдол, дизайны чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна. Сүүлийн хоёр жил ковидоос шалтгаалж үйл ажиллагаа маань доголдсон. Анх ажлаа эхлүүлэхдээ 60 ам.метр талбайтай ажлын байр түрээсэлдэг байлаа. Хэдийгээр цар тахлыг давж чадалгүй түрээсийн байрнаасаа гарсан ч одооноос үйл ажиллагаагаа эргээд сэргээж байна. Одоо бол үндсэн гурван ажилтантай, захиалга ихтэй үедээ нэмэлтээр 6-7 цагийн ажилтан ажиллуулдаг. Цар тахлын үеэр хүн аливаа

зүйлд хөрвөх чадвартай байх ёстой юм байна гэдгийг сайтар ойлгосон. Тиймээс өөрийгөө олон талаар сорьж, сурч хөгжих сонирхолтой. Гэхдээ сүлжмэл урлалдаа тууштай байх юм билээ. Орхиж чаддаггүй. Чиглэлийнхээ олон ч үзэсгэлэн худалдаанд оролцсон.

-Үйлдвэрлэл эрхлэхэд тоног төхөөрөмж авахаас эхлээд эргэлтийн хөрөнгө чухал. Танайх хөдөлмөр эрхлэлт, жижиг, дундын зээл авсан уу?

-Үйлдвэрлэлээ өргөжүүлэх гэхээр яалт ч үгүй санхүүгийн эх үүсвэр зайлшгүй шаардлагатай болдог. Анх өөрийн амьдарч байгаа харьяаллын дагуу дүүргийнхээ Жижиг, дунд үйлдвэрийн газар, Хөдөлмөр халамжийн төвөөс дэмжлэг авч болдгийг мэдээд холбогдох газруудад таван сая төгрөгийн зээл авах боломж эрэлхийлсэн ч бүтээгүй. Таван сая төгрөг авахын тулд 10 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийн барьцаа шаардсан. Дөнгөж гэр бүл зохиосон бидэнд яаж тийм барьцаа байх вэ дээ. Хамгийн хачирхалтай тэр хөрөнгийн эх үүсвэрийг зайлшгүй авах арга эрэлхийлье гэвэл хөгжлийн бэрхшээлтэй эсвэл өрх толгойлсон эмэгтэй байвал зээл авах боломжтой гэсэн. Ингээд шантарч явах үед МҮХАҮТ-д “Rich” төслийн танилцуулгын сургалтад суусан юм. Эндээс Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төв гэж байдгийг мэдэж авсан. Тус төв гарааны бизнес эхэлж байгаа бичил, жижиг, дундынханд хэрэгтэй мэдээлэл, сургалт ордог, тав тухтай орчин бүрдүүлсэн их гоё санагдсан. Тэгээд л тэндээс зохион байгуулсан сургалтуудад хамрагдан их зүйл сурч мэдэж авсан. Надад хамгийн өгөөжтэй байсан нь Азийн сангийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төвийн хэрэгжүүлсэн Инкубатор хөгжүүлэлтийн хөтөлбөрт хамрагдсан дөрвөн сарын хугацаатай сургалт байсан. Тэндээс маш олон зүйлийг ойлгож, сурчавснаар компаниа байгуулан, бүтээгдэхүүн хөгжүүлэлтдээ түлхүү анхаарч үйлдвэрлэлээ эхлүүлж чадсан. Намайг сургалтдаа амжилттай суралцсан гээд Азийн сангаас 5.2 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосон. Дүүргүүдийн жижиг, дундын зээл бол хол юм байна гэдгийг мэдэж, харин эмэгтэйчүүдийн бизнесийг дэмждэг Азийн сан, МҮХАҮТ мэтийн газрууд бодит дэмжлэг үзүүлдэг юм билээ.

-Сурч мэдэж өөрийнхөө чадлаар олж авсан 2.5 сая төгрөгийн дэмжлэгээрээ өөрийн гарааны бизнестээ ямар хөрөнгө оруулалт хийсэн бэ?

Эхлэлийн хөрөнгөтэй болж хоёр оёдлын машин, цаасан урлалдаа хэрэгтэй том, жижиг гурван машин худалдаж авсан. Дараа нь сургалтад хамрагдаж



төгссөн есөн төгсөгч хоорондоо хамтарч бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийж, үзэсгэлэн худалдаанд оролцсоны дагуу дүүргээс зохион байгуулсан 10 сая төгрөгийн хөрөнгө оруулалттай “Start up” тэмцээн зарлагдсаныг олж мэдсэн. Тэр нь хүүгүй, барьцаагүй эргэн төлөгдөх нөхцөлтэй байсан юм. Уг тэмцээнд амжилттай оролцож 10 сая төгрөгийн санхүүжилт авч ажлын байр түрээслэн, тавилга, тавиур хийлгээд бүтээгдэхүүнээ хийж эхэлсэн.

Мөн “Голомт” банк нь инкубатор төгсөгчидтэй хамтарч ажиллаж, барьцаагүйгээр 8.4 хувийн хүүтэй 10-20 сая төгрөгийн зээл авч болно гэсэн учраас түүнд хамрагдан лазер машин, бараа материал авч эргэлтийн хөрөнгөө босгож байлаа. 2017 онд 30 ам.метр байранд,

2018 онд 60 ам.метр байранд орж ажлын байраа томруулсан. 2019 оны шинэ жилээр 2310 сагсны захиалга авч багаараа ажилласан. Энэ нь бидний цар тахлын өмнө хийсэн хамгийн сүүлийн ажил байсан.

Ковидын үеэр түрээсээ ч төлж дийлэхгүй болсон учраас гэрээрээ үйлдвэрлэлээ явуулсан. Тэгээд захиалга бараг орж ирэхгүй болсон учраас компанид цагийн ажил хийж байгаад, хоёр сарын өмнөөс ажлын байр түрээслээд үйлдвэрлэлээ дахин эхлүүлсэн.

-Захиалга хэр байна вэ. Тавилгын компаниудтай хэрхэн хамтарч ажилладаг вэ?

Захиалга сайн байгаа. Сүүлийн үед хүмүүс авсаархан, эко бүтээгдэхүүн хэрэглэх хандлагатай болсон. Тухайлбал, гал тогоондоо хүнсний ногоо зэргийг хийх сагс, оймс, дотуур хувцас хийх зориулалтаар сагс хийлгэх нь их болсон. Түүнчлэн тавилгын компаниуд өндөр дүнтэй худалдан авалтад манай бүтээгдэхүүнээс бэлэг болгон өгөх байдлаар хамтарч ажилладаг.

-Одоо тэгээд бизнесээ ковидын өмнөх үед нь аваачиж, тогтвортой үйл ажиллагаа эрхлэхийн тулд хэрхэн ажиллах бизнес төлөвлөгөөтэй байна вэ?

Өөрийн гэсэн ажлын байртай болох санаатай. Түрээсийн байранд жижиг, дунд бизнес эрхлэхэд хэцүү юм билээ. Цар тахлын үед уналт ямар байдаг вэ гэдгийг мэдэж авсан. Хэрэв бид үйл ажиллагаагаа жигдрүүлээд явбал одоо манайд цагаар ажиллаж байгаа хүмүүсээс маань үндсэн болоод ажиллах боломжтой. Тоног төхөөрөмжийн тухайд жижиг хэрэгслүүдээ бүрдүүлсэн. Одоо материалын нөөцөө бүрдүүлж байна. Манайх дамжлагаар явдаг учраас тогтмол ажиллах 10 ажлын байр хэрэгтэй. ▶

-Танайхыг хаягдалгүй ногоон бизнес гэж үзэж болох юм байна. Банкууд ногоон санхүүжилт гаргах хүсэл сонирхолтой болсон. Танайд ногоон зээл хэр олдох бол?

Бизнесээ эхлүүлээд гоё, гоё нэртэй зээлүүд олон байдгийг мэдэж авсан. Хийж байгаа зүйлээ үзүүлээд дэмжлэг хүсэхээр заавал барьцаа шаарддаг нь үнэхээр хүндрэлтэй. Заавал үл хөдлөх хөрөнгө барьцаалахгүйгээр орлогын баталгаат мэдүүлэг, хамтарч ажилладаг байгууллагуудын гэрээ, тодорхойлолтоо өгье гэхээр хүлээн зөвшөөрдөггүй. Миний бодлоор үйлдвэрлэгчийн хамтын ажиллагааны гэрээг нь үндэслэн барьцаалж итгэлцлийн зээл олгодог болмоор байгаа юм. Бизнесээ өргөжүүлэх гэж байгаа учраас муу зээлийн түүхтэй болохыг хэн ч хүсэхгүй.

Ногоон зээлийн тухайд бол сэргээгдэх эрчим хүч, дулааны алдагдалгүй гэр, орон сууц барих чиглэлд түлхүү олгодог гэж ойлгосон. Манай компанийн тухайд хаягдал цаас ашиглаж сав баглаа боодол хийдэг учраас ногоон санхүүжилт олддог бол хамрагдах боломжтой л байх. Гэхдээ бид нар шиг хүмүүсээс хол зээл байх.

-Танайх шиг сониноор сүлжмэл сагс үйлдвэрлэдэг хүн цөөнгүй байдаг юм билээ. Цаашид ч нэмэгдэх байх. Өрсөлдөгчдөө хэрхэн харж байна. Үйл ажиллагаагаа яаж тэлэх вэ?

Мэдээж нэг салбарт ижил төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг өрсөлдөгчид бий. Өрсөлдөөнд ялагдахгүйн тулд байнгын судалгаа хийдэг. Бүтээгдэхүүний чанараараа ялгарах стратегитэй ажилладаг. Дотоодын болон импортын бараатай бүтээгдэхүүнийхээ чанарыг харьцуулдаг. Манай бүтээгдэхүүн чанартай байдаг учраас байнгын үнэнч

үйлчүүлэгчтэй болсон гэж боддог. Мэдээж бат бөх чанартай хийх нууц технологи бий. Харин загварын тухайд захиалагчид өөрийн хүссэнээрээ захиалж болно.

Миний хувьд манайтай ижил төрлийн гар урлал хийдэг хүмүүсийг өрсөлдөгч гэж харахаасаа илүү хамтарч нэгдэж, кластераар хөгжүүлэх юмсан гэсэн бодол байдаг. Сүүлийн үед салбарын кластерууд нэлээд хөгжиж байгаа шүү дээ.

-Азийн сан таны бизнес болоод хувь хүний хөгжил дэвшилд чухал нөлөө үзүүлсэн гэж болох нь ээ?

Тус сангийн “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төв” төсөл апплкейшнтай болсон. Тэнд хичээл, сургалт, зөвлөгөө гээд бидэнд хэрэгтэй мэдээллүүд байдаг. Миний хувьд Азийн сангийн анхны 10 менторын нэг. Саяхан “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төв” төслийн 3, 4 дэх үеийн менторууд нийлж хамгийн анхны хоршоог байгуулсан. Бид хоршоогоороо дамжуулан бусад эмэгтэйчүүдийг чадавхжуулах сургалтуудыг тогтмол явуулдаг.

-Ментор юм чинь гарааны бизнес эрхэлж байгаа эмэгтэйчүүдэд нэг зөвлөгөө өгөөч?

Аливаа ажил хийхэд шантралгүй тууштай байж, эрэл хайгуул сайн хийх хэрэгтэй гэж бичил, жижиг дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүддээ хэлмээр байна.

Энэ дашрамд хэлэхэд, бизнесийнхнийг том жижгээс үл хамааран холбох гүүр байдаггүй. Хэрэв бид харилцан уялдаатай нэг нэгээсээ суралцаж хамтарч ажиллавал илүү ихийг бүтээнэ гэж боддог. Ялангуяа үйлдвэрлэлийн салбарт томчууддаа бэлтгэн нийлүүлэгч хийгээд сууж байх боломж бий. ■



Нутгийн брэнд болгон хөгжүүлсэн бизнестэй болохыг их хүсдэг

“Манай зүүн аймгийн малчдын орой бэлтгэсэн зөөхий, цөцгий өглөө нь хотын хэрэглэгчдэд очдог байвал гоё уу. Бас болоогүй ээ, дээр нь тусгай технологиор барьдаг буриад талхтай таны гарт хүрнэ гээд бод доо. Гэхдээ ганц хүн үүнийг хийхгүй юм билээ” хэмээн Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын малчин эмэгтэй Д.Мөнгөнхун ярьж байлаа.

Өрх толгойлсон эмэгтэй тэрбээр бэлчээр нутгаа гаднынхнаас хамгаалах, хоёр хүүхдийнхээ хичээлд нь бүрэн анхаарахын тулд сумын төвдөө өвөлждөг байна.

Ганц хүний өрхийн орлоготой түүний хувьд сумын төвд зүгээр суух эрхгүй. Тиймээс ямар бизнес эхлүүлэхээ хэдэн жилийн өмнөөс бодож, зээл хүртэл судалж амжжээ. Ингээд түүнтэй цөөн хором ярилцлаа.

-Өрх толгойлсон малчин эмэгтэй хүний хувьд сумын төвд амьдрах хугацаандаа хэрхэн орлого олдог вэ?

Зүгээр суух боломжгүй тул янз бүрийн л зүйл хийх гэж оролддог. Юмны үнэ тэнгэрт хадаж байгаа үед малчин хүн сумын төвд амьдрах амаргүй. Гэхдээ одоо яах вэ дээ. Би хоёр хүүхдийнхээ боловсролын төлөө зүтгэнэ гэж боддог. Зүтгэж ч байгаа.

Уг нь гурилнаас бусдыг өөрийн гараар үйлдвэрлэж байгаа малчдын хувьд ядуу амьдрах эрхгүй. Гагцхүү гар дээр байгаа зүйлээ худалдан борлуулах, бизнес болгох хэрэгтэй байгаа юм. Хот суурин газрын хүмүүс ихэнхдээ бизнес хийхээрээ хүний нүд хуурсан зүйл хийчих гээд байдаг. Малчид хотноосоо үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнээ брэнд болгож хөгжүүлэхдээ хамгийн үнэнчээр цэвэр, чанартай бүтээгдэхүүн гаргах боломжтой. Малчдын зүрх сэтгэлд хуурамч зүйл хүнд өгөөд өнөөдөр л ашиг олж байвал бусад нь яах вэ гэхгүй шүү дээ. Гагцхүү борлуулалтын найдвартай суваг л хэрэгтэй.

-Зун, намартаа малынхаа түүхий эдийг зараад орлого болох боломж хэр байх вэ, малчдад?

Малчин хүний хувьд зарлагагүйгээр



хийх боломжтой ганц зүйл нь сүү цагаан идээгээ боловсруулж, борлуулах. Гэтэл мөнгө хэрэг болоод сүү тараг, өрөм зөөхийгөө шинээр нь борлуулах гээд сумын төв оруулаад ирэхэд авдаг хүнгүй. Дэлгүүр хоршоонд тавиулъя гэхээр мөнгийг нь бэлэн гаргаад өгөх боломжгүй. Ингээд л малчид гарын доорх зүйлээрээ орлого олох гэхээр санаснаар болдоггүй. Уг нь бол манайх тусгай технологиор хийдэг буриад талхаараа алдартай. Би сумын төв, хөдөөг хослуулж амьдардаг хүний хувьд чадах шинэ хүнсээ зөвхөн сумандаа биш хот суурин газар руу өдөрт нь аваачиж борлуулдаг болчихвол зүгээр байгаа юм. Түүнээс би малчин гээд уулын мухар сахиад суухгүй шүү дээ.

-Хөдөө ямар нэгэн аж ахуй эхэлье гэж бодоход хүндрэл бэрхшээл хэр байх вэ?

Ямар нэгэн зүйл хийх санаатай судалгаа хийж үзсэн. Бизнес эхлэхэд эхний ээлжинд тоног төхрөөмж худалдан авах, ажлын байрны түрээсийн төлбөр, дор хаяж гурван сарын цалингийн нөөцтэй байх хэрэгтэй болдог. Энэ бүхнийг тооцоод үзэхээр гарааны хөрөнгө оруулалт зайлшгүй хэрэгтэй болдог. Тэрийг хаанаас олох вэ гэдэг том асуултын тэмдэг. Суманд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх бол ингэж тэгж дэмжлэг үзүүлнэ гэсэн сайхан мэдээллүүд зурагтаар явдаг ч яг дэмжлэг авах гээд бизнес төслөө бариад явахаар ямар ч зээл олддоггүй. Хөдөө хүлэмжийн аж ахуй эрхэлбэл дэмжинэ гэхээр нь хүлэмжийн аж ахуй хөгжүүлэх хөнгөлөлттэй зээлд хамрагдчих санаатай хөөцөлдөөд дөрөв, таван жил болж байх жишээтэй. Тэр хөдөө орон нутгийнхны үйлдвэрлэлийг дэмжих зориулалттай зээл нь хаана явдаг юм бүү мэд. Уг нь жаахан дэмжлэг байдаг бол хийх хүсэлтэй хүн олон бий. Би гэхэд амьдрахын тулд малынхаа хажуугаар сумын төвд ногоо тариалдаг. Сум орон нутгаас хэн ч өрхийн үйлдвэрлэл хийх

Тэр хөдөө орон нутгийнхны үйлдвэрлэлийг дэмжих зориулалттай зээл нь хаана явдаг юм бүү мэд.

хүсэл сонирхолтой, төсөлтэй байна гээд судлаад, уулзаад явдаггүй. Бид өөрсдөө хөөцөлдөөд явахаар орон нутагт төрийн байгууллагын хүнд суртал дэндүү их. Шинэ юм хийе гэсэн хүнд тэр дарга нарын ярьдаг зээлийн дэмжлэг нь их хол юм билээ. Суманд нэг бичигт гарын үсэг зуруулах гэж долоо хонох нь энүүхэнд. Уг нь бол хөдөөгийн иргэдээ сум орон нутагт нь хүссэнээ хийгээд сайхан амьдрах нөхцөлийг нь бүрдүүлвэл хотоос хүмүүс хөдөөг зорих хүсэлтэй болно шүү дээ. Тэгэхгүй сум орон нутагт бизнес хийж өрхийн орлогоо нэмэгдүүлэх ямар ч боломж нөхцөлгүй байхад хэн хотоос хөдөөг зорих юм.

-Малчин хүмүүсийн хувьд малынхаа ашиг шимийг бүрэн боловсруулж үр өгөөжийг нь хүртэж амьдрахын тулд юу хиймээр санагддаг вэ?

Бидний хувьд зардалгүй хийх ганц арга бол цагаан идээгээ борлуулах. Гэхдээ миний хувьд ганцхан хатсан ааруул зараад суух хангалтгүй санагддаг. Хүмүүс органик эко хэрэглээ рүү хошуурах болсон цагт малчин эмэгтэйчүүд бид сүү цагаагаа олон янзаар үйлдвэрлээд шинэ хүнс хотын иргэдэд шинээр нь хүргэдэг баймаар байна. Үүний тулд ганц нэгхэн өрхийн сүү цагаан идээ шальтай бүтээгдэхүүн болохгүй л дээ. Хэдэн гэрээрээ нэгдэж хоршиж

малын гаралтай бүтээгдэхүүнээ борлуулах, үйлдвэрлэл эрхлэх талаар сонирхоод, ярилцаад л байгаа. Малчид малынхаа ашиг шимийг хүртэж амьдрахын тулд санаа сэтгэл нийлсэн хүмүүс хоршиж илүү хөдөлмөрлөх л хэрэгтэй. Тэрийг нь төр засгийн байгууллага нь эсвэл арилжааны банкууд нь дэмжиж хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл гаргадаг бол малчид хөдлөх боломжтой. Банкууд ногоон зээл гаргана гэдэг. Тэгвэл жинхэнэ ногоон үйлдвэрлэлийг малчид л хийж чадна. Ногоон үйлдвэрлэл хөдөөд бий. Хөдөө их нөөц байна шүү дээ. Залуу малчдын хувьд орчин цагт зүгээр нэг мал дагаад амьдрах нь хангалтгүй. Үйлдвэрлэл эрхлэх хүсэл сонирхол маш их байдаг.

-Танд бизнзесийн ямар санаа байгаа вэ?

Нутгийн брэнд л хөгжүүлэх бизнес хиймээр санагддаг. Судлаад л байгаа. Шинэ зөөхий цөцгийгөөр хот суурин газрын хүмүүсийг хангамаар байна. Миний хувьд зөвхөн цагаан идээ зарах биш, нэмэлт буриад талхаа хүртэл хийгээд худалдмаар санагддаг. Буриад талх гэхэд л нарийн технологитой эд шүү дээ. Зөвхөн энэ нутгийн зон олны хийж чаддаг алдартай брэнд. Энэ брэндээ илүү олон хүнд хүргэмээр байна шүү дээ. Хотынхонд бол жинхэнэ эрүүл эко талх хүрнэ гэсэн үг.

Би хувийн машинаараа цагаан идээний хүргэлт сумандаа хийж үзсэн. Бэлэн бүтээгдэхүүн аваад очихоор авах, авахгүй гээд янз бүр байдаг. Уг нь бол малчид хөдөөнөөс бүтээгдэхүүнээ оруулж ирээд нэгдсэн том дэлгүүрт нийлүүлчихээд л мөнгөө аваад буцдаг болмоор байгаа. Тийм худалдааны сувгууд орон нутагт бий болговол малчид бүтээгдэхүүнээ дуртай нийлүүлнэ. Малынхаа сүү саалийг ч ахиу авахыг боддог болно. Хотынхон шинэ хүнс хэрэглэх тал дээр дэлгүүрийн лангуунд найдахгүйгээр малчин бидний гараас эрүүл, шинэ хүнс авах боломжтой. Хөдөөд малчдын



орлого, үйлдвэрлэлийг дэмжсэн ямар ч бодлого байхгүй хэрнээ мах, сүүгээ үнэтэй зарлаа, юм хийхгүй залхуу байна гээд шүүмжэх нь их. Гэтэл малчид бодохгүй биш янз бүрийн юм хийчих юмсан гээд бодоод л явдаг.

-Банкны зээл аваад бизнесээ хийх болвол барьцааны асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ?

Барьцаанд тавих үл хөдлөн хөрөнгө байхгүй шүү дээ. Малчдын өвөлжөө, хаваржааны газар нь ч өмчлөгдөөгүй байдаг. Хэдэн мал л байна. Уг нь бол барилга барьдаг компаниуд хөдөө орон унтагт бүр суманд очоод тохилог орон сууц

гарна. Орчин үед малчин удмаа залгаж авсан малчид бол боловсрол мэдлэг сайтай, бизнесийн ухаантай их өөр болсон. Малчид харанхуй гэж хүмүүс боддог. Тийм биш. Яг мал аж ахуйг уламжилж хөгжүүлж яваа залуус дотор орчин цагийн технологийн ололт дэвшлийг ашиглах тал дээр мундаг болсон. Эрэгтэй, эмэгтэй ялгаагүй хөдөөд ажил хөдөлмөр, бизнес эрхлээд өрхийн орлогоо нэмэгдүүлэх тэр нөхцөлийг нь өөрөө бүрдүүлэх шаардлага бий.

-Хүнсний хувьсгалын хүрээнд сум орон нутгийн брэндийг хөгжүүлэх асуудал тусгагдсан байсан. Та бүхэн мэдээлэл сайн аваад, сум орон нутгийнхаа тухайн асуудал хариуцсан албаны хүмүүст хандах хэрэгтэй дээ.

Тийм боломж байдаг бол хүслээ гүйцээж хөдөлмөрлөмөөр байна. Хөдөө орон нутагт төрийн албаны хүнд суртал маш их. Ялангуяа ихэнх цагаа малтай хөөцөлдөж өнгөрөөдөг бидэнд мэдээлэл дутмаг байдаг. Малчдынхаа ахуй амьдралыг сайжруулахын төлөө төр засаг, хувийн хэвшил нь ч боддог. Малчид өөрсдөө хүсэл тэмүүлэлтэй байхад бид гаднын тэр өндөр хөгжилтэй орны малчид фермерүүд шиг байгаа газраа ая тухтай амьдарч болно.

Малчдыг малнаас нь салгаж үйлдвэрлэгч, бизнесмэн гэж харах цаг болсон. Мэдээж бид таван эрдэнэ мал сүргээсээ холдохгүй, тэрнийхээ буян хишгийг хүртэж л амьдарна. Гэхдээ өнөөдрийнх шиг биш, илүү үнэ цэнтэй амьдармаар байна. ■

Орчин үеийн яг малчин удмаа залгаж авсан малчид бол боловсрол мэдлэг сайтай, бизнесийн ухаантай их өөр болсон. Малчид харанхуй гэж хүмүүс боддог. Тийм биш.

баривал би гэхэд яаж ийгээд авна. Хоёр охин хүүхэдтэй ээж хүний хувьд хэдий хөдөө ч гэсэн ая тухтай, аюулгүй орчинд амьдруулахын төлөө явна. Одоо над шиг мал хар руугаа байнга явдаг хүний хувьд сумын төвд монгол гэрт хүүхдээ эзэнгүй үлдээгээд явахад хэцүү. Энэ мэтээр хөдөөд ая тухтай орчин бүрдүүлэх шаардлага бий. Малчид гэхээрээ яагаад заавал дуугүй гэртээ насаараа амьдрах ёстой гэж. Орчин үед малчид хотынхноос дутуугүй орчин нөхцөлд амьдарч болно. Банк малчдын юу хийх хүсэлтэй, ямар төсөлтэй байгаа тэр төслийг нь барьцаалаад ч юм уу итгэлцлийн зээл өгдөг бол их зүгээр байгаа юм. Тэгвэл малчдаас сайн санаа санаачилга